ОНЦГОЙ БАЙДЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

ОНЦГОЙ БАЙДЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

ГАМШГААС ХАМГААЛАХ
ЦАГААН НОМ 2023

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

ГАМШГААС ХАМГААЛАХ **ЦАГААН НОМ 2023**

Гамшиг судлалын үндэсний хүрээлэнд номын эхийн боловсруулалтыг хийж, Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын Олон нийттэй харилцах хэлтэс хэвлэлийн эхийг бэлтгэв.

Ерөнхий редактор:
Бригадын генерал Б.Ууганбаяр
Хурандаа Ж.Амгалан (Ph.D)

Хянан тохиолдуулсан:
Дэд хурандаа П.Чимэдцэрэн (Ph.D)

Боловсруулсан:
ГАМШИГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
Дэд хурандаа С.Байгалмаа
Ахмад Э.Оюунгэрэл (Ph.D)
Хошууч Ж.Энхтуяа
Ахмад Б.Амаржаргал
Дэслэгч Б.Лхагвасүрэн
Дэслэгч С.Энхтунгалаг
Ахлах дэслэгч Ц.Одбаяр

Хэвлэлийн эх бэлтгэсэн:
Ахмад Б.Отгон

Улаанбаатар хот. 2024 он
Онцгой байдлын ерөнхий газар

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ 10
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ 12
БҮЛЭГ 1.1. ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРХЗҮЙН ШИНЭЧЛЭЛ 13
1.1.1. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлуулсан баримт бичиг 13
1.1.2. Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батлагдсан баримт бичиг 13
1.1.3. Онцгой байдлын ерөнхийн газрын даргын тушаалаар батлагдсан баримт бичиг 16
БҮЛЭГ 1.2. ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ 21
1.2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилт: 24
БҮЛЭГ 1.3. ГАМШГААС ХАМГААЛАХ ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА 25
1.3.1. Гадаад хамтын ажиллагаа, айлчлал 25
1.3.2. Онцгой байдлын байгууллагад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр 28
БҮЛЭГ 1.4 ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХ 31
1.4.1. Онцгой байдлын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын бэхжилт 31
1.4.2. Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн талаар 33
1.4.3. Техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл,багаж хэрэгслийн хангалт 41
1.4.4. Тэмцээн уралдаан, бусад арга хэмжээний талаар 44
1.5.5 Алба хаагчдын нийгмийн баталгаа, эрүүл мэнд хамгаалал 49
БҮЛЭГ 1.5. ГАМШГААС ХАМГААЛАХ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИ 51
1.5.1. Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологи, эрдэм шинжилгээний зөвлөл, багийн үйл ажиллагаа 51
1.5.2. Эрдэм шинжилгээ, судалгаа, иновацийн үйл ажиллагаа 53
1.5.3. Эрдэм шинжилгээний болон онол практикийн хурал 58
ХОЁРДУГААР ХЭСЭГ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ 62
БҮЛЭГ 2.1 ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 63
2.1.1 Урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт 63
2.1.2. Олон нийтэд зориулсан гамшгаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ 63
2.1.2. Гамшгаас хамгаалах сургалт 67
2.1.3. Гамшгаас урьдчилан сэргийлэх хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа 72
БҮЛЭГ.2.2 ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 76
2.2.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал 76
2.2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа 78
2.2.3. “Эрсдэл ба Стандарт” үндэсний форум 79
2.2.4 Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх хүний нөөцийн чадавх 81

ГУРАВДУГААР ХЭСЭГ. ГАМШГИЙН ҮЕИЙН ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ 84
БҮЛЭГ 3.1. ГАМШГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ
/СТАТИСТИК МЭДЭЭ, ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГАА/ 85
3.1.1. Монгол оронд тохиолдсон аюулт үзэгдэл,ослын тойм 85
3.1.2. 2023 оны уур амьсгалын жилийн тойм 90
3.1.3. Эрэн хайх, аврах ажиллагаа 95
3.1.4 Хариу арга хэмжээ 98
БҮЛЭГ 3.2 ГАЛ ТҮЙМРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ 105

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ХОР УРШГИЙГ АРИЛГАХ, СЭРГЭЭН БОСГОХ АЖИЛЛАГАА 110
БҮЛЭГ 4.1. УЛСЫН НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА 111
БҮЛЭГ 4.2. ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ 112
БҮЛЭГ 4.3 МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙН НИЙГЭМЛЭГЭЭС ЗАРЦУУЛСАН ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ 114
БҮЛЭГ 4.4. УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА 115

ТАВДУГААР ХЭСЭГ. 2023 ОНЫ ОНЦЛОХ НӨХЦӨЛ БАЙДАЛ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ 120
БҮЛЭГ 5.1. УЛААНБААТАР ХОТЫН ҮЕРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ 121
5.1.1 Нийслэл Улаанбаатар хотод тохиолдсон үерийн нөхцөл байдал, ... 121
/2023 оны 7 дугаар сар/
5.1.2 Нийслэл Улаанбаатар хотод тохиолдсон үерийн нөхцөл байдал, ... 134
/2023 оны 8 дугаар сар/
БҮЛЭГ 5.2. СТРАТЕГИЙН КОМАНД ШТАБЫН СУРГУУЛЬ 138
5.2.1. Удирдлагын баримт бичиг боловсруулалт 138
5.2.2 Бэлтгэл ажил 139
5.2.3 Сургуулийн удирдлага зохион байгуулалт 141
5.2.4 Дүгнэлт 145
5.2.5 Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал. 146
5.2.6 Стратегийн команд штабын сургуулийн зургийн сан. 148
БҮЛЭГ 5.3. БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН ХАТАЙ ХОТ ДАХЬ
ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГАА 150
5.3.1 Үүссэн нөхцөл байдал 150
5.3.2. Эрэн хайх аврах бүлэг, Эмнэлгийн бүлгийн үүрэг 151
5.3.3 Туршлага, сургамж 153
5.3.4 Туркийн газар хөдлөлтийн үеийн эрэн хайх, аврах ажиллагааны зургийн сан 155

ХАВСРАЛТ 156

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. БНХАУ-д хийсэн айлчлал, 2023-10 25
Зураг 2. Монгол-Оросын хамтарсан хуралдаан 26
Зураг 3. Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийг хэлэлцэх өндөр түвшний уулзалт 26
Зураг 4. Монгол, Хятадын хил орчмын нутаг дэвсгэрийн ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын зөвөлгөөн 26
Зураг 5. EC-145 нисдэг тэрэг 28
Зураг 6. Сургалтын дадлагажуур 28
Зураг 7. Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалт 29
Зураг 8. Эрэн хайх, аврах дунд түвшний багийн дадлага сургуулилт 30
Зураг 9. Онцгой байдлын байгууллагын бүтэц зохион байгуулалтын бэхжилт 31
Зураг 10. Гал түймэр унтраах, аврах бүлгүүдийн нээлтийн үйл ажиллагаа 32
Зураг 11. Чанарын итгэмжлэлиийн гэрчилгээ, 2023 32
Зураг 12. Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн сургалт, бэлтгэл 33
Зураг 13. Мэргэшүүлэх давтан сургах хөтөлбөр 33
Зураг 14. Үйлчилгээний гавьяат ажилтан Бригадын генерал Батмөнхийн Ууганбаяр 34
Зураг 15. Энэ онд Онцгой байдлын байгууллагаас 1 дэд профессор, 1 доктор төрөн гарсан байна. 34
Зураг 16. Онцгой байдлын байгууллагын залуу офицерийн чуулга уулзалт 35
Зураг 17. Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Хар зүрхний хөх нуурт зохион байгуулагдсан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицеруудын чуулган 36
Зураг 18. Шилдэг залуу офицер шалгаруулах анхдугаар тэмцээний шилдгүүд 37
Зураг 19.“Тикийн гайхамшиг” Туршлага солилцох, хамтарсан дадлага, сургууль 38
Зураг 20. “Далд уурхайн эрэн хайх, аврах ажиллагаа”-ны хамтарсан сургалт: 38
Зураг 21. “Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагаа”-ны хамтарсан сургалт 39
Зураг 22.“Урсгал болон тогтмол уснаас эрэн хайх, аврах ажиллагаа”-ны хамтарсан сургалт 39
Зураг 23. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын цэргийн биеийн тамирын бэлтгэл сургалт 41
Зураг 24. Техник тоног төхөөрөмж, хувцас хэрэгслийн хангалт 42
Зураг 25. Тусгай зориулалтын хувцсыг туршин, үйлдвэрлэсэн байдал 42
Зураг 26. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн бүтээн байгуулалт 43
Зураг 27. Онцгой байдлын газар, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн шинэ байрны нээлтийн ажиллагаа 44
Зураг 28. Шилдэг бүтээлийн шагнал гардуулах ажиллагаа 45
Зураг 29. доктор, дэд хурандаа Б.Саранцэцэг 45
Зураг 30. БНТУ Истанбул хот Дэлхийн аварга 46
Зураг 31. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын уралдаан, тэмцээний амжилтууд 47

Зураг 32. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын тэмцээн, уралдааны амжилтууд 47
Зураг 33. Гандуулга 48
Зураг 34. Алба хаагчдын нийгмийн баталгаа 49
Зураг 35. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг 50
Зураг 36. Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хуралдаан 51
Зураг 37. Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл 52
Зураг 38. Гамшиг судлалын хүрээлэнгийн 2005-2023 онд гүйцэтгэсэн судалгааны ажил 53
Зураг 39. Үнэлгээ шинжилгээний тайлан 54
Зураг 40. Байршлыг илэрхийлэх what3words аппликейшинг гар утсанд суулгах заавар 55
Зураг 41 .Эрсдэлийг бууруулах Сэрэмжлүүлэг самбар 56
Зураг 42. Өвөлжөө төсөл 57
Зураг 43. 2006-2023 онд Галын лабораторид ирүүлсэн материалын галын аюулын үзүүлэлтийг тодорхойлуулах хүсэлт болон шинжилгээ хийсэн бүтээгдэхүүний тоо 57
Зураг 44. Уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн байдал эртнээс сэрэмжлүүлэх үндэсний бодлого: Асуудал, шийдэл, гарц" сэдэвт эрдэм шинжилгээний хурал 58
Зураг 45. "Гамшгаас хамгаалах сургалтын өнөөгийн байдал, хүртээмж, үр нөлөө" сэдэвт онол, практикийн бага хурал 59
Зураг 46. Эрдэм шинжилгээний бага хурал 61
Зураг 47. Эрсдэлд суурилсан тогтвортой хөгжил" олон улсын эрдэм шинжилгээний хурал 61
Зураг 48. Удирдамжийн мэдээлэл 63
Зураг 49. Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний үзүүлэлт 64
Зураг 50. Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний үзүүлэлт 65
Зураг 51. "Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ"-ний үзүүлэлт 66
Зураг 52. Ангиллын сургалт 67
Зураг 53. Тоон үзүүлэлт 67
Зураг 54... "Өсвөрийн аврагч-2023" 68
Зураг 55. Ослын удирдлагын тогтолцоо, сургалт 69
Зураг 56. Дорнод аймаг гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль 70
Зураг 57. Ховд аймагт 10 дугаар сарын 23-30-ны өдрүүдэд Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг зохион байгуулсан. 71
Зураг 58. belenbai.mn сайтын сайжруулалт 72
Зураг 59. Дэвшилтэт технологи 73
Зураг 60. "Нематаймс" булан 73
Зураг 61. Цаг үеийн асуудлаар зохион байгуулсан хэвлэлийн бага хурал. 74
Зураг 62. Онцгой байдлын цаг" нэвтрүүлэг 74
Зураг 63. Онцгой мэдээ сонин. 75

Зураг 64. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгосон байдал /чиглэл тус бүрээр давхардсан тоогоор/ 75
Зураг 65. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо 78
Зураг 66. "Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт" сургалтад оролцогчид, БНСУ-ын Инчеон хот 81
Зураг 67. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэшүүлэх сургалт 82
Зураг 68. 2023 онд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын эзлэх хувь /гамшгийн төрлөөр/ 85
Зураг 69. 2023 онд аюулт үзэгдэл, ослын улмаас учирсан хохирлын эзлэх хувь, гамшгийн төрлөөр 86
Зураг 70. 2023 онд аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний эзлэх хувь /гамшгийн төрлөөр/ 86
Зураг 71. Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо, учирсан хохирлын хэмжээг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт 88
Зураг 72. Аварсан хүний тоо, 2021-2023 88
Зураг 73. Аварсан эд хөрөнгө, 2021-202376 88
Зураг 74. Гэмтэж бэртсэн хүний тоо, 2021-2023 88
Зураг 75. Нас барсан хүний тоо, 2021-2023 88
Зураг 76. 2022-2023 онд аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүн /аймаг нийслэлээр/ 89
Зураг 77. 2023 онд аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүн 100000 хүн амд харьцуулсан байдлаар /аймаг нийслэлээр/ 89
Зураг 78. Аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүний тоо, 2021-2023 89
Зураг 79. 2023 оны жилийн дундаж агаарын температурын орон зайн тархалт 90
Зураг 80. 2023 оны улирлын агаарын дундаж температурын ОЖД-аас(норм 1991-2020 он) хазайх хазайлт 91
Зураг 82. 2023 оны жилийн нийлбэр хур тунадасны орон зайн тархалт 91
Зураг 83. 2023 оны улирлын нийлбэр хур тунадасны ОЖД-аас (норм 1991-2020 он) хазайх хазайлт 92
Зураг 85. Тус жилд ажиглагдсан экстремаль утгууд 93
Зураг 86. 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар цасны зузаан (см) 94
Зураг 87. Эрэн хайх, аврах ажиллагаа, Дундговь аймаг 95
Зураг 88. Аймгуудын Шуурхай Штабын үйл ажиллагаа 97
Зураг 89. Улаанбаатар хотод тархсан хийн голомтын эх үүсвэрийг явуулын лабораториор илрүүлж буй байдал 98
Зураг 90. Шүлхий өвчний гаралт 2023.01-12-р сар. ДМАЭМБ-ын мэдээлэл 99
Зураг 91. Дархлаажуулалтын төлөвлөгөө 2023. 100
Зураг 92. Бог малын мялзан гаралт 2023 он. Эх сурваж. ДМАЭМБ-ын албан ёсны сайт 101
Зураг 93. Бог малын мялзан өвчний дэгдэлт, 2023 101
Зураг 94. Дархлаажуулалтын аян, 2023 102
Зураг 95. Дархлаажуулалтын арга хэмжээний төлөвлөлт, 2023 102
Зураг 96. Үхрийн арьс товруутах өвчний гаралт 2023.01-12-р сар. ДМАЭМБ-ын мэдээлэл 103

Зураг 97. Хонины цэцэг өвчний гаралт 2023.01-12-р сар. ДМАЭМБ-ын мэдээлэл 104
Зураг 98. Хонины цэцэг гаралт 2022.06 105
Зураг 99. Хонины цэцэг гаралт 2023.01 105
Зураг 100. Ой хээрийн түймрийн тархалт 106
Зураг 101. Ажилласан хүч хэрэгсэл 106
Зураг 102. Түймрээс учирсан хохирол 107
Зураг 103. Улаанбаатар гурил үйлдвэрийн агуулахын барилгад гарсан галыг унтрааж буй байдал 108
Зураг 104. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын "Хадын булаг" багийн "Уртын цагаан"-д гарсан ой хээрийн түймэр 109
Зураг 105. Монгол Улсын Засгийн газраас олгосон хүмүүнлэгийн тусламжийг хүлээлгэн өгөх үйл ажиллагаа 113
Зураг 106. Улсын Онцгой комиссын өвөлжилтийн нөхцөл байдлын талаархи 2023 оны 11 сарын 28-ны өдрийн хуралдаан 115
Зураг 107. Үерийн усанд өртсөн 93 байрны байршил /тод болон бүдэг цэнхэр өнгөөр тэмдэглэсэн/ 112
Зураг 108. 7 дугаар сарын 5-ны үерийн нөхцөл байдал 123
Зураг 109. Зураг Үерийн үеийн хүндэрсэн нөхцөл байдлын зураг 123
Зураг 110. Үерийн усанд хүндрэх эрсдэлтэй байршил /7 дугаар сарын 05-ны байдал/ 124
Зураг 111. Үерийн усанд хүндрэх эрсдэлтэй байршил /7 дугаар сарын 05-ны байдал/ 124
Зураг 112. 7 дугаар сарын 5, 6-ны өдрүүдэд үерт өртсөн болон үерийн эрсдэлтэй байршлууд 125
Зураг 113. Үерийн нөхцөл байдал, хэрэгжүүлсэн арга хэмжээний зураг 131
Зураг 114. Баянзүрх дүүргийн 21, 27, 29 дүгээр хорооны үерийн зураг 136
Зураг 115. БНТУ-ын газар хөдлөлтийн гамшгийн үед Монгол Улсаас эрэн хайх, аврах ажиллагаанд оролцсон аврах баг 155

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 24
Хүснэгт 2. Өрхийн газар хөдлөлтөд өртөх байдал /аймгаар/ 76
Хүснэгт 3 Аюулт үзэгдэл, ослын тоо /2022,2023 он/ 85
Хүснэгт 4. Шүлхий өвчний гаралт 2022-2023 он. 100
Хүснэгт 5. Үерт автсан томоохон байршлууд 122
Хүснэгт 6. 2023 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 16 цагийн байдлаарх Зарлагын тооцоо 130
Хүснэгт 7. Эдэлбэрийн хэлбэрээр ангилсан байдал: 130
Хүснэгт 8. Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжийн төрлөөр ангилсан байдал: 130
Хүснэгт 9. Сэлбэ голын үерийн хамгаалалтын 30 метр радиус доторх баригдсан барилга, байгууламж 131
Хүснэгт 10. Нийслэл Улаанбаатар хотод тохиолдсон үерийн нөхцөл байдал 135

МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛСЭН ЭХ СУРВАЛЖ

Цагаан номын бүтэц	Мэдээлэл ирүүлсэн газар, харьяа байгууллага
1-р хэсэг. Гамшгаас хамгаалах удирдлага	
Бүлэг 1.1. Гамшгаас хамгаалах эрхзүйн шинэчлэл	БТГ, ЭУГ, ГТТГ
Бүлэг 1.2. Гамшгаас хамгаалах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт	БТГ, УСГ, ГТТГ, САТГ
Бүлэг 1.3. Гамшгаас хамгаалах олон талт хамтын ажиллагаа	БТГ, ГТТГ, 111-р анги
Бүлэг 1.4. Онцгой байдлын байгууллагын чадавх	ЗУГ, БТГ, АУГ, ГТТГ, УНГ, САТГ, 111-р анги
Бүлэг 1.5. Гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээ, инновац	ГСҮХ, ОБСургууль, 121-р анги
2-р хэсэг. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах	
Бүлэг 2.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	УСГ, АУГ
Бүлэг 2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	ЭУГ
3-р хэсэг. Гамшгийн үеийн шуурхай удирдлага, зохицуулалт	
Бүлэг 3.1. Гамшгийн нөхцөл байдал /статистик мэдээ, эрэн хайх, аврах ажиллагаа/	АУГ, ГТТГ, ШУЗМТ, ҮАБ
Бүлэг 3.2. Гал түймрийн нөхцөл байдал	ГТТГ
4-р хэсэг. Хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаа	
Бүлэг 4.1. Улсын нөөц хүмүүнлэгийн тусламж	УНГ, САТГ,
Бүлэг 4.2. Улсын онцгой комиссын үйл ажиллагаа	УОК-ын ажлын алба
5-р хэсэг.	
5.1. Улаанбаатар хотын үерийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ	
Бүлэг 5.1.1. Удирдлага, зохион байгуулалт	Дэд хурандаа П.Чимэдцэрэн Хошууч Ж.Энхтуяа
Бүлэг 5.1.2. Үүссэн нөхцөл байдал	
Бүлэг 5.1.3. Учирсан хохирол, хэрэгцээ	
Бүлэг 5.1.4. Туршлага, сургамж	
5.2. Гамшгаас хамгаалах стратегийн команд штабын сургууль	
Бүлэг 5.2.1. Удирдлага, зохион байгуулалт	УСГ
Бүлэг 5.2.2. Дадлага, сургуулилтын явцад гарсан хүндрэл бэрхшээл, цаашид сайжруулах санал, дүгнэлт	
5.3 БНТУ-д тохиолдсон газар хөдлөлтийн гамшгийн үед Монгол Улсаас эрэн хайх, аврах, эмнэлэг, хүмүүнлэгийн тусламжийн үүрэг гүйцэтгэсэн хариу арга хэмжээ	
Бүлэг 5.3.1. Үүссэн нөхцөл байдал	Бригадын генерал Б.Ууганбаяр
Бүлэг 5.3.2. “Эрэн хайх бүлэг”, “Аврах бүлэг”, “Эмнэлгийн бүлэг”-ийн үүрэг	
Бүлэг 5.3.3. Туршлага, сургамж	

ӨМНӨХ ҮГ

Онцгой байдлын байгууллага нь Монгол Улсын хэмжээнд тохиолдсон гамшгийн нөхцөл байдал, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үеийн хариу арга хэмжээ, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ, түүнээс авсан сургамж, сайн туршлага, Онцгой байдлын байгууллагын чадавх зэрэг тухайн онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг нэгтгэж багтаасан "Гамшгаас хамгаалах цагаан ном"-ыг 2017 оноос жил бүр эмхэтгэн монгол, англи хэл дээр эрхлэн гаргаж ирсэн.

Энэ удаагийн Цагаан ном нь Үндэсний хэмжээнд анх удаа "Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа" сэдэвт стратегийн команд штабын сургуулилалт, 2023 оны 2 дугаар сард Бүгд Найрамдах Турк Улсад 7,8 магнитутын хүчтэй газар хөдлөлт болоход Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр илгээсэн аврах, эрэн хайх ажиллагааны багийн үйл ажиллагаа, Нийслэл Улаанбаатар хотод 2023 оны 07, 08 дугаар саруудад тохиолдсон үерийн аюултай түвшнээс 40-50 см-ээр давж, онц хүчтэй үерлэж, нөхцөл байдал хүндэрсэн үеийн хариу арга хэмжээ, туршлага сургамжийг багтааснаараа онцлог дугаар болж байна.

Энэхүү номонд 2023 онд хийгдсэн гамшгаас хамгаалах эрх зүйн орчны шинэчлэл, урьдчилан сэргийлэх болон эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, бодлого хөтөлбөрийн хэрэгжилт, гадаад дотоод хамтын ажиллагаа, онцгой

байдлын байгууллагын чадавх, улсын нөөц, хүмүүнлэгийн тусламж, гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээ, инновацын ажил, төсөв, хөрөнгө оруулалтын талаарх бодит мэдээллүүдийг тусгасан болно.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Дэлхийн III бага хурлаас 2015 онд батлан гаргасан "Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд авч хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг"- ийн дунд хугацааны Монгол Улсын 2015-2022 оны тайланг дэлхийн хэмжээнд дэвшүүлсэн 7 зорилт, тэргүүлэх 4 чиглэлийн хүрээнд гаргаж Нэгдсэн үндэсний байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газарт хүргүүлсэн бөгөөд олон улсын үнэлгээний баг энэхүү Цагаан номыг жил бүр англи, монгол хэл дээр гаргаж байгааг өндрөөр үнэлсэн (Mongolia: Voluntary National Report of the MTR SF | Midterm Review of the Sendai Framework (undrr.org)).

Та бүхэн энэхүү эмхэтгэлээс онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны талаарх 2023 оны мэдээ, мэдээллийг судалгаа шинжилгээ, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд ашиглах гарын авлага болж чадна гэдэгт итгэлтэй байна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

ГАМШГААС ХАМГААЛАХ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ

БҮЛЭГ 1.1. ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРХЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор 2023 онд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 1 дүрэм, Шадар сайдын тушаалаар 6 журам, 4 заавар, 1 удирдамж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар 2 дүрэм, 7 журам, 7 заавар, 1 төлөвлөгөө, 1 хяналтын хуудсыг тус тус боловсруулан батлуулсан байна.

1.1.1. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлуулсан баримт бичиг

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 247 дугаар тогтоолоор "Гал түймрийн улсын хяналтын дүрэм"-ийг холбогдох хууль тогтоомжийн шинэчилсэн найруулгатай уялдуулан дараах нэмэлт өөрчлөлтийг оруулав. Үүнд:

1.5-д Энэхүү дүрмийн 1.8 дахь заалтыг хэрэгжүүлэх тохиолдолд гал түймрийн улсын хяналтын байцаагчийн эрх олгох шалгалтыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулж, тэнцсэн албан тушаалтанд үнэмлэх, энгэрийн тэмдэг, баталгааны тэмдэг олгоно.

1.6-д Хяналтын байцаагч нь үйл ажиллагаандаа Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын хууль тогтоомж, техникийн зохицуулалт энэхүү дүрмийг удирдлага болгоно.

2.1.2-д Галын аюулгүй байдлын тухай, Барилгын тухай, Ойн тухай хууль, галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон техникийн зохицуулалт, норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавих.

3.1.2-д Холбогдох байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр хот, суурин газар, байгууллага, аж ахуйн нэгжийн галын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг боловсруулах, галын аюулгүй байдлын техникийн дүгнэлт гаргах зэрэг үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус мэргэжлийн бусад байгууллага, шинжээч, шинжилгээний байгууллага, эрдэм шинжилгээ, зураг төслийн байгууллагын мэргэжилтэн, иргэнийг татан оролцуулах гэж өөрчлөлт оруулсан.

3.2.5-д Хяналтын байцаагч аливаа дүгнэлт гаргахын өмнө "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг тухай бүр гаргах, ашиг сонирхлын зөрчил үүссэн бол үүссэн тухай тайлбарыг хууль тогтоомжид заасны дагуу удирдах албан тушаалтанд танилцуулан шийдвэрлүүлэх" гэж тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

1.1.2. Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батлагдсан баримт бичиг

Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан "Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн дэргэд "Шинжлэх ухаан, технологи, инновацын дэд зөвлөлийн ажиллах журам"

Гамшигт өртөх байдал, эмзэг байдлыг бууруулах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй хэрэгжүүлэх, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бий болгож буй хүчин зүйлийг дэвшилтэт технологи, инновацийн ололтыг ашиглан тандан судалж, арга хэмжээг илүү оновчтой, үр дүнтэй авч хэрэгжүүлснээр иргэдийн амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд болзошгүй гамшгийн хохирлыг бууруулах чухал ач холбогдолтой юм.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хөтөлбөрийн "Шинжлэх ухаан, технологийн байгууллагууд, академи, хувийн хэвшилтэй хамтран сайн туршлагаа харилцан солилцох, түгээн дэлгэрүүлэх хүчин чармайлтыг дэмжих" зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газар дунд хугацаанд хэрэгжүүлэх стратегийн баримт бичгийг баталж, "Гамшгийн эрсдэлийг бууруулахад эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх, дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх"-ээр төлөвлөсөн.

Монгол Улсад гамшиг, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй инноваци технологийг эрчим хүч, барилга дэд бүтэц, уул уурхай зэрэг олон чухал салбарт шинээр санаачилж нэвтрүүлдэг хэдий ч төр-хувийн хэвшил энэ чиглэлээр хамтран ажиллах боломж хязгаарлагдмал, нэгдсэн бодлого зохицуулалтын арга хэрэгсэл дутагдаж байгаагаас дээрх олон инноваци технологийн бүтээгдэхүүнийг нийтийн хүртээл болгож, хэрэглээнд нийтлэг нэвтрүүлэх нь удаашралтай байна.

Иймд Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаас гарсан зөвлөмж, чиглэлийн 5.1-д "Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн дэргэд Шинжлэх ухаан технологи, инновацийн дэд зөвлөл байгуулах" тухай заасны дагуу шинжлэх ухаан, инновацийн ололтыг нэвтрүүлж, шинжлэх ухаанд суурилсан гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хөгжүүлэх зорилго бүхий "Шинжлэх ухаан технологи, инновацийн дэд зөвлөл"-ийг байгуулахаар бүрэлдэхүүн, ажиллах журмыг боловсруулан батлуулжээ.

Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 28 дугаар тушаалаар батлагдсан "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдалд олон эх сурвалж ашиглан салбар хооронд мэдээ мэдээлэл солилцох журам", "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам", "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдлын удирдлагын тогтолцоо, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам", "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ, хариу арга хэмжээний зураглал", "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын төрлөөс хамаарсан магадлалын болон үр дагаврын түвшинг тогтоох жишиг асуумж, Нийгмийн эрүүл мэндийн

ноцтой байдлын үеийн эрсдэлийн харилцаа, холбооны удирдамж”

“Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдалд олон эх сурвалж ашиглан салбар хоорондмэдээ мэдээлэл солилцох журам”-аар нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын мэдээ, мэдээллийг салбар хоорондын байгууллага олон эх сурвалж ашиглан солилцож, шийдвэр гаргагчдыг нотолгоонд тулгуурласан мэдээллээр шуурхай хангах үйл ажиллагааг зохицуулах юм.

УОК-ын даргын 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 2 дугаар тушаалаар батлагдсан “Мал, амьтны гоц халдварт өвчний үед шалган нэвтрүүлэх цэгийн ажиллах нийтлэг заавар”

Мал, амьтны гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэмийг сахиулах үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагын харилцан ажиллагааг нарийвчлан зохицуулсан эрхзүйн баримт бичиг дутмаг байгаа тул энэхүү зааврыг шинээр боловсруулж батлуулсан.

Зааварт “Гамшгаас хамгаалах тухай”, “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хууль, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэргэжүүлэх үйл ажиллагааны журам”-ыг үндэслэн боловсруулж, шалган нэвтрүүлэх цэгийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, тавигдах шаардлагыг нарийвчлан тусгаж, уг үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэргэжлийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, үүргийг тус тус тодорхойлсон ба 5 хэсэг, 62 заалт, 1 хавсралттай байхаар тусгажээ.

Энэхүү заавар нь мал, амьтны гоц халдварт өвчин гарч хорио цээр, хязгаарлалтын дэглэм сахиулах үед шалган нэвтрүүлэх цэг дээр ажиллах мэргэжлийн байгууллага, алба хаагч, иргэний үүрэг гүйцэтгэхэд баримтлах юм.

Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тушаалаар батлагдсан “Гал түймрийн аюулын үнэлгээ хийх журам”-ын нэмэлт өөрчлөлт

Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр гал түймрийн аюулын үнэлгээ хийх зөвлөл 12 гишүүнтэй байхаар батлагдаж, зөвлөл нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулах болсон. Үүнд:

- Галын аюулгүй байдлын тухай хуульд заасны дагуу барилгын зураг төсөлд галын аюулгүй байдлын магадлал хийх,
- Галын аюултай бүтээгдэхүүн, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэх болон үйлдвэрлэх, борлуулах, тээвэрлэх, хадгалах, устгах,
- Гал түймрээс урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа явуулах иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг тус тус сонгон шалгаруулж гэрээ байгуулах, гал түймрийн аюулын үнэлгээг хянаж зөвлөмж, дүгнэлт гаргах ажлыг эрхлэх мэргэжлийн орон тооны бус бүтэцтэй болсноороо онцлог байна.

1.1.3. Онцгой байдлын ерөнхийн газрын даргын тушаалаар батлагдсан баримт бичиг

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/82 тоот тушаалаар батлагдсан "Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын ажил дүгнэх заавар, загвар батлах тухай" заавар, загвар

Энэхүү гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын ажил дүгнэх заавар, загварын зорилго нь Галын аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.1-д заасан хэсгийг хэрэгжүүлэх, алба хаагчдын бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн ба Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааны гүйцэтгэлийг дүгнэж, үр дүнг тооцох, дагаж мөрдөхөд чиглэгдсэн.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/102 дугаар тушаалаар батлуулсан "Гамшгийн статистик, хохирол, хэрэгцээ, мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагааг зохицуулах журам"

Энэхүү журмын төслийг 2020 онд Монгол Улсын Шадар сайдын 3 дугаар сарын 18 ны өдрийн 22 тоот тушаалаар батлагдсан "Олон улсын болон дотоодын гамшгаас хамгаалах бодлого хөтөлбөр"-тэй уялдуулан "Гамшгийн бүртгэл, хохирол хэрэгцээний маягт заавар аргазүй"-д үндэслэн 2023 оны Гамшгийн статистик, хохирол хэрэгцээний мэдээллийн нэгдсэн системийг Австрали Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд хөгжүүлж, тус системийн үйл ажиллагааг зохицуулахаар боловсруулан батлуулж, Онцгой байдлын байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллаж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн А/132 дугаар тушаалаар батлагдсан "Татан гаргах ажиллагаанд оролцох бүрэлдэхүүн, бодлого төлөвлөлт, зохион байгуулалтын заавар, үйл ажиллагааны төлөвлөгөө, ашиглах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тооцоо, Хөдөлмөрийн аюулгүй байдлын заавар"

Нийт зам тээврийн ослын 90 орчим хувьд нь Онцгой байдлын байгууллагын алба хаагч автомашинд задаргаа хийж, байгаатай холбогдуулан энэхүү зааврыг боловсруулахдаа Гамшгаас хамгаалах тухай хууль, Онцгой байдлын байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм", "Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам", "Уснаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах журам", ОХУ-ын "Эрэн хайх, аврах ажиллагааны технологи", "Автомашинаас нэрвэгдэгчийг гаргах техник" сурах бичгийг удирдлага болгож, эрэн хайх, аврах нэгжид түгээмэл ашиглаж буй тусгай зориулалтын багажаар автомашинд задаргаа хийх аргачлалыг алба хаагчдад ойлгомжтой болгож "Аюулгүй ажиллагаа нэгдүгээрт" гэсэн олон улсын зарчмыг удирдлага болгосон.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын болон Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны А/157, А/109 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх аймаг, нийслэл, сум, дүүргийн

бэлэн байдлын дэд төлөвлөгөө боловсруулах заавар, загвар”

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 13.4-д “Улсын бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгайлан заасан бол аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэх бэлэн байдлын дэд төлөвлөгөөг батална.”, 13.5-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн бэлэн байдлын дэд төлөвлөгөө боловсруулах аргачлалыг мал, амьтны эрүүл мэндийн болон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хамтран батална.” гэж тус тус заасныг үндэслэн Онцгой байдлын ерөнхий газар болон Мал эмнэлэгийн газраас хамтран боловсруулжээ.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар батлагдсан “Гал түймэр унтраах автомашин, техникийн гал унтраах тусгай тоноглол болон гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг туршин шалгах заавар”

Энэхүү заавар нь Галын аюулгүй байдлын тухай хуульд заасан гал түймэр унтраах, авран хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд гал түймэр унтраах автомашин, техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдал, алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/228 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын төрийн болон нууцыг ашиглах, хадгалах, хамгаалах журам”

Онцгой байдлын байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд төрийн болон албаны нууц мэдээллийг нууцлах, хамгаалах, задрах үрэгдэх, төрийн болон байгууллагын ашиг сонирхолд аюул занал, хохирол учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд энэхүү журмыг өөрийн байгууллагын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн 7 хэсэг, 52 заалттай журам батлуулсан бөгөөд уг журмыг хэрэгжүүлэх, нууц мэдээллийг ашиглах, хадгалах, хамгаалахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг байгууллагын онцлогт нийцүүлэн нууц хамгаалах ажилтан хэрэгжүүлэх бөгөөд эрх бүхий албан тушаалтны мэдлэг, ур чадвар сайжирч, байгууллагын үйл ажиллагаанд зөрчил, доголдол үүсэхээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхээр зохицуулсан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/263 дугаар тушаалаар батлагдсан “Архивын байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”

Архивын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газартай зөвшилцсөний дагуу улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа Архивын байгууллагад дагаж мөрдөхөөр галын аюулгүй байдлын дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд дүрмийн зорилго нь хүний амь нас, эрүүл мэнд, архивын сан хөмрөгийн баримт, эд хөрөнгө, тэдгээрийн галын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг

зохицуулах бөгөөд нийтлэг үндэслэл, архивын байгууллагын галын аюулгүй байдлыг хангах ажлын зохион байгуулалт, архивын байгууллагын галын аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага, хориглох зүйл, хүлээх хариуцлага гэсэн 5 дэд бүлэгтэйгээр батлагдсан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/365 дугаар тушаалаар батлагдсан "Онцгой байдлын байгууллагын оны шилдгийг шалгаруулах журам"

Монгол Улсын сайдын 2005 оны "Онцгой байдлын албаны тэргүүний ажилтан" тэмдгийн загвар батлах тухай 113, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны "Журам батлах тухай" 102, "Онцгой байдлын албаны төлөө" тэмдэг бий болгох тухай 567 дугаар тушаалыг шинэчлэн, нэг мөр болгох зорилгоор уг журмыг боловсруулж батлуулсан.

Энэхүү журамд "Онцгой байдлын албаны хүндэт тэмдэг", "Онцгой байдлын албаны Онцгой үйлстэн тэмдэг"-ийг нэмэлтээр оруулсан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/383 дугаар тушаалаар батлагдсан "Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг зохион байгуулах, үнэлэх журам"

Улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, аймаг, нийслэл, мэргэжлийн анги, хуулийн этгээдэд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж үнэлэх, зөрчил дутагдлыг арилгуулж бэлэн байдлыг хангуулахад журмын зорилго оршино.

Журамд дараах өөрчлөлт, шинэчлэлтийг оруулсан байна. Үүнд:

Нэгдүгээрт: Бэлэн байдлыг дүгнэх үзүүлэлт, асуудлууд давхардсан байсныг хасаж, зарим асуудлууд хэт ерөнхий ойлгомжгүй байсныг тодорхой болгож тусгасан.

Хоёрдугаарт: Бэлэн байдлын үзлэгийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт 4 жилд 1-ээс доошгүй, улсын албанд 2 жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна гэснийг нэг жилд 2-3 улсын алба, нэг жилд 2-3 аймаг, нийслэлд 4 жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулахаар өөрчилсөн.

Гуравдугаарт: Аймаг, нийслэл, сум, дүүрэг, улсын болон орон нутгийн алба, мэргэжлийн анги, хуулийн этгээдийг үзлэг зохион байгуулах чиглэл, үнэлгээний нэг хүснэгтээр үнэлдэг байсныг тус бүрийн онцлогт тохируулан үнэлэх хүснэгт боловсруулахаар тусгасан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 12 сарын 06-ны өдрийн А/392 дугаар тушаалаар батлагдсан "Онцгой байдлын байгууллагын ар тал, хангалтын журам"

Онцгой байдлын албанд ар тал, хангалтын шинэ нэгжүүд байгуулагдсантай холбогдуулан "Онцгой байдлын байгууллагын ар тал, хангалтын журам"-ыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн, бүртгэл хөтлөлт, төлбөр тооцоог сайжруулах, хангалт хариуцаж буй алба хаагчдын эрх үүргийг

тодорхой болгох, хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор батлуулсан.

Энэхүү журмыг Онцгой байдлын байгууллагын ар тал, хангалтыг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд дагаж мөрдөх, Онцгой байдлын байгууллагын бэлтгэл, бэлэн байдлыг хангах, тайван цагт өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах, хяналт тавих асуудлыг зохицуулах, ар тал, хангалтын үйл ажиллагааг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, хандив, төсөл хөтөлбөрөөр санхүүжүүлэх асуудлыг зохицуулсан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/404 дүгээр тушаалаар батлагдсан "Хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах хяналтын хуудас"

"Хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах хяналтын хуудас"-ыг батлуулснаар Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6-д "Хяналт шалгалт эхлэхээс өмнө эрх бүхий албан тушаалтан шалгуулах этгээдэд шалгалтын зорилго, бүрэлдэхүүнийг танилцуулж удирдамж, хяналтын хуудасны нэг хувийг өгөх, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д "Хяналт шалгалтыг зөвхөн удирдамж, хяналтын хуудсанд заасан асуудлын хүрээнд гүйцэтгэнэ", 54 дүгээр зүйлийн 54.1-д "Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болох хор хохирол, үр дагаврыг харгалзан хяналт шалгалтын объектын эрсдэлийг бага, дунд, их хэмжээний гэж ангилна" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлэх, Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын баталсан гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт шалгалтын төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалт үр дүнтэй зохион байгуулагдах ач холбогдолтой.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/405 дугаар тушаалаар батлагдсан "Өндрөөс аврах ажиллагааны заавар"

Гамшгаас хамгаалах тухай хууль, Онцгой байдлын байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм", "Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам", "Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах журам", ОХУ-ын "Эрэн хайх, аврах ажиллагааны технологи" сурах бичгийг удирдлага болгон эрэн хайх, аврах нэгжид түгээмэл ашиглаж буй тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр өндрөөс аврах зааврыг алба хаагчдад ойлгомжтой байдлаар боловсруулж "Аюулгүй ажиллагаа нэгдүгээрт" гэсэн олон улсын зарчмыг баримталж, Онцгой байдлын ерөнхий газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 12.15-т заасны дагуу "Өндрөөс аврах ажиллагаа зохион байгуулах заавар"-ыг батлуулсан.

Зааврын төсөл нь нийт 8 бүлэг, 93 зүйлтэй бөгөөд өндрөөс, нисдэг тэргээр

аврах ажиллагаа зохион байгуулах үед ашиглах биет дохио, нэрвэгдэгч болон хүнийг буулгах дадлага сургуулийн хувилбарыг хавсаргасан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/406 дугаар тушаалаар батлагдсан "Сум, галт хэрэгсэлтэй харьцах үеийн заавар"

Зааврыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2008 оны тушаалаар батлагдсан Тэсэрч, дэлбэрэх зүйлийн хайгуул устгалын ажлын түр заавар, Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийг судлан боловсруулсан бөгөөд төсөлд улсын хэмжээнд ашиглагдаж байгаа их буу, миномёт, тийрэлтэт артиллер, хуягт, зенит, танкны сум, минийн заалт бичиглэл, түүний зарим тайлбар, сум, галт хэрэгслийн дуудлага, мэдээллийг хүлээн авах, хүрэлцэн очих, сум, галт хэрэгсэлтэй аюулгүй харьцах, алба хаагчдын гүйцэтгэх үүрэг, тэдэнд тавигдах шаардлагыг тус тус тодорхойлж өгсөн.

Мөн дуудлагаар ажилласан тухай нотломжийн хуудасны загвар, урьдчилсан зааварчилгааны хүснэгт, сум, галт хэрэгсэл, тэсрэх бодис тэсэлгээний хэрэгслийн хамгийн бага болон холын аюулгүй зайг тодорхойлох хүснэгт, нийтлэг олддог сум, минийн төрөл, үсгийн тайлбар, заалт бичиглэл, түүний зарим тайлбарыг хавсралтаар тусгаж өгсөн бөгөөд энэхүү заавар батлагдан гарснаар тэсрээгүй сум, галт хэрэгсэлтэй холбоотой дуудлага, мэдээллийн дагуу үүрэг гүйцэтгэхэд төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндэс болох юм.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/408 дугаар тушаалаар батлагдсан "Гал түймэр унтраах, аврах анги, эрэн хайх, аврах анги, салбар, бүлгийн баримт бичиг баталгаажуулах тэмдэг хэрэглэх журам"

Энэхүү журмаар Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх аврах анги, салбар, бүлгийн өдөр тутмын үйл ажиллагаанд хөтлөгдөх баримт бичгийг баталгаажуулах тэмдэг хийлгэх, хэрэглэх, хадгалахтай холбоотой харилцааг зохицуулахаар боловсруулж батлуулсан.

Тэмдгийг нэгжийн дарга, захирагч, мөн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр томилогдсон албан үүргийг түр орлон гүйцэтгэгч түшиж, тус албан тушаалтны баталгаат гарын үсэг зурсан нэгжид хөтлөгдөх баримт бичиг /томилгоот ээлжийн бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх хуваарь, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа/-ийг баталгаажуулахад хэрэглэхээр журамласан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/412 дугаар тушаалаар батлагдсан "Гамшгаас хамгаалах иж бүрэн

болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар”

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/323 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар”-ыг шинэчлэн боловсруулсан.

Сургууль, дадлагын хэрэгцээг тодорхойлох нь сургалтын процессын эхний чухал үе шат тул зааварт “Сургууль, дадлагын бодлого, хэрэгцээ” гэсэн бүлгийг шинээр нэмсэн байна. Энэ бүлэгт өмнөх зааварт сургалтын бодлого болон сургалтын зорилготой холбоотой гарсан заалтуудыг оруулж, сургалтын хэрэгцээг тодорхойлох үндсэн алхамыг шинээр нэмж өгсөн. Түүнчлэн “Сургууль, дадлагын үйл ажиллагаа, үнэлгээ, дүгнэлт” гэсэн тавдугаар бүлэгт сургууль дадлагын үйл ажиллагаа болон үнэлгээ, дадлагын үр дүнг дүгнэх, дүгнэлт хийж байхаар нэмэлт оруулсан.

БҮЛЭГ 1.2. ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжсэн дараах бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэнд Хяналт шалгалтын газраас хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

1. “Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 50 дугаар тушаалаар батлагдсан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны I үе шат буюу 2016-2020 онд нийт 41 арга хэмжээ хэрэгжиж 91.2 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн.

Тус төлөвлөгөөний 6 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг 2021-2025 он хүртэл хэрэгжүүлэхээр тусгагдсан ба 2023 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 93.0 хувьтай үнэлэгдсэн.

2. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөр Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан.

Тус хөтөлбөрийн амар тайван аюулгүй нийгэм VII зорилгын хүрээнд “Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн тогтолцоог бэхжүүлнэ”, “Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бараа материалын

хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан хүнсний агуулах, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулна" гэх 2 арга хэмжээг;

Бүс орон нутгийн хөгжил VIII зорилтын хүрээнд "Орон нутгийн мэдээлэл болон цаг агаарын урьтаж анхааруулах мэдээг малчдад дамжуулж бэлэн байдалд орох боломж бүрдүүлэх мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий цогцолборыг аймгууд, аюулын эрсдэл өндөртэй зарим сумдад үе шаттайгаар байгуулна" гэх 1 арга хэмжээг нийт 3 заалт арга, хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар Онцгой байдлын ерөнхий газрыг заасан байдаг.

"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т Онцгой байдлын ерөнхий газрын биелэлтийг хангах арга хэмжээнүүдэд 2021-2024 онд хэрэгжих 1 (7.3.3.), 2022-2024 онд хэрэгжих 1 (7.3.4), 2022-2025 онд хэрэгжих 1 (8.1.4) арга хэмжээ тусгагдсан.

"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд Онцгой байдлын ерөнхий газар үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар тусгагдсан 3 ажил, арга хэмжээний биелэлт 53.3 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэгдсэн байна.

3. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 203 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд засаглалын бодлогын 4.3.11.1, 4.3.14.1, 4.3.14.2, 4.3.15.1, ногоон хөгжлийн бодлогын 5.1.2.1 зэрэг нийт 5 заалт арга, хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар Онцгой байдлын ерөнхий газрыг заасан байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Онцгой байдлын ерөнхий газрын биелэлтийг хангах арга хэмжээнүүдэд 2021-2028 онд хэрэгжих 1 (4.3.11.1), 2020-2023 онд хэрэгжих 1 (4.3.15.1), 2020-2024 онд хэрэгжих 1 (5.1.2.1), 2022-2024 онд хэрэгжих 2 (4.3.14.1, 4.3.14.2) арга хэмжээ тусгагдсан байна.

"Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-нд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд Онцгой байдлын ерөнхий газар үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар тусгагдсан 5 ажил, арга хэмжээний 2023 оны жилийн эцсийн биелэлт 58 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэгдсэн.

4. Монгол Улсын Их хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-ийн 3.2 дахь "Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана", 4.1 дэх "Ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглаж, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ" гэх 2 зорилгын хүрээнд Онцгой

байдлын ерөнхий газар хариуцах тус бүр 1 нийт 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан. Үүнд;

Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 3.2.3-т Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг бэхжүүлэх хүрээнд аврах ажиллагаа явуулах нөхцөлийг сайжруулах, 4.1.6 -т Хөвсгөл нуурт живсэн машин техникийг татаж гаргах гэсэн 2 арга хэмжээ туссан байна.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд Онцгой байдлын ерөнхий газрын үндсэн хэрэгжүүлэгчээр туссан 2 ажил, арга хэмжээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 100 хувь дүгнэгдсэн.

Онцгой байдлын ерөнхий газарт 2023 онд гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй 2 төсөл байна. Үүнд:

1. “Онцгой байдлын албанд агаараас эрэн хайх, аврах нэгж байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх” төсөл (Бүгд Найрамдах Франц улсын засгийн газрын хөнгөлөлттэй зээл 2020-2023 он)
2. Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл (Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламж 2022-2026 он)

Нэг. “Онцгой байдлын албанд агаараас эрэн хайх, аврах нэгж байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх” төсөл 2020-2023 онд хэрэгжих бөгөөд төслийн хүрээнд:

1. “EC-145 маркийн 1 нисдэг тэрэг, сургалтын симулятор хүлээн авах”,

2.“Нисгэгч, инженер техникийн ажилтан бэлтгэх сургалтыг зохион байгуулах” гэсэн 2 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан.

Хоёр. “Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх” төсөл 2022-2026 онд хэрэгжих бөгөөд төслийн хүрээнд:

1.“Хүчитгэх шаардлагатай барилга байгууламжийн жагсаалт гаргах, барилгад үнэлгээ хийж, үнэлгээ хийгдсэн барилгын хүчитгэлийн ТЭЗҮ боловсруулах, Тэсвэржилтийг бэхжүүлэхэд чиглэсэн бодлого, систем, замын зураглал боловсруулах, Газар хөдлөлтийн тэсвэржилт, хүчитгэлтэй холбоотой журам, норм боловсруулах”.

2.“Газар хөдлөлтийн тэсвэржилтийн чиглэлээр захиргааны ажилтнуудын чадавхыг сайжруулах сургалт зохион байгуулах” гэсэн 2 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан.

Онцгой байдлын ерөнхий газарт 2023 онд гадаад зээл тусламжаар хэрэгжиж буй 2 төсөлд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, тус бүр дараах байдалтай үнэлэгдсэн.

Хүснэгт 1. Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт

№	Төслийн нэр	Зорилтын тоо	Зорилтын үнэлгээ	Төслийн үнэлгээ
1	Онцгой байдлын албанд агаараас эрэн хайх, аврах нэгж байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх	Зорилт-1	100 хувь	100 хувь
		Зорилт-2	100 хувь	
2	Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх	Зорилт-1	100 хувь	100 хувь
		Зорилт-2	100 хувь	

1.2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилт:

Гамшгийн эрсдэлийг бууруулах Дэлхийн III бага хурлаас 2015 онд батлан гаргасан "Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд авч хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг"-т 2030 он гэхэд дараах үр дүн, зорилгод хүрнэ гэж тодорхойлсон. Үүнд:

Хүрэх үр дүн: Гамшгийн эрсдэл, түүний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, ард иргэд, бизнес, олон нийт, улс орны эдийн засаг, нийгэм, биет болон соёлын үнэт зүйл, хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээг бодитой бууруулах.

Зорилго: Аюулд өртөх байдал, гамшигт эмзэг байдлаас урьдчилан сэргийлэх, бууруулах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох бэлэн байдлыг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх эдийн засгийн, бүтцийн, хууль, эрх зүйн, нийгмийн, эрүүл мэндийн, соёлын, боловсролын, байгаль орчны, технологийн, улс төрийн болон институцийн нэгдмэл, харилцан уялдаатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулах, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх[1].

Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн дунд хугацааны Монгол Улсын тайлан нь 2015-2022 онд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр Монгол Улсад олсон ололт амжилт, учирсан хүндрэл бэрхшээл, сорилтыг дүгнэн, тулгарч буй асуудлыг цаашид үндэсний болон бүс нутаг,

[1]United Nations, Sendai Framework for disaster Risk Reduction 2015-2030 (17, 20 дахь тал), 2015

олон улсын хэмжээнд хэрхэн шийдвэрлэж болох арга зам, сайжруулах үйл ажиллагааг тодорхойлох зорилготой бөгөөд дэлхийн хэмжээнд дэвшүүлсэн 7 зорилт, тэргүүлэх 4 чиглэлийн хүрээнд тулгуурлан холбогдох талуудын оролцоотойгоор боловсруулсан байна.

Тус тайлан нь НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын сайтад байршсан байна. Mongolia: Voluntary National Report of the MTR SF | Midterm Review of the Sendai Framework (undrr.org)

БҮЛЭГ 1.3. ГАМШГААС ХАМГААЛАХ ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА

1.3.1. Гадаад хамтын ажиллагаа, айлчлал

Онцгой байдлын байгууллага нь Гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр гадаад улс оронтой хамтран ажиллаж, Олон улсын хурал, семинарт оролцох зэргээр олон арга хэмжээнд идэвхитэй оролцсон. Үүнд :

1. Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханаар ахлуулсан бүрэлдэхүүн БНХАУ-д 2023 оны 10 дугаар сард айлчилж, тус улсын Онцгой байдлын яамны сайд Ван Шянь Шитай нар хоёр талын уулзалтыг зохион байгуулагдсан. Уулзалтын дүнд хоёр орны хил орчмын нутаг дэвсгэрт ой, хээрийн түймэртэй тэмцэх хамтын ажиллагааг боловсронгуй болгох, эрэн хайх, аврах чадавхыг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын аврагч нарыг сургаж бэлтгэх, “Бүс ба зам” санаачлагын гамшгаас хамгаалах хяналтын сүлжээний төслийг хамтран хэрэгжүүлэх болон гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцлоо.



Зураг 1. БНХАУ-д хийсэн айлчлал, 2023-10

2. “Үйлдвэрийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн хор уршгийг арилгах салбарт хамтран ажиллах тухай” Монгол-Оросын хамтарсан хуралдаан 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, комиссын хуралдаанаар “Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, тэдгээрийн хор уршгийг арилгах яам хоорондын 2024-2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөө”-г батлав.



Зураг 2. Монгол-Оросын хамтарсан хуралдаан

3. АНУ Нью-Йорк хотод зохион байгуулагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийг хэлэлцэх өндөр түвшний уулзалтад Онцгой байдлын байгууллагын төлөөлөл оролцож, Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр болон Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг зэрэг хөгжлийн баримт бичгүүдийн зорилтын уялдаа холбоог авч үзэн, тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхийн тулд гамшгийн эрсдэлийн төлөвлөлтийг бататган, тэр дундаа уур амьсгалын өөрчлөлт, биологийн зэрэг асуудлыг харилцан уялдаатай хэрэгжүүлэхэд нягт хамтран ажиллахаар боллоо.

Зураг 3. Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийг хэлэлцэх өндөр түвшний уулзалт

4. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн А/183 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн Хурандаа Ц.Нямбаяр, хурандаа Ч.Ариунаа, хурандаа Д.Базаррагчаа, хошууч Н.Баттүвшин, хошууч Н.Амгалан нарын бүрэлдэхүүн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын өөртөө засах орны Шилийн хотод 2023 оны 6 дугаар сарын 18-ны өдрөөс 23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэх үйл ажиллагааны гарын авлага" боловсруулах ажлын хэсгийн уулзалтад оролцсон. Тус уулзалтаар ӨМӨЗО-ны Онцгой байдлын яамтай хамтарсан "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах санамж бичиг"-ийг хамтран боловсруулж, 2024 онд гарын үсэг зурахаар төлөвлөсөн байна.

Зураг 4. Монгол, Хятадын хил орчмын нутаг дэвсгэрийн ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын зөвөлгөөн

5. ESCAP олон улсын байгууллага, Исламын бүгд найрамдах Иран Улсын Засгийн газар хамтран Тегеран хотод зохион байгуулсан "Элс болон шороон шуургатай тэмцэх, бууруулах" сэдэвт олон улсын хуралд 2023 оны 09 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд ГСҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд хурандаа П.Чимэдцэрэн панелистаар оролцож "Монгол орны элсэн болон шороон шуурганы нөхцөл байдал, сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

1.3.2. Онцгой байдлын байгууллагад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

Онцгой байдлын байгууллага гадаад улс, орны Монгол Улсын Засгийн газар, олон улсын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, цаашид хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

1. Монгол Улсын Шадар Сайдын 2023 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 41 дүгээр тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн А/185 дугаар тушаалаар Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуянаар ахлуулсан Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр, Санхүү, ар талын газрын дарга, хурандаа Я.Гантөмөр, Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр ангийн захирагч, хурандаа Т.Мөнхдорж нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс 6 дугаар сарын 17-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Франц Улсад ажлын айлчлал хийж "Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл"-ийг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүний үр дүнд "Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл"-ийн санхүүжилт олгох тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийг 2023 оны 10 дугаар сард Парис хотод Монгол Улсын Шадар Сайд С.Амарсайхан ажлын айлчлал хийх үед байгуулсан байна.

Энэхүү Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд "Онцгой байдлын албанд агаараас эрэн хайх, аврах ажиллагааны нэгж байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх төсөл" амжилттай хэрэгжсэн.

Төслийн 2 дахь шат буюу 2024-2026 онд агаараас эрэн хайх, аврах ангийн чадавхыг бэхжүүлэх, гал унтраах автомашин нийлүүлэх нийт 38.2 сая еврогийн төслийг хэрэгжүүлэхээр санхүүгийн хэлэлцээрийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулсан.

Зураг 5. EC-145 нисдэг тэрэг

Зураг 6. Сургалтын дадлагажуур

2. Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА -тай хамтран “Монгол Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн 2 дугаар шатыг 2022 оны 4 дүгээр сараас эхлүүлсэн. Төслийн хүрээнд “Хүчитгэлийн үйл ажиллагааны урт хугацааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг “Гамшгаас хамгаалах Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичигтэй уялдуулах талаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Төслийн ажлын хэсэг хүчитгэх шаардлагатай 780 олон нийтийн барилгын эрэмбэлсэн жагсаалтаас барилгын зориулалт, бүтээцийн төрөл, төлөөлөх шинж чанар, гамшгийн үед гүйцэтгэх үүрэг гэх зэрэг шинж чанарыг харгалзан газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хийх 10 барилгыг сонгосон. Тус барилгаас 5 барилгад хүчитгэлийн зураг төсөл боловсруулах бөгөөд эхний шатанд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эх барих эмнэлгийн барилгын хүчитгэлийн зураг болон төсвийг боловсруулж Барилгын хөгжлийн төвөөр хянуулан Эрүүл мэндийн яаманд хүлээлгэн өгсөн байна.

Зураг 7. Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалт

Төслөөс алба хаагчдыг сургаж, дадлагажуулах зорилтын хүрээнд Япон Улсад 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад Онцгой байдлын ерөнхий газар, Барилга, хот байгуулалтын яам, Сангийн яам, Нийслэлийн Боловсролын газар, Монголын Барилга инженерүүдийн холбоо зэрэг төсөл хамтран хэрэгжүүлж буй байгууллагын нийт 20 алба хаагч хамрагдсан. Сургалтын үеэр Япон улсын барилга байгууламжийн хүчитгэлийн эрх зүйн орчин, бодлого төлөвлөлт, гамшгаас хамгаалах төлөвлөлтийн талаар судалж,

гамшгаас хамгаалах түшиц байгууламж болон сургалтын төв, газар хөдлөлтөд тэсвэртэй буюу хүчитгэл хийгдсэн барилга байгууламжтай танилцуулсан байна.

Төслийн хүрээнд Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвд нийлүүлэгдэх Виртуал дүрсний тоног төхөөрөмжийг 2023 хүлээн авч сургалт зохион байгуулах нөхцлийг бүрдүүлсэн.

3. Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран Монгол Улсад хот дотор эрэн хайх, аврах ажиллагааны чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд олон улсын эрэн хайх, аврах дунд түвшний багийг бэлтгэх, сургаж дадлагажуулах сургалт дадлагыг гадаадын шинжээч сургагч багш нартай хамтран зохион байгуулсан.

Зураг 8. Эрэн хайх, аврах дунд түвшний багийн дадлага сургуулилт

4. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Монгол Улсын гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх” техник туслалцааны төслийн хүрээнд Монгол Улсад ихэвчлэн тохиолддог гамшиг, аюулт үзэгдлийн 10 төрлөөр гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж, гамшгийн эрсдэлийн мэдээллийн сан боловсруулах ажлыг зохион байгуулав.

БҮЛЭГ 1.4 ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХ

1.4.1. Онцгой байдлын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын бэхжилт

Онцгой байдлын байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн мн/346 тогтоолоор "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, судалгаа, туршилт, үйлдвэрийн төв" 123 дугаар ангийг шинээр байгуулж, Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн мн/190 дүгээр тогтоолоор Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх "Давтан сургалт, сургалт сэргээн заслын төв 113 дугаар анги"-ийг "Жаргалант сэргээн засах төв 113 дугаар анги" гэж өөрчилж, Төв аймгийн Баян сум дахь эрэн хайх, аврах бүлгийг Төв аймгийн Эрдэнэ суманд, Төв аймгийн Лүн сум дахь эрэн хайх, аврах бүлгийг Булган аймгийн Дашинчилэн суманд тус тус шилжүүлсэн.

Зураг 9. Онцгой байдлын байгууллагын бүтэц зохион байгуулалтын бэхжилт

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоолоор байгуулагдсан Төв аймгийн Батсүмбэр сум дахь Гал түймэр унтраах, аврах 84 дүгээр анги, Засгийн газрын 2023 оны мн/190 тогтоолоор Булган аймгийн Дашинчилэн суманд байгуулагдсан Эрэн хайх, аврах бүлгийн үйл ажиллагааг тус тус эхлүүлснээр төв, орон нутаг дахь гамшгаас хамгаалах чадавх нэмэгдсэн.

Зураг 10. Гал түймэр унтраах, аврах бүлгүүдийн нээлтийн үйл ажиллагаа

Онцгой байдлын байгууллагын хэмжээнд 2023 оны байдлаар Үндэсний аврах бригад, Агаараас эрэн хайх, аврах анги, Уул уурхайн аврах анги, Нийслэлийн аврах анги, Нийслэлийн Налайх дүүрэг дэх эрэн хайх, аврах бүлгээс гадна орон нутагт эрэн хайх, аврах 40 гаруй нэгжүүд үйл ажиллагаа явуулж бна.

Онцгой байдлын байгууллага нь төрийн тусгай байгууллагуудыг түүчээлэн “Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандарт”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн уг стандартыг 4 дэх жилдээ нэвтрүүлж 2023 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр давтан баталгаажилтын аудитад хамрагдаж, ЧАНАРЫН итгэмжлэлийн гэрчилгээ 3 жилээр сунгагдаж, Олон улсын итгэмжлэгдсэн байгууллагын жагсаалтад орлоо. Олон улсын итгэмжлэлийн форум нэгдсэн мэдээллийн санд албан ёсны MNS ISO 9001:2015 стандарт хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зураг 11.
Чанарын итгэмжлэлиийн гэрчилгээ,2023

1.4.2. Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн талаар

Дотоодын сургалт, семинарт давхардсан тоогоор 2911 гаруй алба хаагч, гадаад улс орон, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн хүрээнд давхардсан тоогоор 170 гаруй алба хаагч хамрагдаж мэргэжил, ур чадвараа дээшлүүлсэн.

Гадаад улс орнууд буюу ОХУ, Польш, Турк, Солонгос, Япон, Тайланд зэрэг улс орнуудад нийт 80 гаруй алба хаагчийг гамшгаас хамгаалах чиглэлээр академи, сургуулиудад бакалавр, магистрын хөтөлбөрүүдэд суралцуулсан.



Зураг 12. Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн сургалт, бэлтгэл

Дотооддоо хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх давтан сургах чиглэлээр ДХИС-ийн доктор, магистрын хөтөлбөр, мөн 3.5 жилийн эчнээ хөтөлбөрт нийт 160 гаруй алба хаагч суралцсан байна. ДХИС-ийн Ахлагчийн сургуулиар дамжуулж Аврагч-гал сөнөөгч, Гал унтраах автомашины жолооч, холбооны бага мэргэжилтэн зэрэг 3 мэргэжлээр 2023-2024 оны хичээлийн жилд 2 удаагийн сургалт төлөвлөснөөс 2024 оны 04 сарын байдлаар 3 удаагийн сургалтаар 239 сонсогч төгсөж, төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагад томилогдон, албан үүргээ гүйцэтгэж байна.

Зураг 13. Мэргэшүүлэх давтан сургах хөлөлбөр

Энэ онд Онцгой байдлын байгууллагаас үйлчилгээний гавьяат ажилтан 1, дэд профессор 1, доктор 1 төрөн гарсан байна.

Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигаар Онцгой байдлын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцсон, олон улсын хүмүүнлэгийн ажиллагаанд алба хаагчдыг шуурхай удирдлагаар хангаж үүргээ амжилттай биелүүлэн эх орныхоо нэрийг өндөрт өргөсөн гавьяа зүтгэлийг үнэлж, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, Бригадын генерал Батмөнхийн Ууганбаяр Үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртлээ.

Зураг 14. Үйлчилгээний гавьяат ажилтан Бригадын генерал Батмөнхийн Ууганбаяр

Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан бөгөөд секторын эрхлэгч, доктор /Ph.D/ ахмад Т.Өсөхжаргалд "дэд профессор" эрдмийн зэрэг олгож, эрдэм шинжилгээний ажилтан бөгөөд секторын эрхлэгч, ахмад Д.Нарантуяа доктор /Ph.D/-ын зэрэг хамгааллаа.

Зураг 15. Энэ онд Онцгой байдлын байгууллагаас
1 дэд профессор, 1 доктор төрөн гарсан байна.

“Онцгой байдлын байгууллагын залуу офицерууд”-ын чуулга уулзалт

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор 2023 оны 09 дүгээр сард зохион байгуулагдах “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын залуу офицеруудын чуулган”-тай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газраас “Онцгой байдлын байгууллагын залуу офицерууд”-ын чуулга уулзалтыг 2023 оны 08 дугаар сарын 10-11-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Зураг 16. Онцгой байдлын байгууллагын залуу офицерийн чуулга уулзалт

Чуулга уулзалтад төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын 120 орчим алба хаагч оролцож, оролцогчдод төрийн албан хаагчийн ёс зүйн хандлага, төлөвшил болон хувь хүний хөгжлийн талаар мэдээлэл өгсөн юм.

Чуулга уулзалтаас Онцгой байдлын байгууллагын залуу офицеруудын манлайллын нийтлэг зарчим, агуулгыг тодорхойлох, хамтын ажиллагааг бэхжүүлж, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг бий болгоход алба хаагчдын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий нэгдсэн зөвлөмжийг гаргажээ.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицерууд чуулга уулзалт

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицеруудын чуулган”-ыг 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс 10-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Хар зүрхний хөх нуурт амжилттай зохион байгуулаа.

Энэхүү чуулганд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудаас шалгарсан шилдэг 817 залуу офицер оролцсон бөгөөд Онцгой байдлын

байгууллагыг төлөөлж 100 гаруй офицер амжилттай хамрагдав.

“Залуу офицеруудыг дэмжих жил”-ийн хүрээнд дэвшүүлсэн хамгийн гол зорилт, үр дүн бол залуу офицерууд өөрсдийнхөө албаны ирээдүй, хөгжлийн чиг хандлага, хөгжлийн орчныг бүрдүүлэхэд идэвхтэй оролцож, үзэл бодол, дуу хоолойгоо хүргэх явдал байсан. Уг чуулганы угтаж Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнайгаар ахлуулсан ажлын хэсэг 43 ажил арга хэмжээ төлөвлөж, бодит ажил хэрэг болгон хэрэгжүүлсний нэг нь “Шилдэг офицер-2023” уралдаан байв.

Дээрх чуулганаар “Залуу офицеруудын манлайлал, хөгжил, нийгмийн оролцоо” сэдэвт панел хэлэлцүүлэг өрнүүлэн, “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицеруудын хөгжил ба манлайлал” нэгдсэн илтгэлийг танилцуулж, “Залуу офицеруудын нийгмийн асуудал, манлайлал, хөгжлийн талаарх социологийн судалгааны дүн”-г танилцуулан дэд чуулган болон эрдэм шинжилгээний хурлаас гарсан санал, дүгнэлт, уриалгыг удирдлагуудад гардуулав.

Зураг 17. Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Хар зүрхний хөх нуурт зохион байгуулагдсан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицеруудын чуулган

“Шилдэг залуу офицер шалгаруулах тэмцээн"

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын "Шилдэг залуу офицер шалгаруулах анхдугаар тэмцээн"-д Онцгой байдлын байгууллагаас 5 эрэгтэй, 3 эмэгтэй алба хаагч амжилттай оролцсоноос тэмцээний гадаад хэлний төрөлд ОБЕГ-ын харьяа Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр ангийн ахлах мэргэжилтэн, дэслэгч А.Энх-Ариун тэргүүлсэн бол ОБЕГ-ын мэргэжилтэн, ахмад Д.Нацагдорж илтгэх урлагийн төрөлд гутгаар байр эзэлсэн. Эдгээр алба хаагчдын тэмцээний бэлтгэлийг Захиргааны удирдлагын газрын хурандаа Б.Үнэнбаатар ахлагчтай баг, гадаад хэлний төрлийн бэлтгэлийг хурандаа Д.Базаррагчаа, ахмад Н.Ананда, ахлах дэслэгч Г.Нарантуяа нар, илтгэл эссэний төрлийн бэлтгэлийг дэд хурандаа П.Чимэдцэрэн нар хариуцан ажиллажээ.

Зураг 18. Шилдэг залуу офицер шалгаруулах анхдугаар тэмцээний шилдгүүд.

2023 онд зохион байгуулагдсан томоохон сургалт

“Зочин судлаач-2022” сургалт, Япон Улс

Япон Улсын Кобэ хотод байрладаг Азийн гамшгийн эрсдэлийг бууруулах төв (ADRC)-ийн “Зочин судлаач-2022” хөтөлбөрт Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн химич-судлаач, ахлах дэслэгч Б.Ариунтунгалаг хамрагдаж “A study on the issues to be considered in improving the requirements for evacuation shelter during disaster” сэдвээр судалгааны тайлан боловсруулж амжилттай дүүргэсэн.

“Тикийн гайхамшиг” туршлага, солилцох сургалт

Онцгой байдлын ерөнхий газар, Америкийн нэгдсэн улсын Элчин сайдын яам, Батлан хамгаалах хамтын ажиллагааны газартай хамтран “Тикийн гайхамшиг” хамтарсан дадлага, сургуулийг Увс аймагт Ховд, Говь-Алтай, Завхан, Увс аймгийн Онцгой байдлын газраас нийт 39 алба хаагчийг хамруулан зохион байгуулж, харилцан туршлага солилцож, мэргэжил ур чадвараа дээшлүүллээ.

Зураг 19.“Тикийн гайхамшиг” Туршлага солилцох, хамтарсан дадлага, сургууль

Далд уурхайд эрэн хайх, аврах ажиллагааны сургалт

Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах 09 дүгээр анги хамтран “Далд уурхайд эрэн хайх, аврах ажиллагаа”-ны сургалт, бэлтгэлийг Налайх дүүргийн “Эрдэнийн хөгжил” ХХК-ийн далд уурхайд зохион байгуулан, нийт 34 алба хаагчийг хамруулж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн.

Зураг 20. “Далд уурхайн эрэн хайх, аврах ажиллагаа”-ны хамтарсан сургалт:

Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны сургалт

Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах 09 дүгээр анги, хамтран “Өндөр уулнаас эрэн хайх, аврах

ажиллагаа”-ны сургалт, бэлтгэлийг Төв аймгийн Баян-Өнжүүл сумын нутаг дэвсгэр “Зоргол хайрхан”-д 2023 оны 10 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад харьяа, анги байгууллагуудын нийт 40 гаруй алба хаагч хамрагдаж, эгц ханан хадруу авирах, буух, өндрөөс нэрвэгдэгчдийг буулгах, ачаа хөнгөлж татах зэрэг дадлагыг хийв.

Зураг 21. “Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагаа”-ны хамтарсан сургалт

Урсгал болон тогтмол уснаас эрэн хайх, аврах ажиллагааны сургалт

Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Уул уурхайн аврах 09 дүгээр анги Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран “Урсгал болон тогтмол уснаас эрэн хайх, аврах ажиллагаа”-ны хамтарсан сургалт, бэлтгэлийг Налайх дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэр “Баян цагааны даваа”-ны урд Туул голын эргүүлэг гэдэг газар 2023 оны 10 дугаар сарын 12-13-ны өдөр зохион байгуулж, 11 алба хаагчдыг хамруулсан.



Зураг 22.“Урсгал болон тогтмол уснаас эрэн хайх, аврах ажиллагаа”-ны хамтарсан сургалт

Агаараас аврах нэгж байгуулах, нисгэгч бэлтгэх сургалт

Монгол Улсад Агаараас аврах нэгж байгуулах, нисгэгч бэлтгэх сургалтын хөтөлбөрийн дагуу эхний ээлжийн 4 сурагч нисгэгч, "Хэли-Юнион" компанийн багш нисгэгч Romain Cadet, Stephane Leroiux, David Busson, Dominic Heraud нарын удирдлага дор "Био-1", "Буянт-Ухаа" бүсэд сургалтын нислэгийг "Cabri G2" загварын нисдэг тэргээр нислэг, нислэгийн аюулгүй байдлыг ханган зохион байгуулсан. Онцгой байдлын байгууллагын анхны нисэх ангийн 10 нисгэгч, 12 инженер, техникийн мэргэжилтэн, агаараас эрэн хайх, аврах ажиллагааны багийг сурган дадлагажуулж, бэлтгэл, бэлэн байдал хангагдаж, үүрэг гүйцэтгэх чадавх дээшилсээр байна. Төслийн хүрээнд инженер, техникийн бүрэлдэхүүнийг бэлтгэх сургалтын хөтөлбөрийн дагуу "EC-145" загварын нисдэг тэрэгний мэргэшүүлэх сургалт, "EC-145" загварын нисдэг тэрэгний "Arriel-1" хөдөлгүүрийн мэргэшүүлэх сургалтыг тус тус зохион байгуулжээ. Бүгд Найрамдах Франц Улсын Иргэний хамгаалалтын газрын аврах ажиллагааны мэргэжилтнүүдтэй хамтран "Тэрэлж", "Буянт-Ухаа" бүсэд агаараас аврах ажиллагааны мэргэжилтэн, аврагч, яаралтай тусламжийн багийг бэлтгэх сургалтыг зохион байгуулж, сургалтад хамрагдсан алба хаагчдад БНФУ-ын Иргэний хамгаалалтын газраас сертификат гардуулсан байна.

Хот доторх эрэн хайх, аврах ажиллагааны чадавхыг сайжруулах сургалт

"Монгол Улсын Онцгой байдлын албаны хот доторх эрэн хайх, аврах ажиллагааны чадавхыг сайжруулах" төслийн хүрээнд сургагч багш бэлтгэх сургалтад 1, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сантай хамтран зохион байгуулагдсан "Гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ" сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтад 1, "Хяналт, шалгалт нэгдсэн арга хэмжээ" сэдэвт сургалтад 2, "Онцгой байдлын байгууллагын санхүүгийн ажилтан, нягтлан бодогч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх" сургалтад 1, Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын "Аврагч-химичин"-ийн мэргэшүүлэх сургалтад 1, "Аврагч-тэсэлгээчин"-ий мэргэшүүлэх сургалтад 1, Эрэн хайх, аврах нэгжийн Бүлгийн дарга-аврах ажиллагааны зааварлагч нарыг мэргэшүүлэх "Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч" сэдэвт сургалтад 1, Архивын ерөнхий газарт "Албан хэрэг хөтлөлт, архив"-ын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад 1 алба хаагч, нийт 8 мэргэшүүлэх сургалтад, 9 алба хаагчийг хамруулсан.

Алба хаагчдын ажил, үүрэг гүйцэтгэх сэтгэл зүй, бие бялдрын байнгын бэлэн байдал, ур чадварыг дээшлүүлэх сургалт

Онцгой байдлын албаны алба хаагчдын бие, бялдрын ерөнхий болон тусгай чанарыг хөгжүүлэх, цэргийн биеийн тамирын бэлтгэл сургалтыг төлөвлөлтийн дагуу зохион байгуулахад мэргэжлийн дэмжлэгээр хангаж, сургалтын чанарыг дээшлүүлэхэд анхааран ажилласан байна. Алба хаагчдын ажил, үүрэг гүйцэтгэх

сэтгэл зүй, бие бялдрын байнгын бэлэн байдал, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор цахим сургалтыг 2023 онд туухай өргөлт, усанд сэлэлт, бие бялдрын ерөнхий болон тусгай чанарыг хөгжүүлэх дасгал, цэргийн биеийн тамирын чиглэлээр 19 хичээлийг бэлтгэн цахим хэлбэрээр байршуулж, төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагын 36 байгууллагын 160 алба хаагчид хамрагдсан.

Зураг 23. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын цэргийн биеийн тамирын бэлтгэл сургалт

Энэхүү цахим группт “Цэргийн биеийн тамирын заавар”-ын (ЦБТЗ-18) дагуу бие бялдрын шалгуур үзүүлэлтийн стандартыг хангуулах зорилгоор бие бялдрын 5 чанарыг хөгжүүлэх дасгал хөдөлгөөнийг бэлтгэн байршуулж алба хаагчдыг бие даан биеийн тамираар хичээлүүлэх нөхцөлийг бүрдүүллээ.

“Монгол Улсын ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзлэг”-ийг зохион байгуулах зорилгоор “Цэргийн биеийн тамирын бэлтгэл, алба хаагчдын бие бялдрын ерөнхий болон тусгай чанарыг хөгжүүлэх” сэдэвт сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 01-02-ний өдөр Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/50 дугаар тушаалаар төв орон нутаг, нийслэлийн хүрээний газар, хэлтэс, ангийн орлогч дарга, орон тооны бус биеийн тамир, спортын зөвлөлийн гишүүд 75 алба хаагчдын дунд зохион байгуулсан.

1.4.3. Техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл, багаж хэрэгслийн хангалт

Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн мн/05 дугаар тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу техник, гал түймэр унтраах болон аврах ажиллагааны багаж зэвсэглэмж, холбоо зарлан мэдээллийн тоног төхөөрөмж, программ хангамж, хувцас хэрэглэл худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсанаар тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл техникийн хангалт 18.3 хувиар, хүн нэг бүрийн

аврах ажиллагааны хувцас хэрэглэлийн хангалт 10.4 хувиар нэмэгдсэн.

Мөн Япон улсын буцалтгүй тусламжаар гал түймэр унтраах нийт 113.0 сая төгрөгийн 5 нэгж техник хүлээн авч холбогдох газруудад хүлээлгэн өгсөн байна.

Зураг 24. Техник тоног төхөөрөмж, хувцас хэрэгслийн хангалт

Алба хаагчдын хуулиар хүлээсэн ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай 43 нэр төрлийн 43.5 мянган ширхэг дүрэмт хувцас, хэрэгслийг үйлдвэрлэж, нийлүүллээ. Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр ангийн алба хаагчдын тусгай зориулалтын хувцсыг 106 кг даац даах, 42339 эргэлтэд тэсвэртэй, 340 нэгж нягттай, гал дэмждэггүй, боловсруулалт бүхий даавуу материалаар инженер, техникийн алба хаагчдын өвөл, зуны хүрэм, өмд, нисгэгчийн өвөл, зуны комбинзон, аврагч, эмч, сувилагч нарын ажиллагааны хувцас, комбинзон, тусгай зориулалтын өвөл, зуны бээлий зэрэг 9 нэр төрлийн 132 ширхэг хувцсыг шинээр туршин үйлдвэрлэж, нийт 2.6 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

Зураг 25. Тусгай зориулалтын хувцсыг туршин, үйлдвэрлэсэн байдал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн барилга, байгууламж, засвар үйлчилгээ

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар Онцгой байдлын ерөнхий газрын Мэргэжлийн сургалтын төвийн барилга угсралтын ажилд 2.0 тэрбум, Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын өргөтгөлийн барилга угсралтын ажилд 2.7 тэрбум, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Онцгой байдлын хэлтсийн барилгад 2.7 тэрбум, нийт 7.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж, барилга угсралтын ажил бүрэн хийгдсэн байна.

Мөн төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын барилга, байгууламжинд шаардлагатай урсгал засварт 1.7 тэрбум төгрөгийг шийдвэрлэж, барилга байгууламжийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллажээ.

Зураг 26. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн бүтээн байгуулалт

Гал түймэр унтраах, аврах 1 дүгээр зэргийн ангийн үндсэн болон туслах албаны автомашины тавиулан, цутгамал төмөр бетон хийц бүхий 7 давхар, 500 хүний хурлын заал, 170 гаруй өрөө тасалгаатай, гурван блокоос бүрдсэн иж бүрэн цогцолбор барилгыг улсын төсвийн 21.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр бариулан ашиглалтад оруулснаар алба хаагчдын ажиллах нөхцөл сайжирсан.

Зураг 27. Онцгой байдлын газар, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн шинэ байрны нээлтийн ажиллагаа

1.4.4. Тэмцээн уралдаан, бусад арга хэмжээний талаар

2023 оны Шилдэг бүтээл

Онцгой байдлын байгууллагын 2023 оны эрдэм шинжилгээний “Шилдэг бүтээл”-ээр Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах 4 боть судалгаа”-ны бүтээл шалгарч тус бүтээлийг Эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд хурандаа П.Чимэдцэрэн, эрдэм шинжилгээний ажилтан, ахмад Т.Өсөхжаргал, төвийн дарга, хошууч Э.Энхбат,

Гамшиг судлалын төвийн Эрдэм шинжилгээний ажилтан, хошууч С.Солонго нар хамтран судалж, боловсруулсан ба бүтээл нь газар хөдлөлтийн гамшгийн үеийн эрх зүйн орчин, төлөвлөлтийн өнөөгийн байдал, сайжруулах боломж, газар хөдлөлтийн үеийн эрэн хайх, аврах ажиллагааны чадавхад хийсэн үнэлгээ, газар хөдлөлтийн гамшгийн үеийн талуудын хамаарал, нөлөөллийн судалгаа, гамшгийн үеийн Гамшгаас хамгаалах улсын албад, иргэдийн бэлэн байдлын өнөөгийн байдлын судалгаа гэсэн дөрвөн багц судалгаа юм. Судалгааны үр дүнгээр хэд, хэдэн эрх зүйнзохицуулалтын баримт бичигт өөрчлөлт шинэчлэлт оруулахаар санал хүргүүлж, ажлын хэсэг гарган ажилласан байна.

Зураг 28. Шилдэг бүтээлийн шагнал гардуулах ажиллагаа

Гамшиг судлалын төвийн эрхлэгч, доктор, дэд хурандаа Б.Саранцэцэг Хууль зүй дотоод хэргийн сайдын нэрэмжит “Гранд олгох төсөл” -ийн Тэргүүн байрт шалгарсан байна.

Зураг 29. доктор, дэд хурандаа Б.Саранцэцэг

Тэмцээн уралдаан:

Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотод зохион байгуулагдсан Дэлхийн аврагч, гал сөнөөгчдийн 18 дахь удаагийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр "Бурхан фэлэк" цэнгэлдэх хүрээлэнд тэмцээний нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж, Тэмцээнд Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Беларусь улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Исламын Бүгд Найрамдах Иран Улс, Бүгд Найрамдах Узбекстан Улс, Бүгд Найрамдах Казакстан Улс, Бүгд Найрамдах Австри Улс, Бүгд Найрамдах Азарбайжан Улс, Бүгд Найрамдах Камерун Улс, Бүгд найрамдах Болгар, Бүгд Найрамдах Словак Улс, Саудын арабын хаант Улс, Монгол Улсын нийт 14 баг оролцсон.

Довтолгооны шатны тэмцээний төрөлд Монгол Улсын шигшээ баг, багийн нийлбэр дүнгээр 6-р байр, Саадтай 100 м-ийн гүйлтийн тэмцээний төрөлд Монгол Улсын шигшээ баг, багийн нийлбэр дүнгээр 5-р байрыг эзлэв.

Зураг 30. БНТУ Истанбул хот Дэлхийн аварга

Тус тэмцээнд Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах 21 дүгээр ангийн аврагч, гал сөнөөгч ахлах ахлагч Б.Энх-Оргил 16:30 секундийн амжилт үзүүлж, Олон Улсын хэмжээний мастер цолны болзол хангасан бол 4х100 м-ийн буухиа тэмцээний төрөлд Монгол улсын шигшээ багийн 1 дүгээр багийн тамирчид 57:77 секундийн амжилтаар Монгол Улсын дээд амжилтыг шинэчлэн тогтоожээ.

Нийслэлийн Онцгой байдлын газрын Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн ГТУА-10 дугаар ангийн аврагч, гал сөнөөгч ахлах ахлагч Б.Буянбат, Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын ГТУА-22 дугаар ангийн аврагч, гал сөнөөгч дэд ахлагч С.Төрбат, Булган аймгийн Онцгой байдлын газрын ГТУА-20 дугаар ангийн аврагч, гал сөнөөгч ахлах ахлагч Б.Мөнх-Эрдэнэ нар Олон Улсын хэмжээний мастер цолны болзол хангасан. Тус тэмцээнд нийлбэр дүнгээр Монгол улсын шигшээ баг 7 дугаар байрт шалгарсан байна.

Зураг 31. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын уралдаан, тэмцээний амжилтууд

Аврагч биеийн тамир техник спортын хороо 120 дугаар ангийн баг тамирчид 2023 онд дотоод, гадаадын тэмцээнүүдээс алтан медаль 24, мөнгөн медаль 15, хүрэл медаль 14 тус тус хүртэн өндөр амжилт үзүүллээ. Үүнд:

Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс боксын тамирчин ахлах ахлагч Б.Мишээлт 67 кг-ын жинд хүрэл медаль, ахлагч Л.Алтанцэцэг 48 кг-ын жинд мөнгөн медаль, буудлагын төрөлд тамирчин ахлагч Т.Баярцэцэг, сонгомол гар бууны 50 метрийн төрөлд мөнгөн медаль, “Ханжоу 2022” Азийн 19 дүгээр наадмын боксын төрөлд дэд ахлагч О.Есүгэн алтан медаль хүртэж, Парис 2024 олимпийн наадамд оролцох эрх авсан.

Азийн аварга шалгаруулах тэмцээнээс тамирчин ахлагч Г.Анужин алтан медаль, Үндэсний их баяр наадмын барилдаанд тамирчин ахмад Монгол Улсын аварга О.Хангай их шөвгийн 4 шалгарсан байна.

Зураг 32. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын тэмцээн, уралдааны амжилтууд

Гал унтраах техникийн олон төрөлт спортын Улаанбаатар бүсийн “Гандуулга’ клубийн 2023 оны аварга шалгаруулах тэмцээн Багануур дүүрэгт 2023 оны 06 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж, шилдгүүдийг тодруулж, тэмцээний аваргаар Дотоод хэргийн Их сургуулийн баг тамирчид шалгарчээ.

Тэмцээний довтолгооны шатны төрөлд Алтан медалийг УБТЗ-ын Цэрэгжүүлсэн Гал унтраах ангийн Н.Пүрэвдаш, мөнгөн медалийг ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн Аюулгүй байдлын үнэлгээний төвийн дарга олон улсын хэмжээний мастер, хошууч Э.Энхбат, хүрэл медалийг Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах 10 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч Г.Цогтбаяр,

Саадтай 100 метрийн төрөлд алтан медалийг УБТЗ-ын Цэрэгжүүлсэн Гал унтраах ангийн С.Мөнх-Эрдэнэ, мөнгөн медалийг ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн төвийн дарга олон улсын хэмжээний мастер, хошууч Э.Энхбат, хүрэл медалийг ДХИС-ийн сонсогч, Д.Раднаабазар, 4х100 метрийн буухиа гүйлтийн төрөлд алтан медалийг Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах 10 дугаар анги, мөнгөн медалийг ДХИС-ийн баг, хүрэл медалийг мөн ДХИС-ийн баг,

Зураг 33. Гандуулга

Байлдааны тархалтын төрөлд алтан медалийг Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн ГТУА 26 дугаар анги, мөнгөн медалийг Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн ГТУА 10-р анги, хүрэл медалийг УБТЗ-ын Цэрэгжүүлсэн Гал унтраах ангийн баг тамирчид,

Хоёр төрөлтөд алтан медалийг ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн дэргэдэх, олон улсын хэмжээний мастер, хошууч Э.Энхбат, мөнгөн медалийг УБТЗ-ын Цэрэгжүүлсэн Гал унтраах ангийн Н.Пүрэвдаш, хүрэл медалийг Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах 10-р ангийн салааны захирагч, дэслэгч Г.Цогтбаяр тус тус хүртлээ.

1.5.5 Алба хаагчдын нийгмийн баталгаа, эрүүл мэнд хамгаалал

Нийгмийн баталгааны чиглэлээр:

Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр 7 алба хаагчид орон сууцны дэмжлэг 54.0 сая төгрөг, эмчилгээний зардалд 5 алба хаагчдад 17 сая төгрөг,

албан үүргээ гүйцэтгэх явцад амь насаа алдсан 2 алба хаагчийн ар гэрт 10 жилийн үндсэн цалинтай тэмцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж, ослын улмаас нас барсан 1 алба хаагчийн ар гэрт 3 жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг тус тус олгосон.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 188 дугаар тогтоолд “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа алба хаагчид мөнгөн урамшуулал олгох” гэж заасны дагуу нэг удаагийн мөнгөн урамшууллыг 400 алба хаагчдад нийт 7.6 тэрбум төгрөгийг олгосон. Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2024 онд улсын төсөвт 3.9 тэрбум төгрөгийг суулгаж батлуулаад байна.

Төрийн тусгай албан хаагчдын цалингийн зэрэглэлд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 488, 2023 оны 241 дүгээр тогтоолоор 2 удаа өөрчлөлт орсонтой холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын тушаалаар албан тушаалын ангилал зэрэглэлд өөрчлөлт оруулж, алба хаагчдын цалин, хөлс 2022 онтой харьцуулахад дунджаар 55.0 хувиар нэмэгдсэн.



Зураг 34. Алба хаагчдын нийгмийн баталгаа

Эрүүл мэндийн чиглэлээр:

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэгийг жил тутамд зохион байгуулдаг бөгөөд 2023 онд нийт алба хаагчдын 85 хувь нь 2-р шатлалын эмнэлгүүдэд багажийн болон дэлгэрэнгүй шинжилгээнүүдэд орж нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамрагдсан.

Мөн Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг өөрсдийн эмч нарын нөөцөд тулгуурлан 2 жил тутамд зохион байгуулдаг бөгөөд Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/342 дугаар тушаалаар 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулж зүүн бүсийн Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын ажилтан, алба хаагч, ахмад настан, гэр бүлийн хамтаар хамрагдлаа.

Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын Эрүүл мэндийн тасаг алба хаагчдын эмчлэх үйлчлэх зорилгоор сэргээн засах өрөөг тохижуулж, Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв-119 дүгээр ангийн нийт давхардсан тоогоор 425 алба хаагчдад эмчийн үзлэг, оношилгоо, 352 алба хаагчдад эмийн болон сэргээн засах, уламжлалтын эмчилгээ үйлчилгээг хийж үйлчилсэн байна.

ОБЕГ-ын Сэргээн засах өрөөний тохижилт

Тус тасгаас 2023 оны 7-р сард Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт үүссэн үерийн гамшгийн голомтод ажилласан Онцгой байдал, Зэвсэгт хүчин, Цагдаа, дотоодын цэргийн 500 гаруй алба хаагчдад эрүүл мэндийн тасгаас эмч нарын баг гарган үзлэгийг зохион байгуулж, эрүүл мэндийн тусламж болон эмийн үйлчилгээг үзүүлсэн.

Зураг 35. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг

БҮЛЭГ 1.5. ГАМШГААС ХАМГААЛАХ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИ

1.5.1. Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологи, эрдэм шинжилгээний зөвлөл, багийн үйл ажиллагаа

Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх орон тооны бус Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн ээлжит хуралдаануудаар Онцгой байдлын ерөнхий газрын захиалгаар Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтээр Одон орон геофизикийн хүрээлэнд хийгдсэн "Улаанбаатар хот болон түүний орчмын нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн идэвхжлийн судалгаа"-ны ажлын явцын болон эцсийн тайлангуудыг хэлэлцлээ.

Мөн Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн тушаалаар байгуулагдсан "Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн дэргэдэх Шинжлэх ухаан технологи, инновацын дэд зөвлөл", хурандаа генерал С.Равдангийн нэрэмжит "Гамшгийн эрсдэлийг бууруулах" үндэсний шагналын асуудлыг тус тус хэлэлцсэн байна.

Зураг 36. Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хуралдаан

Онцгой байдлын ерөнхий газрын шинжлэх ухаан технологийн зөвлөл, Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг "Гамшиг судлал, инновац" сэтгүүлийн 2023 №1 (10), 2023 №2 (11) дугааруудыг хэвлүүлж, нийтийн хүртээл болгосон. Сэтгүүлд ирүүлсэн гамшгаас хамгаалах чиглэлийн эрдэм шинжилгээний бүтээлүүдийг тус зөвлөлийн эрдэмтдээр хянан магадлагаа хийлгэн, журамд заасан шаардлага хангасан бүтээлүүдийг хэвлэн нийтэлж байна.





Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн “Эрдмийн зөвлөл”-ийн үйл ажиллагаа

Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн “Эрдмийн зөвлөл” 2023 онд 4 удаа хуралдаж нийт 9 судалгааны эцсийн тайлан, 5 судалгааны явцын тайланг хэлэлцэж, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй явуулахад дэмжлэг үзүүлсэн байна.

Зураг 37. Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл

Гамшгаас хамгаалах “ЦАГААН НОМ-2022”-ыг Англи, Монгол хэлээр бэлтгэн Гамшиг судлалын үндэсний хүрээлэнд боловсруулан, Урьдчилан сэргийлэх газар хэвлэж нийтийн хүртээл болгоод байна.

Онцгой байдлын сургуулийн Гамшиг судлалын профессорын багийн үйл ажиллагаа

Гамшиг судлалын профессорын судалгааны баг 2023 оны хичээлийн жилд нийт 4 удаа хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар "Онцгой байдал-Гамшиг судлал" хөтөлбөрийн суралцагч 2 докторант, 9 магистрантын судалгааны ажлын сэдэв, эрдэм шинжилгээний ажлын удирдагч томилох,

2. 2023 оны 04 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд "Онцгой байдал-Гамшиг судлал" хөтөлбөрийн суралцагч 16 магистрантын судалгааны ажлын урьдчилсан хамгаалалт,

3. 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Их сургуулийн 90 жилийн ойг тохиолдуулан шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал О.Үржинд Дотоод хэргийн их сургуулийн "Хүндэт профессор" цолны болзол хангасан тухай хурлын шийдвэр, 2 докторантын судалгааны ажлын явцыг хэлэлцэж, "Ар тал, хангалтын үндэс" сурах бичиг, "Сургалтын тоглолт хөтлөн явуулах арга зүй" "Судалгааны арга зүй" гарын авлага, "Гамшгийн эрсдэлийн менежмент" нэгэн сэдэвт бүтээл зэрэг нийт 6 гарын авлага, 1 сурах бичиг, нэг сэдэвт бүтээлийн агуулга, бүтцийг хэлэлцэн санал, зөвлөмж өгч ажилласан.

1.5.2. Эрдэм шинжилгээ, судалгаа, иновацийн үйл ажиллагаа

Гамшиг судлалын үндэсний хүрээлэн 2005-2023 онд нийт 142 судалгааны ажлыг хийж гүйцэтгэн, гамшиг судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулахад дэмжлэг үзүүлээд байна.

Тус хүрээлэнгээс эрдэм шинжилгээний ажилтан, алба хаагчид болон гамшиг судлалын чиглэлээр судалгааны ажил хийдэг судлаачдын бүтээлийг эмхэтгэн гаргасан ном, сэтгүүл, судалгаа, гарын авлага, заавар зэргийг цахим хэлбэрт хөрвүүлэн хүрээлэнгийн цахим хуудас, хаягт байршуулан нийтийн хүртээл болгосон байна.



Зураг 38. Гамшиг судлалын хүрээлэнгийн 2005-2023 онд гүйцэтгэсэн судалгааны ажил

Гамшиг судлалын үндэсний хүрээлэн 2023 онд Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдал, газар хөдлөлтийн үеийн гамшгийн үеийн удирдлага зохицуулалт, хариу арга хэмжээ, салбар хоорондын харилцан хамтын ажиллагааны чиглэлээр дараах судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэж, тайланг холбогдох газруудад хүлээлгэн өгсөн байна. Үүнд:

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны захиалгаар "Онцгой байдлын байгууллагын эмэгтэй алба хаагчдын оролцоог энхийг дэмжих ажиллагаа болон аюулгүй байдлын салбарт нэмэгдүүлэх боломж" сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Судалгааны ажлын хүрээнд 649 алба хаагчаас асуулга судалгаа авч боловсруулалт хийж, судалгааны үр дүнг салбар дундын хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний бага хурлаар тус тус хэлэлцүүлж, тайланг Онцгой байдлын ерөнхий газарт танилцуулж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүлээлгэн өгөв.

Онцгой байдлын ерөнхий газраас Гамшиг судлалын үндэсний хүрээлэнд захиалсан захиалгат судалгааны бүтээлийн хувьд::

"Монгол Улсын гамшгаас хамгаалах улсын алба, байгууллага, иргэд, олон нийтээс газар хөдлөлтийн гамшгийн үеийн бэлэн байдал, харилцан ажиллагааны талаар авсан асуумж судалгааны үр дүн", "Газар хөдлөлтийн гамшгийн үеийн удирдлага, зохицуулалтын өнөөгийн байдлын судалгаа", "Гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт түүний хэрэгжилтэд хийсэн шинжилгээ", "Гамшгийн үед ашиглах түр байрны өнөөгийн байдал, сайжруулах боломж", "Улаанбаатар хот болон түүний орчмын нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн идэвхжилтийн судалгаа", "Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажилллагаа", Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын сэтгэл зүй, хандлага, ёсзүйн өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ" сэдэвт судалгааны ажлуудын эцсийн тайланг танилцуулан, захиалагч талуудад хүлээлгэн өгөв.



Зураг 39.Үнэлгээ шинжилгээний тайлан

Стратегийн команд штабын сургалтын үеэр “Иргэд болон төрийн байгууллагуудаас авах асуулга судалгаа”-г боловсруулан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс нийт 2606 асуумжийн судалгаа, гамшгаас хамгаалах албадаас 2336 иргэдээс судалгаа авч тайланг боловсруулж хүлээлгэн өгсөн байна.

Иновацийн үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын цахим бодлогыг хэрэгжүүлж, цахим системийг хөгжүүлэх хүрээнд “И-Монголиа” аппликейшнээр дамжуулан гамшгийн яаралтай тусламжийн дуудлага мэдээллийг Монгол улсын 21 аймаг, 330 сум, 1568 баг, 9 дүүрэг, 152 хорооны нутаг дэвсгэрийн аль ч газраас иргэд өөрийн байгаа газрын хаяг, байршлаа мэдэхгүй, координат өгөх боломжгүй тохиолдолд өөрийн гар утсандаа суулгасан “what3words” апп-г ашиглан 3 үгт хаягаар байршлаа зөв өгөх боломж бүрдүүлснээр иргэдийн амь насыг аврах, яаралтай тусламж авах нөхцлийг хангалаа.



Зураг 40. Байршлыг илэрхийлэх what3words аппликейшинг гар утсанд суулгах заавар

Хэрэв та байршлаа илэрхийлэх үед гар утсандаа what3words аппликейшныг суулгаж амжаагүй бол таны холбогдож байгаа Онцгой байдлын байгууллагын Холбоо зарлан мэдээлэл хариуцсан оператор таны гар утас руу мессежээр тусгай холбоос илгээх бөгөөд та тус холбоос руу орж гарч ирсэн гурван үгийг ашиглан байршлаа илэрхийлэх боломжтой юм.

Усны ослоор амь насаа алдах эрсдэлийг бууруулах зорилгоор “Усны ослын шалтгаан, эрсдэлийн судалгааны ажлын үр дүнг хэрэглээнд нэвтрүүлж, Улаанбаатар хот, Төв аймгийн нутаг дэвсгэрт Туул голын эрэг дагуух эрсдэл өндөртэй газруудад усны ослын статистик мэдээлэл, байршил заах гурван үгт хаяг, усны гүний мэдээлэл, үерийн усны түвшин хэмжих багана, анхны тусламжийн хайрцаг зэрэг тоноглолтой сэрэмжлүүлэг самбарыг байршуулж, богино хэмжээний видео бичлэг хийж олон нийтэд сурталчилан 78 иргэнд болон өөрийн цахим хуудсаар 2000 иргэнд хүргэж, энэ судалгааны туршлагыг 21 аймагт хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж, холбогдох зардлыг аймаг, сум бүрийн 2024 оны жилийн төсөвт тусгуулах арга хэмжээг авлаа.



Зураг 41 .Эрсдэлийг бууруулах Сэрэмжлүүлэг самбар

Монгол Улсын үндэсний баялаг мал аж ахуйн салбарыг Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулах, дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйн чиглэлийн судалгаа шинжилгээний хүрээлэнгүүдтэй 21-р зуунд нүүдлийн мал аж ахуйг хөгжүүлэх, эрсдлээс хамгаалах нэгдсэн судалгааг хийж, 1990 оноос хойш хийгдээгүй байсан малчдын өвөлжөө, хаваржааны хашаа саравчийг сайжруулж шинэ шатанд гаргахын тулд 21.0 сая төгрөгийн өртөг бүхий “ӨВӨЛЖӨӨ” төслийг боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их хурлын дарга,

Зураг 42. Өвөлжөө төсөл

Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн дугаар 04 тоот тушаалыг гарган ЗГХЭГ-ын даргад танилцуулж ажилласан байна.

Лабораторийн туршилт, шинжилгээ

2023 онд шүүх, цагдаагийн байгууллагаас ирүүлсэн 303 тогтоолоор 563 дээжинд шинжилгээ хийж, шинжээчийн 303 дүгнэлт гарган, хавтаст хэргийн 10 материалтай танилцан шинжээчийн дүгнэлт гаргасан байна.

Аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хүсэлтээр тоног төхөөрөмж, барилгын зориулалттай материалын 332 дээжинд шинжилгээ хийж, 332 лабораторийн сорилтын дүнг гаргасан.

Зураг 43. 2006-2023 онд Галын лабораторид ирүүлсэн материалын галын аюулын үзүүлэлтийг тодорхойлуулах хүсэлт болон шинжилгээ хийсэн бүтээгдэхүүний тоо

Химийн лаборатори нь төв орон нутгийн Цагдаагийн газраас “Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тухай” 75 мөрдөгчийн тогтоолын дагуу ирүүлсэн 136 дээжийг хүлээн авч, шинжлэн 75 шинжээчийн дүгнэлт гаргасан байна.

1.5.3. Эрдэм шинжилгээний болон онол практикийн хурал

“Уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн байдал, эртнээс сэрэмжлүүлэх үндэсний бодлого, шийдэл, арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хурал

Хүн төрөлхтний өмнө тулгамдаад байгаа цаг уурын өөрчлөлт, олон төрлийн аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, даван туулахад төр засаг, ард иргэд, эрдэмтэн мэргэд, хэвлэл мэдээлэл зэрэг бүх талуудын түншлэлийг сайжруулж, хамтран ажиллах, соён гэгээрүүлэх, нэгдмэл ухамсрыг төлөвшүүлэх зорилгоор Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханы санаачлагаар “Уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн байдал эртнээс сэрэмжлүүлэх үндэсний бодлого: Асуудал, шийдэл, гарц” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгээс Төрийн ордонд зохион байгууллаа.

Зураг 44. Уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн байдал эртнээс сэрэмжлүүлэх үндэсний бодлого: Асуудал, шийдэл, гарц” сэдэвт эрдэм шинжилгээний хурал

Эрдэм шинжилгээний хуралд Монгол Улсын Шадар сайд, НҮБ, ОБЕГ, БОАЖЯ, Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн, Үндэсний Аюулгүй Байдлын Стратеги судалгааны хүрээлэн, ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн мэргэжилтэн болон бусад эрдэмтэн судлаачид оролцож, илтгэл хэлэлцүүллээ.

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян “Уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн нөхцөл байдал сэдэв”-ийн хүрээнд тавьсан илтгэлдээ:

Монгол Улсын хэмжээнд 2022 оны байдлаар нийт 4321 удаагийн аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 401 /154 Ковид-19/ хүн амь насаа алдаж, 173 хүн гэмтэж бэртэн 8553 толгой мал, амьтан хорогдож, 33.2 тэрбум төгрөгийн шууд хохирол учирч, 2004-2013 онд жилд дунджаар 3104 аюулт үзэгдэл, осол тохиолддог байсан бол 2013-2022 онд жилд дунджаар 4529 болж нэмэгдсэн талаар онцолсон. Харин Ус, Цаг уур, Орчны судалгаа, мэдээллийн

хүрээлэнгийн захирал Г.Сарантуяа "Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт нь Монгол нутагт уур амьсгалын үндсэн үзүүлэлт болох агаарын хэм, хур тунадас зэрэг элементээр төдийгүй цөлжилт, экосистемийн доройтлоор нэн тод илэрч байна" хэмээгээд Монгол орны нутагт жигд шахам тархан байрласан цаг уурын 47 өртөөний өгөгдлөөс үзвэл 1940 оноос хойш 64 жилийн дотор агаарын дундаж хэм 1.8°С-ээр нэмэгдсэнээс өвөл 3.6°С-ээр, намар 1.3°С-ээр, зун 0.5°С-ээр тус тус дулаарсан талаар танилцуулав.

"Гамшгаас хамгаалах сургалтын өнөөгийн байдал, хүртээмж, үр нөлөө" сэдэвт онол, практикийн бага хурал

Гамшиг судлалын үндэсний хүрээлэн Монголын Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран өдөр "Гамшгаас хамгаалах сургалтын өнөөгийн байдал, хүртээмж, үр нөлөө" сэдэвт онол, практикийн бага хурлыг 2023 оны 5 дугаар сарын 05-ны амжилттай зохион байгууллаа. Тус хурлыг зохион байгуулах ажлын хүрээнд 2022, 2023 оны онол, практикийн бага хуралд ирүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллүүдийг нэгтгэн, "Онол, практикийн бага хурлын эмхэтгэл 2022-2023" номыг эмхэтгэн хэвлүүлж нийтийн хүртээл болгосон.

Зураг 45. "Гамшгаас хамгаалах сургалтын өнөөгийн байдал, хүртээмж, үр нөлөө" сэдэвт онол, практикийн бага хурал

Эрдэм шинжилгээний хуралд ҮБХИС, СЭЗДС, ХААИС, УЦУОСМХ, Стратеги судалгааны хүрээлэн, Батлан хамгаалах ЭШХ, Хил судлалын хүрээлэн, Эрсдэл судлалын төв ТББ болон олон улсын байгууллагын 60 гаруй төлөөлөл оролцож, илтгэл хэлэлцүүлсэн юм.

Хэлэлцүүлсэн илтгэлүүдээс гарсан санал, дүгнэлтэд үндэслэн байгалийн гамшгаас үүсэх эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхэд талуудын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх зөвлөмж гаргасан байна.

“Гамшгийн үеийн хариу арга хэмжээ, удирдлага зохион байгуулалт, талуудын оролцоо” сэдэвт эрдэм шинжилгээний хурал

Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгээс “Шинжлэх ухааны ажилтны өдөр”-ийг угтан “Гамшгийн үеийн шуурхай хариу арга хэмжээ, удирдлага, зохион байгуулалт, талуудын оролцоо” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 11-р сарын 23-ны зохион байгууллаа.

Эрдэм шинжилгээний хуралд Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, бригадын генерал Б.Ууганбаяр, Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд хурандаа П.Чимэдцэрэн нар “Монгол Улсын гамшгийн үеийн хариу арга хэмжээний эрхзүйн зохицуулалт, удирдлага зохион байгуулалт, талуудын оролцооны өнөөгийн байдал”, ОБЕГ-ын Ажиллагааны удирдлагын газрын хэлтсийн дарга, хурандаа Б.Мягмардорж “Монгол Улсын гамшгийн үеийн шуурхай арга хэмжээг зохион байгуулах төлөвлөлтийн асуудалд”, ОБЕГ-ын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Ч.Ариунаа “Монгол Улсын зудын эрсдэлийн удирдлага, эрт арга хэмжээ”, Престиж инженеринг ХХК-ийн захирал Ш.Ганзориг “Улаанбаатар хотын үерийн эрсдэлийн нөхцөл байдал”, ОБЕГ-ын Гал түймэртэй тэмцэх газрын ахлах мэргэжилтэн, хошууч Н.Отгонбаяр “Гал түймэр унтраах үйл ажиллагааны зохион байгуулалт, туршлага, сургамж”, ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын хэлтсийн дарга Э.Оюунсүрэн “Коронавируст халдварт цар тахлын үеийн Эрүүл мэндийн салбарын бэлэн байдал” , Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн ажилтан, ахмад Т.Өсөхжаргал “Гамшгаас хамгаалах аюулгүй талбайг стандартчилах хэрэгцээ шаардлага”, мөн хүрээлэнгийн Мэдээллийн технологи, инновацын төвийн дарга, дэд хурандаа Д.Содномрагчаа “Гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашины давчуу орон зайд зорчих боломжийг судалсан дүнгээс” сэдвийн хүрээнд илтгэл хэлэлцүүллээ.

Зураг 46. Эрдэм шинжилгээний бага хурал

“Эрсдэлд суурилсан тогтвортой хөгжил” олон улсын эрдэм шинжилгээний хурал

Дотоод хэргийн их сургууль, Монголын Улаан Загалмай нийгэмлэг хамтран “Эрсдэлд суурилсан тогтвортой хөгжил” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Монголын Улаан Загалмай нийгэмлэгийн Хүүхэд, залуучуудын хөгжлийн төвд зохион байгууллаа. Хурлаар гадаад болон дотоод эрсдэлээс сэргийлэх, тогтвортой хөгжилд нөлөөлөх хүчин зүйл, аюулгүй байдал, хөгжил судлал, эрсдэл судлалын хөгжил, түүний чиг хандлага, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэн сахих, хэрэгжүүлэх, эрсдэлд суурилсан хөгжлийн орчин үеийн дэвшилтэт технологи, судалгаа-шинжилгээний ололтыг нэвтрүүлэх, онол ба практикт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлохын зэрэгцээ олон улсын байгууллага, их, дээд сургуулиудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтарсан судалгааны ажил гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, улмаар улс орны төдийгүй дэлхий нийтийн өмнө тулгамдсан асуудалд гарц, шийдэл дэвшүүлснээрээ онцлогтой байв.

Зураг 47. Эрсдэлд суурилсан тогтвортой хөгжил” олон улсын эрдэм шинжилгээний хурал

ХОЁРДУГААР ХЭСЭГ.

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ

БҮЛЭГ 2.1 ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1.1 Урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт

Улсын хэмжээнд 2023 онд Монгол Улсын Шадар сайдын баталсан 5, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан 7 удирдамжийн хүрээнд урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгууллаа.

Хяналт шалгалтын ажлын хүрээнд хуулийн этгээдийн **16.1** мянган барилга байгууламж, **158.7** мянган айл өрхийг хамруулан **89.8** мянган зөрчлийг илрүүлж, **48.9** мянган зөрчлийг газар дээр нь арилгуулж, зөрчлийг арилгуулахаар гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага **5054**, мэдэгдэл **4055**, танилцуулга **189**, зөрчлийн тэмдэглэл **1322** боловсруулж иргэн, хуулийн этгээдэд хүргүүлсэн байна. Гал түймрийн улсын хяналтын байцаагч нар **39** хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, нийт **307.7** сая төгрөгийн торгуулийн шийтгэл оногдуулсан байна.

2.1.2. Олон нийтэд зориулсан гамшгаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ

Гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал нэгдсэн арга хэмжээ”, “Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”, ”Шар усны үерээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”, “Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”, “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөрлөг”, “Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдөрлөг”, “Олон улсын Иргэний хамгаалалтын өдөрлөг” нийт 7 төрлийн нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийн удирдамжийг Монгол Улсын Шадар сайдаар батлуулан 2023 онд зохион байгууллаа.

Зураг 48. Удирдамжийн мэдээлэл

“Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”

“Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ний хүрээнд гэр хорооллын айл өрхийн пийшин, зуух, яндан, цахилгаан эрчим хүчний ашиглалтын үеийн галын аюулгүй байдлыг хангуулах ажлыг олон нийтэд өргөн хүрээтэй сурталчлан таниулах, объектын гал түймрийн тоо хохирлыг бууруулах зорилгоор “Галын аюулаас сэргийлье” цахим аяныг зохион байгуулсан. Энэ хүрээнд “ОБЕГ-ын Урьдчилан сэргийлэх газар” фэйсбүүк пэйж хуудсанд “Ахуйн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх” 52 төрлийн сэрэмжлүүлэг мэдээ мэдээлэл (постер 44, рийл 8)-ийг байршуулж, давхардсан тоогоор нийт 4,355,715 хүний хандалт авч, мэдээлэл хүргэн ажилласан.



Зураг 49. Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний үзүүлэлт

Монгол Улсын 330594 өрх гэрт, 320360 өрх сууцны байшинд нийт 650954 айл өрх гэр хорооолд амьдарч байгаагийн 241878 буюу 37.1 хувьд гал түймрийн аюулгүй байдлын талаар ухуулга, сурталчилгаа хийж, холбогдох стандарт, норм, норматив хэрэгжүүлэхийн ач холбогдол, эрсдэлийг тайлбарлан таниулж ажилласан.

“Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”

“Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ний хүрээнд нийслэл, орон нутгийн 41 телевизэд 123 удаа цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж, сэрэмжлүүлэг, анхааруулга, мэдээлэл ярилцлага өгч ажилласан.

Зураг 50. Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний үзүүлэлт

“Олон улсын иргэний хамгаалалтын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх аян”

“Олон улсын иргэний хамгаалалтын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх аян”-ы удирдамж, Олон улсын иргэний хамгаалалтын байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн “Ирээдүй хойч үеийнхээ аюулгүй байдлын төлөө дэлхийн тэргүүлэх салбарын мэргэжилтнүүдийг нэгтгэе” уриалгын хүрээнд “Хүүхдэд учирч болох бүх төрлийн эрсдэлийг бууруулах ойлголтыг олгох”, “Аюулгүй амьдрах ухаан”, “Анхны тусламж” сэдэвт танхимын болон цахим сургалтыг нийт 156 удаа, 8028 иргэдийг хамруулсан.

Мөн аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар хэлтсүүдийн цахим сайт болон фэйсбүүк пэйж хуудас, өдөр тутмын мэдээллийн сайт, сонин, телевиз, олон нийтийн сүлжээ, бүх шатны Засаг даргын Тамгын газар болон томоохон худалдааны төвийн гадна байрлах ЛЕД дэлгэцүүдээр сурталчилж, давхардсан тоогоор 1.3 сая гаруй иргэнд хүргэж ажилласан.

“Шар усны үерээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, ярилцлагыг давхардсан тоогоор 85 удаа төв, орон нутгийн телевизэд, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар хэлтсүүдийн цахим сайт болон фэйсбүүк пэйж хуудсаар 668 удаа дамжуулан давхардсан тоогоор 1.3 сая гаруй иргэнд хүргэж, ажилласан. Мөн шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх 8 төрлийн сэрэмжлүүлэг мэдээ мэдээлэл (постер 7, рийл 1)-ийг “ОБЕГ-ын Урьдчилан сэргийлэх газар” фэйсбүүк пэйж хуудсанд байршуулж, нийт 777,490 хүнд мэдээлэл хүрсэн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газраас цаг агаарын мэдээг 7 хоногоор нарийвчлан гаргуулж “Мобиком”, “Скайтел”, “Юнител”, “Жи-Мобайл” үүрэн телефоны оператор компанийн давхардсан тоогоор нийт 2.402.108 хэрэглэгчийн гар утсанд багц мессежээр малчид, иргэдэд тухай бүр нь сэрэмжлүүлэг, мэдээллийг хүргэн ажиллав.

“Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”

“Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-г улсын хэмжээнд 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл улсын хэмжээнд зохион байгуулж, төв, орон нутагт мэргэжлийн зөвлөмж хүргүүлэн, төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсээс 2915 алба хаагч 38 завьтай 37 гол, нуурын эрэг дагуу 52,598 км хөдөлгөөнт эргүүл хийсэн

Зураг 51. “Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ний үзүүлэлт

Төв, орон нутгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цагдаагийн байгууллага, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн давхардсан тоогоор нийт 14,321 хүн 943 нэгж техник хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэн гол, нуурын ай сав газарт амарч, зугаалж буй 217499 иргэнд гол усанд осолдохоос урьдчилан сэргийлэх гарын авлага, тараах материал 132739 ширхгийг тарааж, сэрэмжлүүлэг яриаг нийт 54936 иргэнд хийж, голын эрэг дагуу байрласан 954 тээврийн хэрэгслийг ногоон бүсээс 50-100 метрийн зайд гаргаж ажилласан байна.

Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг, шторк бэлтгэж, 112 телевиз, сонин, сэтгүүлд цахим сайтад 612 удаа урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх мэдээ, мэдээлэл, ярилцлага өгч, ухуулах хуудас нийт 132,739 ширхгийг тарааж, олон нийтийн сүлжээгээр давхардсан тоогоор 3.118.307 иргэдэд хүргэж, төрийн болон төрийн бус, ерөнхий боловсролын, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 18088 ажилтан, албан хаагч, сурагчдад Гол, усны ослын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 478

удаагийн сургалт зохион байгуулсан.

2.1.2. Гамшгаас хамгаалах сургалт

1. Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын талаар:

Улсын хэмжээнд 2023 онд гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг нийт 6629 удаа зохион байгуулж 403943 хүнийг хамруулсан байна. Ангиллын сургалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль 16 буюу 12.2 хувиар, гамшгаас хамгаалах команд штабын сургууль 46 удаа буюу 33.6 хувиар, удирдах албан тушаалтны сургалт 937 буюу 86.8 хувиар, их, дээд сургууль болон МСҮТөв, коллежийн оюутан, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сургалт 1859 буюу 5.1 хувиар, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны сургалт 3175 буюу 8.7 хувиар, иргэний сургалт 596 буюу 14.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 52. Ангиллын сургалт

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд зохион байгуулсан нэгдсэн сургалт

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1989 оны 64/200 дугаар шийдвэрийн дагуу "Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр"-ийг 2023 онд дэвшүүлсэн "Гамшигт тэсвэртэй ирээдүйн төлөө тэгш бус байдалтай тэмцэх нь" урианы дор улсын хэмжээнд өргөн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлсэн.Үүнд:



Зураг 53. Тоон үзүүлэлт

Онцгой байдлын ерөнхий газраас гамшгаас урьдчилан сэргийлэх, хүн бүрийг өөрийгөө болоод бусдыг аврах хамгаалах мэдлэгтэй болгоход мэргэжлийн байгууллагаас гадна хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Нэгдсэн үндэстний байгууллагын Суурин төлөөлөгчийн газартай хамтран "Гамшигт тэсвэртэй ирээдүйн төлөө хамтдаа" өглөөний уулзалтыг 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтад телевиз, өдөр тутмын сонин, сайтын нийт 13 ерөнхий редактор, албаны дарга нар оролцсон. Улсын хэмжээнд аюулгүй амьдрах ухааны мэдлэг, боловсрол олгох сургалтыг нийт 358, Ерөнхий боловсролын сургуулийн 20,715 сурагчид, нэгдсэн арга хэмжээ өдөрлөгийг нийт 98 удаа зохион байгуулж, 33,298 иргэдийг хамруулсан.

2."Өсвөрийн аврагч-2023"

Онцгой байдлын ерөнхий газар, Боловсролын ерөнхий газар, Монголын Улаан загалмайн нийгэмлэг, Дэлхийн Зөн-Монгол ОУБ хамтран "Өсвөрийн аврагч-2023" Улсын аварга шалгаруулах уралдааныг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 2023 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж, аймаг, бүсээс шалгарсан нийт 48 хүүхдүүдийг хамруулан, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг өсвөр насны хүүхдүүдэд сурталчилсан арга хэмжээ зохион байгуулсан.

Зураг 54... "Өсвөрийн аврагч-2023"

Энэ нь гамшгаас урьдчилан сэргийлэх, мэдлэг ойлголтыг өгөх, Монгол Улсын иргэдийг бага наснаас нь энэ чиглэлд сургаж, дадлагажуулан хэвшил болгоход чухал ач холбогдолтой юм.

3. Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургууль

1. 2023 онд Дархан-Уул, Дорнод аймгуудад гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Хөвсгөл, Говь-Алтай, Ховд аймгуудад гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгууллаа.



Зураг 55. Ослын удирдлагын тогтолцоо, сургалт

Дархан-Уул аймагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг "Орон нутгийн Онцгой байдлын ажиллагааны удирдлагын төвийн үйл ажиллагаа, гамшгийн үеийн хариу арга хэмжээ" сэдвийн хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 13-18-ны өдрүүдэд астрономийн 72 цаг, оперативын 288 цагийн багтаамжтай 4 үе, шаттайгаар зохион байгуулж, аймаг, сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн анги, төрийн болон хувийн хэвшлийн нийт 40 байгууллагын 998 ажилтан, алба хаагч, 79 автомашин, техник, 5012 нэр төрлийн багаж хэрэгслийг дэлгэн оролцсон. Сургуулийн хүрээнд Хонгор сумын 920 иргэнийг түр байранд шилжүүлэн байрлуулж, төрийн бүхий л шатны үйлчилгээг иргэдэд үзүүлсэн. Мөн аймгийн хэмжээнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нүүн шилжих дадлага сургуулийг зохион байгуулж, Дархан-Уул аймгийн 4 сумын нийт 56,172 иргэн хамруулж, нийт хүн амын 54,0 хувийг эзэлж байгаа нь өндөр үзүүлэлттэй оролцсон.

Энэ удаагийн Дархан-Уул аймагт зохион байгуулсан гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн удирдах бүрэлдэхүүний "Академик" сургалтыг АНУ-ын Ойн албаны сургагч багш нар "Ослын удирдлагын тогтолцоо" сэдвээр орон нутгийн түвшинд анх удаагаа зохион байгуулсан нь онцлог байсан. Сургуулийн удирдагч гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд 98.0 буюу Дүүрэн хангалттай үнэлгээ өгсөн.

2. Дорнод аймагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг "Орон нутгийн гамшгаас хамгаалах бэлэн байдал, хариу арга хэмжээ, харилцан ажиллагаа" сэдвийн хүрээнд 2023 оны 09 дүгээр сарын 27-29-ны өдрүүдэд астрономийн 72 цаг, оперативын 288 цагийн багтаамжтай 5 үе, шаттайгаар зохион байгуулж,

аймгийн бүх шатны Засаг дарга, Онцгой комисс, гамшгаас хамгаалах орон нутгийн 14 алба, мэргэжлийн 23 анги, ерөнхий зориулалтын 2 анги, тусгай зориулалтын 21 ангийн нийт 680 томилгоот бүрэлдэхүүн, 69 автомашин, техник, 312 багаж, хэрэгслийг дэлгэн оролцсон. Сургуулийн хүрээнд Баянтүмэн сумын 458 иргэнийг түр байранд шилжүүлэн байрлуулж, төрийн бүхий л шатны үйлчилгээг иргэдэд үзүүлсэн. Дорнод аймгийн 14 сумын 32 цэгт нийт 22,585 иргэдийг хамруулсан нь нийт хүн амын 27,5 хувь оролцсон байна. Аймгийн бүс нутгийн онцлогт тохируулан хээрийн гал түймэр унтраах болон усны мандлаас нисдэг тэргээр осолдогчийг аврах ажиллагааны дадлага, сургуулиудыг анх удаагаа зохион байгуулсан нь онцлог байсан.

Зураг 56. Дорнод аймаг гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль

Сургуулийн удирдагч гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 90.0 буюу Дүүрэн хангалттай үнэлгээ өгч дүгнэсэн.

3.Хөвсгөл аймагт Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг 2023 оны 03 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургуулийг "Газар хөдлөлтийн гамшгийн үеийн хариу арга хэмжээ, удирдлагын харилцан ажиллагаа" сэдвийн хүрээнд астрономийн 48 цаг, оперативын 288 цагийн багтаамжтай, 2 үетэйгээр "Ослын үеийн удирдлагын тогтолцоо" сэдэвт танхимын сургалт, Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлын үзлэг, Газар хөдлөлт, ой, хээрийн гал түймэр зэрэг цагийн байдал дээр ажиллах штабын дадлагыг зохион байгуулсан. Уг сургуульд аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын газар, гамшгаас хамгаалах орон нутгийн 12 алба, 10 мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, байгууллагын томилгоот бүрэлдэхүүн, 23-н сум, 1 тосгоны ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүн 200, цахимаар 220, нийт 520 удирдах бүрэлдэхүүн хамрагдан оролцсон. Сургуулийн удирдагч гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд 92.7 буюу Дүүрэн хангалттай үнэлгээ өгсөн.

4. Говь-Алтай аймагт Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг 04 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургуулийг "Газар

хөдлөлтийн гамшгийн үеийн хариу арга хэмжээ, удирдлагын харилцан ажиллагаа” сэдвийн хүрээнд астрономийн 48 цаг, оперативын 288 цагийн багтаамжтай, 4 үетэйгээр “Ослын үеийн удирдлагын тогтолцоо” сэдэвт танхимын сургалт, Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлын үзлэг, Газар хөдлөлт, хүчтэй цасан болон шороон шуурганы цагийн байдалдээр ажиллах штабын дадлагыг зохион байгуулсан. Тус сургуульд аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын газар, гамшгаас хамгаалах орон нутгийн 11 алба, 32 мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, байгууллагын томилгоот бүрэлдэхүүн 506, 17-н сум, 2 тосгоны ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүн 1335, цахимаар 225, нийт 2066 хүн хамрагдан оролцсон. Сургуулийн удирдагч гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 92.5 буюу Дүүрэн хангалттай үнэлсэн.

Зураг 57. Ховд аймагт 10 дугаар сарын 23-30-ны өдрүүдэд
Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг зохион байгуулсан.

Сургууль “Газар хөдлөлтийн гамшгийн үеийн хариу арга хэмжээ, удирдлагын харилцан ажиллагаа” сэдвийн хүрээнд астрономийн 48 цаг, оперативын 288 цагийн багтаамжтай, 4 үетэйгээр “Ослын үеийн удирдлагын тогтолцоо” сэдэвт танхимын сургалт, Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлын үзлэг, газар хөдлөлт, цасан болон шороон шуурга, хүний халдварт өвчний цагийн байдал дээр ажиллах штабын дадлагыг зохион байгуулсан. Тус сургуульд аймгийн бүх шатны Засаг дарга, Онцгой комисс, гамшгаас хамгаалах орон нутгийн 11 алба, ерөнхий болон тусгай зориулалтын 20 мэргэжлийн ангийн нийт 474 томилгоот бүрэлдэхүүн, 32 техник хэрэгсэл, 17 сумын гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн 1056

томилгоот алба хаагч, 104 техник, багаж хэрэгслийг дэлгэн, бэлэн байдлын үзлэгт хамрагдсан. Сургуулийн удирдагч гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг 93,0 буюу Дүүрэн хангалттай үнэлэгджээ.

2.1.3. Гамшгаас урьдчилан сэргийлэх хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа

Орчин цагийн техникийн шинэчлэл, цаг үеийн хэрэгцээ, шаардлага, иргэдийн хүсэл сонирхолд нийцүүлэн албаны nema.gov.mn сайтыг, MNS 6285:2017 төрийн байгууллагын вэб сайтад тавих стандартын дагуу шинэчлэн олны хүртээл болголоо.

Ингэснээр гамшиг, ослын талаарх нэгдсэн статистик, иргэд, олон нийтэд зориулсан зөвлөгөө, мэдээлэл, албаны хэмжээнд өрнөж байгаа онцлох үйл явдлуудыг цаг алдалгүй богино хугацаанд шуурхай мэдээлэх боломжийг бүрдүүлсэн. Мөн гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зөвлөмж мэдээллийн төрөлжсөн belenbai.mn сайтыг сайжруулалт хийн үйл ажиллагааг нь жигдрүүллээ. Тус сайтад өнөөдрийн байдлаар газар хөдлөлтийн гамшиг, гал түймэр, цасан шуурганы талаарх зөвлөмж мэдээллийг нэгтгэн байршуулж, арванхоёрдугаар сарын 5-ныг өдрийн байдлаар давхардсан тоогоор 25 сая гаруй хүн иргэн хандаж, мэдээ, мэдээллийг хүлээн авсан байна.



Зураг 58. belenbai.mn сайтын сайжруулалт

Орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан, сурталчилгаа мэдээллийг хүргэж байна

Хиймэл оюун ухаан дээр суурилсан AI технологийг нэвтрүүлж, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа, ард иргэдэд зориулсан сэрэмжлүүлэг, зөвлөгөө зэрэг 30 удаагийн мэдээ, мэдээллийг 5.7 сая гаруй иргэнд хүргэж ажиллалаа.



Зураг 59. Дэвшилтэт технологи

Хиймэл оюун ухаанд суурилсан хэвлэл мэдээллийн ажилтан “Nemaka” нь 2023 оны наймдугаар сарын 24-нд анхны мэдээллээ хүргэснээр төрийн байгууллагуудаас анхдагч болж, байгууллагын мэдээ, мэдээллийг цаг алдалгүй, богино хэмжээгээр сонирхолтой хэлбэрээр хүргэх боломж бүрдсэн.

Онцгой байдлын байгууллага нь орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан, сурталчилгаа мэдээллийг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд “Онцгой байдлын ерөнхий газар” пейж хуудасныхаа мессенжер үйлчилгээнд суурилсан “чатбот” буюу автомат хариулагчийг нэвтрүүлж, 24 цагийн турш иргэдэд мэдээ, мэдээллийг хүлээн авах боломжийг бүрдүүллээ.

Онцгой байдлын алба хаагчид, тэдгээрийн ажил, мэргэжлийн онцлогийг сурталчлан таниулах зорилгоор “Нематаймс” буланг ажиллуулах болсноор 2023 оны 09 дүгээр сараас хойш 12 дугаар сарын 5-ныг хүртэл 18 алба хаагчийг зочноор урьж, мэдээллийг бэлтгэн nema.gov.mn сайт болон “Онцгой байдлын ерөнхий газар” пейж хуудсанд байршуулж 1.5 сая хүнд, хэвлэл мэдээллийн байгууллагын 80 орчим байгууллагаар дамжуулан олон нийтэд сурталчилан ажилласан.

Зураг 60. “Нематаймс” булан

ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ

2023 онд Онцгой байдлын ерөнхий газраас объектын болон ой, хээрийн гал түймэр, газар хөдлөлт, мөс цөмрөлт, шар усны үер, хүчтэй цасан болон шороон шуурга, зам даваа хаагдах зэрэг цаг агаарын аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, цаг агаарын аюулт үзэгдэлтэй холбогдуулан нийт 12 удаагийн хэвлэлийн хурал зохион байгуулсан. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан зохион байгуулсан хэвлэлийн хурлын дүрс бичлэг, мөн шууд дамжуулах болон мэдээ мэдээлэл бэлтгэн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран иргэд олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулав.

Зураг 61. Цаг үеийн асуудлаар зохион байгуулсан хэвлэлийн бага хурал.

“ОНЦГОЙ БАЙДЛЫН ЦАГ” НЭВТРҮҮЛЭГ

Онцгой байдлын ерөнхий газраас “Онцгой байдлын цаг” нэвтрүүлгийг 14 хоногийн давтамжтайгаар бэлтгэн нэвтрүүлж байна. 2023 онд 139-163 дахь дугаар ыг буюу нийт 24 дугаарыг дохионы хэлний хэлмэрчтэйгээр бэлтгэн байгууллагын цахим хуудас болон пэйж хуудас, MYOHT-ийн 1, 2 дугаар суваг, Өлзий, Royal HD, News channel, Малчин телевизээр тус тус иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.






Зураг 62. Онцгой байдлын цаг” нэвтрүүлэг

"ОНЦГОЙ МЭДЭЭ" СОНИН

“Онцгой мэдээ” сониныг 2023 онд 178-199 дэх дугаар буюу 22 дугаарыг тус тус хэвлүүлэн олны хүртээл болгосон байна. 2023 онд тус сонинд байгууллагын удирдлага болон алба хаагчдын ярилцлага-32, албаны үйл ажиллагаатай холбоотой мэдээ, нийтлэл, сурвалжлага-239 бэлтгэн хэвлүүлэв.

Зураг 63. Онцгой мэдээ сонин

БҮЛЭГ.2.2 ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.2.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал

Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ:

Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх" техник туслалцааны төслийн хүрээнд Монгол Улсад зонхилон тохиолддог гамшиг, аюулт үзэгдлийн 10 төрлөөр үндэсний болон орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж тайланг боловсруулсан. Энэхүү үнэлгээнд баг, хороо, сум, дүүрэг, хүн ам, өрх айл, барилга байгууламж, зам тээвэр, эрчим хүч, мал амьтан, хөдөө аж ахуй гэх мэт элементүүдийг сонгож үндэсний болон Улаанбаатар хот, Орхон, Өмнөговь, Ховд, Дорнод аймгийг хамруулжээ.

ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНГЭЭС:

Айл өрх: 2020 оны байдлаар улсын хэмжээнд нийт 902.609 айл өрхийн 257.840 буюу 28.6 хувь нь өрх толгойлсон эмэгтэйчүүд бүхий айл өрх байна. Үнэлгээний дүнгээр нийт 902.609 айл өрхийн 666.118 (73.7%) өрх нь газар хөдлөлтийн >VIII баллд, 158.357 (17.5%) өрх VII баллд, 78.134 (8.6%) өрх нь VI баллын хүчтэй газар хөдлөлтөд өртөх магадлалтай гэж дүгнэгдсэн байна.

Хүснэгт 2. Өрхийн газар хөдлөлтөд өртөх байдал /аймгаар/

Д/д	Аймаг	Өртөх байдал бүхий өрхийн тоо				
1	Улаанбаатар	-	-		9,370	407,232
2	Зүүн бүс	-	-	57.237 (88.04%)	7.351 (11.3%)	421 (0.6%)
2.1	Дорнод	-	-	23,215	163	
2.3	Сүхбаатар	-	-	17,725		
2.4	Хэнтий	-	-	16,297	7,188	421
3	Төвийн бүс	-	-	20.897 (14.3%)	86.483 (59.5%)	37.876 (20.7%)
3.1	Төв	-	-		17,940	9,103
3.2	Сэлэнгэ	-	-		27,400	1,604
3.3	Дорноговь	-	-	19,531	584	
3.4	Дархан-Уул	-	-	0	28,797	
3.5	Өмнөговь	-	-	1,195	5,235	14,676
3.6	Дундговь	-	-	171	1,548	12,493
3.7	Говьсүмбэр	-	-		4,979	

4	Хангайн бүс	-	-	-	43.560 (25.5%)	126.908 (75.6%)
4.1	Орхон	-	-		28,386	
4.2	Өвөрхангай	-	-		1,084	31,978
4.3	Булган	-	-		4,391	14,090
4.4	Баянхонгор	-	-		1,036	24,534
4.5	Архангай	-	-		6,038	21,017
4.6	Хөвсгөл	-	-		2,625	35,289
5	Баруун бүс	-	-	-	11.593 (11%)	93.681 (89%)
5.1	Завхан	-	-		10,373	10,340
5.2	Говь-Алтай	-	-		1,123	14,952
5.3	Баян-Өлгий	-	-			24,327
5.4	Ховд	-	-			22,513
5.5	Увс	-	-		97	21,549
Нийт эзлэх хувь				78.1 (8.6%)	158.3 (17.5%)	666.1 (73.7%)

Сургууль, цэцэрлэгийн эрсдэлийн үнэлгээ:

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран сургууль, цэцэрлэгийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийсэн бөгөөд 2023 оны байдлаар улсын хэмжээнд нийт сургууль, цэцэрлэгийн 84 хувьд хийгээд байна. Мөн нийслэлийн хэмжээнд төрийн өмчийн нийт 152 сургууль байгаагаас гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг 100 хувь, 9 дүүргийн 41 хороо, 60 өрхийн эмнэлэгт гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж гүйцэтгэсэн.

Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн 2023 оны хуралдааныг 4 болон 11 дүгээр сард тус тус зохион байгуулж 3 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл, 3 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн чиглэлийг тус тус цуцалж, 1 хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг шинээр олгож нийт 31 хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн хүрээнд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхтэй байна.

Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг Уул уурхай, Дэд бүтэц, Хөдөө аж ахуй, Байгаль орчин, түүх соёлын дурсгалт газар, Үйлдвэр үйлчилгээ, Эрүүл мэнд гэсэн 6 чиглэлээр олгодог.



Зураг 64. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгосон байдал /чиглэл тус бүрээр давхардсан тоогоор/

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд улсын хэмжээнд нийт 496 аж ахуйн нэгж, байгууллага гамшгийн төрөл тус бүрээр гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийлгэжээ.



Зураг 65. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо

2023 онд нийт 98 аж ахуйн нэгж, байгууллага гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн байна.

2.2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 189 дүгээр тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл”-ийн 2023 оны ээлжит хуралдааныг 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан.

2022 оны хуралдаанаас өгсөн үүрэг чиглэлийн хэрэгжилт 83,07 хувьтай дүгнэгдсэн байна. Мөн Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажлын алба, Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр ОБЕГ-т хэрэгжиж буй “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх” техник туслалцааны төслийн хүрээнд 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн гишүүд, орон нутгийн зөвлөлийн дарга, төв орон нутгийн ОББ-ын гамшгийн эрсдэлийн удирдлага,

үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдэд “Гамшгийн эрсдэлийн удирдлагыг орон нутагт хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулж нийт 80 гаруй оролцогчдыг хамруулсан.

Гамшгийн эрсдэлийг бууруулах санхүү, хөрөнгө оруулалтад үндэсний болон орон нутгийн зөвлөлийн оролцоог нэмэгдүүлж, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2 дахь заалтын дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэлийн төсвийн 0.1-3.7 хувь буюу улсын дунджаар 0.8 хувийг тусган хэрэгжүүлсэн байна.

2.2.3. “Эрсдэл ба Стандарт” үндэсний форум

Монгол Улсын Шадар сайдын ивээл доор Шадар сайдын 2023 оны 70 дугаар тушаалын хүрээнд “Эрсдэл ба стандарт” үндэсний форумыг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд улсын хэмжээнд Төрийн ордны “Их Монгол” танхим, 21 аймагт амжилттай зохион байгууллаа.

Энэхүү үндэсний форумын гол зорилго нь Монгол Улсын нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжилд нөлөөлж буй уур амьсгалын өөрчлөлт, байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой гамшгийн болон бусад эрсдэлийг ойлгох, тодорхойлох, хүлээн авах, учирч буй сөрөг нөлөөллийг бууруулах, эрсдэлийг бууруулахад стандартыг сайжруулах, мөрдөн хэрэгжүүлэх, эрсдэлийг шилжүүлэх даатгалын тогтолцоог боловсронгуй болгох арга зам, барилга, хот байгуулалт, эрчим хүч, зам тээвэр зэрэг дэд бүтэц, хүн амын

эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд тулгарч буй эрсдэл, хүндрэл бэрхшээлийг тодорхойлох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхөд чиглэсэн бөгөөд "Стандартаа хэрэгжүүлье, эрсдэлээ бууруулъя" уриан дор зохион байгуулагдсан.

Тус форумд 3 өдрийн турш төр, хувийн хэвшил, олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, хэвлэл мэдээллийн төлөөлөл зэрэг давхардсан тоогоор 2400 орчим зочид төлөөлөгч, мөн 1500 орчим төлөөлөгчид орон нутагт чууллаа.

Эрсдэлийн үндэсний форумыг зохион байгуулахад Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Үндэсний итгэмжлэлийн газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар болон НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болох Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Хүүхдийн сан, Хүн амын сан, мөн ДЭМБ, МУЗН олон улсын байгууллагууд, аймгийн нутгийн захиргааны байгууллага, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл хамтран ажилласан.

Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг, Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Парисын хэлэлцээр, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримлал, "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор:

- Эрсдэлийн удирдлага ба тогтвортой байдал
- Гамшгийн эрсдэл ба бэлэн байдал
- Хүн амын эрүүл, аюулгүй байдал гэсэн 3 үндсэн сэдвийн хүрээнд 8 дэд сэдвийг хамарсан хэлэлцүүлгийг форумын үеэр зохион байгуулж эрсдэл болон стандартын асуудлыг олон талаас нь хэлэлцсэн.

Тус форумаас гарсан санал зөвлөмж, дүгнэлтийг үндэсний болон орон нутгийн хэмжээнд авч хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Шадар сайд, ГЭБҮЗ-ийн орлогч даргын 2024 оны 01 дүгээр тушаалаар "Эрсдэл ба стандарт" үндэсний форумаас гарсан санал, дүгнэлтийг хэрэгжүүлэх ажлын хэсэг болон хэрэгжүүлэх арга хэмжээг тус тус батлуулан хэрэгжүүлж байна. Нийт хийж хэрэгжүүлж ажиллах 6 чиглэлд бүлэг болгон авч үзсэн.Үүнд:

1.Барилга, дэд бүтцийн тэсвэртэй байдал, хот төлөвлөлт

2.Эрсдэлийг шилжүүлэх, даатгалын тогтолцоог бүрдүүлэх

3.Эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, стандартыг мөрдүүлэх

4.Хүн ам, нийгмийн хамгааллыг сайжруулах

5.Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах

6.Хүн амын эрүүл аюулгүй байдлыг хангах чиглэлээр тус тус авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан байна.

2.2.4 Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх хүний нөөцийн чадавх

НҮБ-ын Зүүн Азийн Улс орнуудын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас зохион байгуулсан БНСУ-ын Инчеон хотноо энэ сарын 12-17-ны өдрүүдэд болсон "Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт" сэдэвт сургалтад 35 алба хаагч хамрагдлаа.

Зураг 66. "Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт" сургалтад оролцогчид, БНСУ-ын Инчеон хот

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэшүүлэх сургалт

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар Сайдын 2018 оны 45 дугаар тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/145 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2019 онд Гамшиг судлалын үндэсний хүрээлэн нь анх удаа "Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэшүүлэх сургалт"-ыг явуулж танхимын сургалт 70 цаг, дадлага ажил 40 цаг нийт 110 цагийн хичээлийг батлагдсан хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулан явуулсан.

Мөн 2023 онд анх удаа гэрчилгээ сунгах буюу "Гамшгийн эрсдэлийн үнэлгээчдийг чадавхжуулах сургалт"-ыг явуулж 40 гаруй эрсдэлийн үнэлгээчид хамрагдан суралцсан байна.

2019 оноос хойш жил бүр сургалт явуулж өдгөө 300 гаруй эрсдэлийн үнэлгээчдийг бэлтгэн сертификат олгосон байна.

Зураг 67. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэшүүлэх сургалт

БЭЛЭН Бай

www.belenbai.mn

ГУРАВДУГААР ХЭСЭГ.

ГАМШГИЙН ҮЕИЙН ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ

БҮЛЭГ 3.1. ГАМШГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ /СТАТИСТИК МЭДЭЭ, ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГАА/

3.1.1. Монгол оронд тохиолдсон аюулт үзэгдэл,ослын тойм

Монгол Улсын хэмжээнд 2023 онд нийт 4485 удаагийн аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 321 хүн амь насаа алдаж, 215 хүн гэмтэж бэртэн 560223 толгой мал, амьтан хорогдож, 52.0 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан.

Эдгээрийн хор уршгийг арилгахад Онцгой байдлын байгууллагын болон бусад байгууллага, орон нутгийн нийт 40747 хүн, 10127 техник хэрэгсэлтэйгээр ажиллаж, 8592 хүний амь нас, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 385.3 тэрбум төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалж, гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах ажилд онцгой байдлын байгууллага болон орон нутгаас 0.9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 3 .... Аюулт үзэгдэл, ослын тоо /2022,2023 он/

	Газар хөдлөлт	Үер	Аянга	Бусад Цаг агаарын	Мөндөр	Объектын түймэр	Хүчтэй салхи	Ой, хээрийн түймэр	Биологийн гаралтай аюулт үзэгдэл	Хүний үйл ажиллагаатай холбоотой осол
2022	89	21	4		4	3075	56	179	226	666
2023	86	107	9	17	1	3054	75	101	151	876

Тохиолдсон аюулт үзэгдэл, ослын 70 хувь буюу 3155 нь гал түймэр, 3 хувь буюу 151 нь биологийн гаралтай аюулт үзэгдэл, 20 хувь буюу 876 нь хүний үйл, ажиллагаатай холбоотой осол, 5 хувь буюу 209 нь ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл, 2 хувь буюу 94 нь геологийн гаралтай аюулт үзэгдэл байна.



Зураг 68. 2023 онд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын эзлэх хувь /гамшгийн төрлөөр/

Аюулт, үзэгдэл ослын улмаас учирсан нийт хохирлын 76 хувь буюу 39.5 тэрбум төгрөг нь гал түймрийн улмаас, 19 хувь буюу 10 тэрбум төгрөг нь ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн улмаас, 4 хувь буюу 1.8 тэрбум төгрөг нь хүний үйл ажиллагаатай холбоотой ослын улмаас, 1 хувь буюу 0.5 тэрбум төгрөг нь биологийн гаралтай аюулт, үзэгдэл ослын улмаас учирсан байна.



Зураг 69. 2023 онд аюулт үзэгдэл, ослын улмаас учирсан хохирлын эзлэх хувь, /гамшгийн төрлөөр/

Аюулт, үзэгдэл ослын улмаас нас барсан иргэдийн ослын шалтгаанаар нь авч үзвэл 26 хувь буюу 84 хүн зам тээврийн ослын улмаас, 22 хувь буюу 70 хүн объектын гал түймрийн улмаас, 21 хувь буюу 66 хүн усны ослын улмаас, 11 хувь буюу 37 хүн төөрч сураггүй болсны улмаас, 5 хувь буюу 15 хүн үерийн улмаас, 1 хувь буюу 4 хүн аянганы улмаас, 12 хувь буюу 37 хүн амь бусад төрлийн ослын улмаас амь насаа алджээ.



Зураг 70. 2023 онд аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний эзлэх хувь /гамшгийн төрлөөр/

УС, ЦАГ АГААРЫН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ:

Аадар бороо, үер:

Улсын хэмжээнд 18 аймаг, нийслэлийн 57 сум, дүүргийн нутаг дэвсгэр хамарсан 107 удаагийн аадар бороо орж, үер болсны улмаас 15 хүн амь насаа алдаж, 3213 толгой мал хорогдож, 1117 гэр, байшин урсан эвдэрч, 3974 иргэний амь насыг авран хамгаалсан. Үерийн голомтод 5107 албан хаагч, 803 автомашин техник ажилласан. 5.7 тэрбум төгрөгийн хохирол учирсан.

Аянга:

Зургаан аймгийн 9 сумын нутаг дэвсгэрт аянга буусны улмаас 4 хүн амь насаа алдаж, 4 хүн гэмтэж бэртэн, 2 толгой мал хорогдсон байна.

Хүчтэй салхи шуурга:

Улсын хэмжээнд 18 аймаг, нийслэлийн 55 сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан 75 удаагийн хүчтэй салхи, шуурганы улмаас 476 гэр, байшин нурж эвдрэн 1.7 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Шуурганд төөрсөн хүмүүсийг эрэн хайх ажиллагаанд Онцгой байдлын байгууллага, орон нутгийн иргэд нийт 1213 хүн, 256 автомашин техник ажилласан.

ГЕОЛОГИЙН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ:

Газар хөдлөлт:

Монгол Улсын 16 аймгийн 50 сумын нутагт 3.5 магнитудаас дээш хүчтэй газар хөдлөлтийн 86 тохиолдол мэдрэгдсэн. Онцгой байдлын байгууллага, орон нутгийн иргэд нийт 2 хүн, 1 автомашин техник ажилласан.

БИОЛОГИЙН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ:

Онцгой байдлын байгууллагад нийт 151 удаагийн хүн малын халдварт өвчний дуудлага мэдээлэл бүртгэгдэж, 2 хүн амь насаа алдаж, 6831 толгой мал хорогдсон. Хорогдсон мал, амьтдыг булж устган, ариутгал халдваргүйжүүлэлт хийж урьдчилан сэргийлэх, вакцинжуулах зорилгоор нийт 1778 хүн, 656 техник ажилласан байна.

ХҮНИЙ БУРУУТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ОСОЛ:

Нийт 876 удаа тохиолдож, 229 хүн амь насаа алдаж, 1931 хүний амь насыг авран хамгаалж, 140 хүн гэмтэж бэртсэн. Ослын голомтод Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, орон нутгаас нийт 7627 хүн, 1631 автомашин техниктэйгээр ажилласан.



Зураг 71. Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо, учирсан хохирлын хэмжээг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

Аюулт үзэгдэл, ослын тоо

2023 онд тохилдсон аюулт үзэгдэл, ослоос аварсан хүн, аварсан эд хөрөнгө, гэмтэж бэртсэн хүний тоо, нас барсан хүний тоог өмнөх онуудтай харьцуулахад дараах үзүүлэлттэй байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4569 буюу буюу 2.1 дахин өссөн

Зураг 72. Аварсан хүний тоо, 2021-2023

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 111.2 тэрбум төгрөг өссөн



Зураг 73. Аварсан эд хөрөнгө, 2021-2023

Гэмтсэн хүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42 буюу 24 хувиар өссөн



Зураг 74. Гэмтэж бэртсэн хүний тоо, 2021-202

Нас барсан өмнөх оны мөн үетэй харьцуулахад 74 буюу 30 хувь өссөн



Зураг 75. Нас барсан хүний тоо, 2021-2023



Зураг 76. 2022-2023 онд аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүн /аймаг нийслэлээр/

Аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүний тоогоор Улаанбаатар, Хэнтий, Өмнөговь аймаг орж байгаа боловч тухайн орон нутгийн 100000 хүн тутамд ногдох нас баралтын графикаар Хэнтий, Дундговь, Өмнөговь аймгууд өндөр байгаа нь харагдаж байна.



Зураг 77. 2023 онд аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүн 100000 хүн амд харьцуулсан байдлаар /аймаг нийслэлээр/



Зураг 78. Аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүний тоо, 2021-2023

2023 онд аюулт үзэгдэл, ослын улмаас нас баралтын 20 хувийг усны осол эзэлж байгаа бөгөөд 91 хувь нь эрэгтэйчүүд байна. Харин 22 хувийг объектын гал түймэр эзэлж үүний 61 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

3.1.2. 2023 оны уур амьсгалын жилийн тойм

1. Агаарын температур

Монгол орноор дунджилсан 2023 оны жилийн дундаж агаарын температур 1.3°С буюу уур амьсгалын өөрчлөлт харьцангуй сул илэрч байсан 1961-1990 оны дунджаас 1.9°С-аар дулаан буюу 1940 оноос хойш ажиглагдсан 7 дахь дулаан жил болж өнгөрлөө.

Жилийн дундаж температурын орон зайн тархалтыг авч үзвэл говийн бүс нутгийн өмнөд, Алтайн өвөр говиор +6.5...+10.5°С, тал хээрийн бүс нутгуудаар болон Их нууруудын хотгор орчмоор +2.5...+6.5°С, Хөвсгөлийн өндөр уулс, Хангайн нуруу, Дархадын хотгор орчмын нутгаар -3.5...-7.5°С, бусад нутгаар -1.5...+2.5°С орчим байсан байна.



Зураг 79. 2023 оны жилийн дундаж агаарын температурын орон зайн тархалт

2023 оны агаарын дундаж температурыг улирлаар авч үзвэл өвлийн улиралд нийт нутгийн 47.8% нь ОЖД-аас +1.0°С -ээс +3.0°С дулаан, 53.7% нь дунджийн орчим, 1.5% буюу Хэнтийн нуруу орчмоор дунджаас -1.4-ээс -2.2°С -аар хүйтэн байсан байна.

Хаврын улиралд нутгийн ихэнх хэсэг буюу 80.9%-д нь агаарын дундаж температур ОЖД-ийн орчим, 16.2% -д дунджаас -1.0°С-ээс -2.3°С-ээр хүйтэн, 2.9% нь дунджаас дулаан байжээ.

Зуны улиралд нийт нутгийн 42.6% буюу баруун болон говийн бүс нутгаар агаарын дундаж температур ОЖД-аас +1.0°С -ээс +1.9°С дулаан, бусад нутгаар дунджийн орчим байжээ.

Намрын улиралд агаарын дундаж температур нутгийн дийлэнх хэсгээр

(77.2%) ОЖД-аас дунджаас 1.0°С-ээс 2.4°С-аар дулаан, Дорнод Сүхбаатар, Хэнтий, Дорноговь аймгуудын зарим хэсгээр дунджийн орчим байсан байна.



Зураг 80. 2023 оны улирлын агаарын дундаж температурын ОЖД-аас(норм 1991-2020 он) хазайх хазайлт

2. Хур тунадас

Монгол орноор дунджилсан 2023 оны жилийн нийлбэр хур тунадас 251.2 мм буюу 1940 оноос хойш тохиолдсон 15 дахь ахиу хур тунадастай жил болж өнгөрлөө. Жилийн нийлбэр хур тунадасны орон зайн тархалтыг авч үзэхэд Хөвсгөлийн өндөр уулс, Хангай, Хэнтийн нуруу, Хараа, Туул зэрэг томоохон голын ай сав орчмоор 400.3-558.9 мм, тал хээрийн болон говийн бүс нутгийн хойд хэсгээр 100.0-392.9 мм, Их нууруудын хотгор болон говийн бүс нутгийн зарим хэсгээр 50-100 мм, Баян-Өлгийн Дэлүүн, Баянхонгорын Эхийн гол, орчмоор 36.4-48.9 мм орсон байна. Жилийн нийлбэр тунадасны хамгийн их утга нь Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр суманд 558.9 мм тунадас оржээ.



Зураг 82. 2023 оны жилийн нийлбэр хур тунадасны орон зайн тархалт

2023 оны өвлийн улиралд нийт нутгийн 28.0%-д ОЖД-аас бага, 61.0% -д ахиу, 11.0% -д дунджийн орчим хур тунадас орсон ба говийн бүсийн ихэнх нутгаар болон Увс, Завхан, Говь-Алтай, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгорын нутгаар дунджаас 2 дахин ахиу хур тунадас оржээ.

Хаврын улиралд нутгийн дийлэнх хэсгээр буюу 21.3% -д ОЖД-аас бага, 64.0% -д ахиу, 14.7% -д дунджийн орчим хур тунадас орсон. Баруун болон төвийн бүс нутгийн хойд талаар дунджаас харьцангуй ахиу хур тунадастай байлаа.

Зуны улиралд нийт нутгийн 48.5% -д дунджаас бага, 11.8% -д ахиу, 39.7%-д дунджийн орчим тус тус тунадас орсон. Төвийн бүс нутгаар дунджаас ахиу, харин баруун болон говийн бүс нутгаар бага хур тунадас орсон байсан.

Намрын улиралд нийт нутгийн 12.5% -д дунджаас бага, 80.1% -д ахиу, 7.4%-д дунджийн орчим хур тунадас орсон бөгөөд нутгийн ихэнх хэсгээр ОЖД-аас 2-3 дахин ахиу хур тунадас орсон байна.



Зураг 83. 2023 оны улирлын нийлбэр хур тунадасны ОЖД-аас (норм 1991-2020 он) хазайх хазайлт

Сүүлийн 5 жилийн сар бүрийн нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын утгыг харьцуулж үзэхэд 2023 оны 2, 4, 6 саруудад дунджаас 10-40% -иар бага 1, 8 дугаар саруудад дунджийн орчим, 3, 5, 7, 12 дугаар саруудад 10-40% хувиар ахиу, ялангуяа 9 болон 11 дугаар саруудад дунджаас 60%-иас их тунадас орсон байна.

3. Экстремаль утгууд

2023 онд температурын үнэмлэхүй их утга Баянхонгорын Эхийн голд агаарт 41.8°C, Говь-Алтайн Тоороймд хөрсөн дээр 70°C хүрч халсан бол үнэмлэхүй бага утга Завханы Баянтэс суманд агаарт -49.9°C, Отгонд хөрсөн дээр -52°C хүрч хүйтэрсэн байна. Нэг хоногт хамгийн ихдээ Улаанбаатарын Хан-Уул дүүрэгт

7 дугаар сарын 23-нд 85.9 мм тунадас оржээ. Даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 972.8 гПА, бага утга Баянхонгорын Баянбулагт 757.9 гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурдны үнэмлэхүй их утга Ховд аймгийн Зэрэг суманд 43 м/с хүрсэн байна.



Зураг 85. Тус жилд ажиглагдсан экстремаль утгууд

4. Цасан бүрхүүлийн зузаан

2023 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар нийт нутгийн 70 гаруй хувьд цасан бүрхүүл тогтсон. Цасан бүрхүүлийн зузаан Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулархаг нутаг, Хан Хөхий, Тарвагатай, Эрээний нуруу, Хархираа Түргэний уулс, Дарьгангын тэгш өндөрлөгөөр 20 см-ээс их, Баян-Өлгийн Сагсай, Увсын Улаангом, Хяргас, Сагил, Малчин, Түргэн, Баруунтуруун, Зүүнговь, Өндөрхангай, Тэс, Давст, Ховдын Алтай, Завханы Тэс, Баянтэс, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Цагаанчулуут, Их-Уул, Яруу, Сонгино, Идэр, Нөмрөг, Түдэвтэй, Тосонцэнгэл, Тэлмэн, Сантмаргац, Баянхайрхан, Цагаанхайрхан, Баянхонгорын Баянговь, Архангайн Тариат, Цэцэрлэг, Батцэнгэл, Хангай, Жаргалант, Өлзийт, Цахир, Хайрхан, Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Өвөрхангайн Хужирт, Бат-Өлзий, Бүрд, Хөвсгөлийн Жаргалант, Улаан-Уул, Цагааннуур, Эрдэнэбулган, Галт, Ренчинлхүмбэ, Цэцэрлэг, Цагаан-Үүр, Булганы Гурванбулаг, Баяннуур, Дашинчилэн, Рашаант, Хангал, Орхоны Жаргалант, Сэлэнгийн Хүдэр, Хушаат, Орхон, Орхонтуул, Түшиг, Ерөө, Зүүнбүрэн, Сүхбаатар, Төвийн Эрдэнэсант, Угтаалцайдам, Лүн, Алтанбулаг, Батсүмбэр, Өндөрширээт, Бүрэн, Баян-Өнжүүл, Баянчандмань, Цээл, Баян, Заамар, Зуунмод, Эрдэнэ, Жаргалант, Дорноговийн Иххэт, Дэлгэрэх, Айраг, Хэнтийн Дархан, Баян-Овоо, Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт, Жаргалтхаан, Өлзийт, Батноров, Баянмөнх, Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Норовлин, Дадал, Хэрлэн, Баян-Адрага, Сүхбаатарын

Түвшинширээ, Баяндэлгэр, Дарьганга, Наран, Онгон, Эрдэнэцагаан, Сүхбаатар, Халзан, Уулбаян, Мөнххаан, Асгат, Түмэнцогт, Дорнодын Булган, Гурванзагал, Матад, Дашбалбар, Баянтүмэн, Баяндун, Баян-Уул, Халхголд 10.1-ээс 41.0 см, Дархан-Уулын нийт, Говь-Алтай, Завхан, Архангай, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Орхон, Төв, Дундговь, Хэнтий, Дорнодын зарим, Баян-Өлгий, Увс, Ховд, Өвөрхангай, Баянхонгорын ганц нэг сумдын нутгаар 5.1-10 см, бусад нутагт 1-5 см (8 дугаар зураг), хунгарлаж шуурсан газартаа 60 см хүртэл байлаа.



Зураг 86. 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар цасны зузаан (см)

5. Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл

2023 онд улсын хэмжээнд 132 удаагийн цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдэл болсноос аюултай үзэгдэл 113 удаа, гамшигт үзэгдэл 19 удаа болж үүний улмаас 31 хүн амь насаа алдаж, 11702 толгой мал хорогдож, улсын чанартай авто зам 8, 19 эрчим хүчний шон, 807 орчим гэр, 201 барилгын дээвэр хуурч, 919 хашаа эвдэрч, 36 холбооны шон унасан ба 356.5 га тариалангийн талбай өртсөн бөгөөд улс нийгэмд 10 тэрбум 182 сая 142 мянган төгрөгийн шууд хохирол учирсан байна.

Нийт 10 төрлийн аюулт, гамшигт үзэгдэл болсноос хүчтэй салхи шуурга болон уруйн үер, аадар бороо, цочир хүйтрэл, мөндөр, аянга цахилгаан, нөөлөг салхи, их цас хамгийн олон удаа болсон бөгөөд нийт аюулт, гамшигт үзэгдлийг харгалзан **12-27%**-ийг эзэлсэн байна. Аюултай үзэгдлийг цаг агаарын нөхцөл, хамрах газар нутаг, үргэлжлэх хугацаагаар нь **фронтын** болон **конвекцийн** гаралтай гэж ангилдаг. 2023 онд конвекцийн гаралтай аюулт, гамшигт үзэгдэл фронтын гаралтай аюултай үзэгдлээс илүү олон удаа ажиглагдсан.

3.1.3. Эрэн хайх, аврах ажиллагаа

Онцгой байдлын байгууллагын алба хаагчид Дундговь, Төв, Хэнтий болон Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулан ажиллажээ.

1. Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг "Флюмон" ХХК-ийн "Хөх дэл" жоншны ил уурхайн үүсмэл нуурын мөс цөмөрч экскаватор, жолоочийн хамт живсэн ослын дуудлагаар эрэн хайх ажиллагааг эхлүүлж, уурхайн үүсмэл нуурын 1500 м2 талбайд 7.5 метрийн гүнд 4 шумбагч нийт 17 удаа гүний шумбалт хийж нийт 8500 м3 ус соруулан, 184 тонн мөсийг тээвэрлэн зайлуулсан.

Ослын голомтод Онцгой байдлын байгууллагын 17 алба хаагч, 3 техник, Дундговь аймгийн Цагдаагийн хэлтсийн 5 алба хаагч, аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн 2 алба хаагч, 3 техник, Хэнтий аймгийн "Бор-Өндөр" сумын Уулын баяжуулах үйлдвэрийн 8 ажилтан, 2 техник, "Флюмон" ХХК-ийн 14 ажилтан, 6 техник, 12 тоног төхөөрөмж нийт 46 хүн, 14 техник, 12 тоног төхөөрөмжтэйгээр үүрэг гүйцэтгэсэн.



Зураг 87. Эрэн хайх, аврах ажиллагаа, Дундговь аймаг

2. Төв аймгийн нутгаар 2023 оны 11 дүгээр сард хүчтэй цасан шуурга шуурч, цаг агаарын гамшигт үзэгдэл тохиолдсон нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, үнэлэлт, дүгнэлт гаргах, амь насаа алдсан иргэдийн ар гэрийхэнтэй уулзах, аймаг, сумын онцгой комиссын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор Ажиллагааны удирдлагын газрын ажлын хэсэг Бүрэн, Лүн, Өндөрширээт, Эрдэнэсант суманд ажилласан.

2.1 Бүрэн сум: 2023 оны 11 дүгээр сарын 4, 5-ны өдөр их хэмжээний цас орж, салхины хурд 16-22 м/сек хүрч хүчтэй цасан шуурга 14 цаг 50 минут үргэлжлэн, тал газартаа 25 см, гуу жалга, хунгарласан газарт 60-70 см зузаан цасан бүрхүүл тогтсон. Цаг агаарын аюулт үзэгдэлийн улмаас 93 айл намаржаандаа цасанд боогдож, өвөлжөө рүү нүүхэд хүндрэл үүссэн.

Цасан шуурганы үеэр сумын хэмжээнд төөрсөн сураггүй болсон тухай 4, автомашинтай зорчиж яваад цасанд суусан тухай 9, нийт 13 дуудлага мэдээллийн дагуу сумын мэргэжлийн анги, нутгийн захиргааны байгууллагын 12 алба хаагч, 2 техниктэйгээр эрэн хайх, цасанд суусан машин татан гаргах ажиллагааг зохион байгуулж 43 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлсэн.

Цасанд боогдсон айл өрхийг нүүлгэх, шаардлагатай газруудад зам гаргах ажиллагаанд онцгой байдлын байгууллагын 7 алба хаагч, 2 нэгж техник, Зэвсэгт хүчний 2 алба хаагч, 1 нэгж техник, нутгийн захиргааны байгууллага, сумын мэргэжлийн ангийн 25 ажилтан 3 нэгж техник, нийт 34 хүн, 6 техниктэй ажиллаж 616 км зам гарган 38 айл өрхийг нүүлгэн, 6 иргэн /3 жирэмсэн эх/-д эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэн, цасанд суусан 6 авто машиныг татан гаргаж, 2 айлд хүнс, түлээ түлш татан өгсөн.

2.2 Лүн сум: 11 дүгээр сарын 4, 5-ны өдөр цас орж, салхины хурд 16-18 м/с хүрч, цасан шуурга 11 цаг гаруй үргэлжлэн шуурч, цасны зузаан 36 см хүрч цаг агаарын аюулт үзэгдэл болсон бөгөөд 1 хүний амь нас эрсдэж, 35 толгой бод, 785 толгой бог, нийт 820 толгой мал хорогдсон.

Цасанд боогдсон айл өрхийг нүүлгэх, шаардлагатай газруудад зам гаргах ажиллагаанд онцгой байдлын байгууллагын 6 алба хаагч, 2 нэгж техник, Зэвсэгт хүчний 4 алба хаагч, 2 нэгж техник, нутгийн захиргааны байгууллага, сумын мэргэжлийн ангийн 45 ажилтан 1 нэгж техник, нийт 55 хүн, 5 техниктэй ажиллаж 639 км зам гарган 55 айл өрхийг нүүлгэн, 9 иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэн, цасанд суусан 48 авто машиныг татан гаргаж, 1 айлд хүнс, түлээ түлш татан өгсөн.

2.3 Өндөрширээт сум: 11 дүгээр сарын 4, 5-ны өдөр цас орж, салхины хурд 16-18 м/с хүрч, хүчтэй цасан шуурга 20 орчим цаг үргэлжилсэн. Цасны зузаан тал газартаа 20-25 см орчим, гуу жалга, хунгарласан газар 50-80 см хүрч, битүү цасан бүрхүүл тогтсон. Цасан шуурганы улмаас 72 өрхийн 2000 орчим толгой бог мал хорогдсон, 82 өрх цасанд боогдож өвөлжөөндөө бууж амжаагүй, 12 малчин гэр орондоо хүрэх боломжгүй малтайгаа цасанд боогдсон нөхцөл байдал үүссэн.

Цасанд боогдсон айл өрхийг нүүлгэх, шаардлагатай газруудад зам гаргах ажиллагаанд онцгой байдлын байгууллагын 7 алба хаагч, 3 нэгж техник, Зэвсэгт хүчний 2 алба хаагч, 1 нэгж техник, нутгийн захиргааны байгууллага, сумын мэргэжлийн ангийн 22 ажилтан, 5 нэгж техник, нийт 31 хүн, 9 техниктэй ажиллаж 381 км зам гарган 21 айл өрхийг нүүлгэн, 25 иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэн, цасанд суусан 7 авто машиныг татан гаргаж, 8 айлд хүнс, түлээ түлш татан өгсөн.

2.4 Эрдэнэсант сум: 11 дүгээр сарын 4, 5-ны өдөр цас орж, салхины хурд 16-18 м/сек хүрч, цасан шуурга 20 гаруй цаг үргэлжлэн орж, цасны зузаан 36 см хүрсэн. Цаг агаарын аюулт үзэгдлийн улмаас 6 хүний амь нас эрсдэж, 786

толгой бог мал хорогдсон.

Цасанд боогдсон өрхийг нүүлгэх, шаардлагатай газруудад зам гаргах ажиллагаанд Онцгой байдлын байгууллагын 14 алба хаагч, 4 нэгж техник, Зэвсэгт хүчний 9 алба хаагч, 4 нэгж техник, нутгийн захиргааны байгууллага, сумын мэргэжлийн ангийн 51 ажилтан, 12 нэгж техник, нийт 74 хүн, 20 техниктэй ажиллаж 1509 км зам гарган, 56 айл өрхийг нүүлгэн, 47 иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэн, цасанд суусан 212 авто машиныг татан гаргаж, 19 айлд хүнс, түлээ түлш татан өгсөн.

Зураг 88. Аймгуудын Шуурхай Штабын үйл ажиллагаа

3. Хэнтий, Сүхбаатар аймгийн нутгаар 5 дугаар сарын 19-ний өдөр, Дорнод аймгийн нутгаар 5 дугаар сарын 20-ны өдөр салхины хурд 18-20 м/с, зарим үед 28-32 м/с хүрч цасан болон шороон шуурга шуурч цаг агаарын гамшигт үзэгдлийн хэмжээнд хүрсэн бөгөөд нийт 12-15 цагийн хугацаанд шуурсан. Эрэн хайх, аврах ажиллагаанд онцгой байдлын байгууллагын 56 алба хаагч 10 автомашин (Хэнтий аймагт 21 алба хаагч 3 автомашин, Сүхбаатар аймагт 35 алба хаагч, 7 автомашин), нутгийн захиргааны байгууллагаас 133 хүн, 31 автомашин (Хэнтий аймагт 63 хүн, 12 автомашин, Сүхбаатар аймагт 70 хүн, 19 автомашин) ажиллажээ.

3.1.4 Хариу арга хэмжээ

1. Хорт хийн тархалтын хариу арга хэмжээ

2023 оны 10 дугаар сарын 11-ний шөнөөс эхлэн Улаанбаатар хотын иргэдээс газ, бензин мэт зүйл үнэртэж эхэлсэн тухай 230 орчим ШУЗМТөвд ирсэн мэдээллийн дагуу ГСҮХүрээлэнгийн химийн мэргэжилтэнүүд агаарт алдагдаж тархсан химийн бодисын нэр, шалтгааныг тогтоох тандах судалгаа, шинжилгээг 11 байршилд 22 удаагийн хорт хийн хэмжилт хийж, “Дизель түлш”-ээс шалтгаалж байгааг тодорхойлон, холбогдох тооцооллыг боловсруулж, бохирдуулагчийн эх үүсвэрийн байршлыг тогтоож, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг гүн бохирдлоос сэргийлэх шуурхай хариу арга хэмжээ авах, Тагнуул, цагдаа, мэргэжлийн хяналтын хамтарсан ажлын хэсгийг бодит дүгнэлт, мэдээллээр хангах ажлыг шуурхай гүйцэтгэв.

Зураг 89. Улаанбаатар хотод тархсан хийн голомтын эх үүсвэрийг явуулын лабораториор илрүүлж буй байдал

2. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалт, хэрэгжүүлсэн арга хэмжээ

2023 оны 01-р сарын 01-нээс 12 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл

хугацаанд Монгол Улсад мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг, үхрийн арьс товруутах, гахайн африкийн мялзан зэрэг нийт 5 төрлийн өвчний гаралт бүртгэгдсэн.

ДМАЭМБ-ын Газрын амьтны эрүүл мэндийн кодексийн 4.18.2 дугаар зүйлд "Яаралтай дархлаажуулалт гэж өвчин дэгдэх, эсхүл гаднаас нэвтрэх эрсдэл нэмэгдэх, эсхүл дахин сэргэх үеийн яаралтай хариу арга хэмжээнд хэрэглэх дархлаажуулалтыг хэлнэ" гэж заасан байдаг нь өвчин гарсан тухайн нөхцөл байдалд төдийгүй өвчин гарах, тархах эрсдэлийг харгалзан вакцин болон бусад холбогдох нөөцийг бүрдүүлэх нь чухал болохыг харуулж байв.

Шүлхий өвчний гаралт:

Шүлхий өвчний гаралт олон улсад 2023 оны 01-р сараас хойш хойд Африк, Араб, Азийн улсуудад бүртгэгдсэн байна. Азийн орнуудаас БНХАУ, БНСУ-д бүртгэдсэн нь бүгд О дэд хэвшлийн India/2001 ийлдсэн хэвшлээр үүсгэгдсэн байсан. БНХАУ-д уг өвчний гаралт идэвхтэй байгаа нь манай улсад өвчний халдвар дамжин тархах эрсдэл байв.

Зураг 90. Шүлхий өвчний гаралт 2023.01-12-р сар. ДМАЭМБ-ын мэдээлэл

Шүлхий өвчний гаралт Монгол Улсад 2022 оны 01-06-р сард нийт 20 аймгийн 201 суманд нийт 447 голомт бүртгэгдэж 357,981 толгой мал ил шинж тэмдэгтэйгээр өвчилж байсан бол 2023 оны 01-06-р сард Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын 4 голомтод 46 үхэр өвчилсөн тохиолдол 01-р сард бүртгэгдсэн. Өвчний гаралт, тархалтыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлснээр голомтоос гадагш халдвар тархаагүй 03-р сард хорио цээрийн дэглэмийг бүрэн цуцалсан бөгөөд өвчний гаралт 2023 онд дахин бүртгэгдээгүй.

д/д	Хамрах хугацаа	Аймгийн тоо	Сумын тоо	Голомт тоо	Өвчилсөн малын тоо	Устгасан малын тоо
1	2022.01-06-р сар	20	201	447	357,981	705
2	2023.01-06-р сар	1	1	4	46	-
Бууралт хувь		(95)	(99)	(99)	(99)	(99)

Хүснэгт 4. Шүлхий өвчний гаралт 2022-2023 он.

Монгол Улсад бүртгэгдсэн шүлхий өвчний тохиолдол нь О дэд хэвшлийн India/2001 ийлдсэн хэвшлээр үүсгэгдсэн болох нь Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн шинжилгээний дүнгээр баталгаажсан.

Шүлхий өвчний гаралт 2021-2022 онд өргөн хүрээтэй тархсан, вирусийн халдварын эргэлт бүрэн зогсоогүй эрсдэлтэй тул 2022 онд хэрэгжүүлсэн эрсдэлд суурилсан дархлаажуулалтын арга хэмжээг 2023 оны 05-06-р сард үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн.

Дархлаажуулалтын арга хэмжээг дараах төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.

Зураг 91. Дархлаажуулалтын төлөвлөгөө 2023.

2023 оны хаврын дархлаажуулалтад 2022 онд Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслөөс 6,9 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэн нийлүүлсэн О хэвшлийн дан цэнт тосон суурьт 6,5 сая тун вакциныг ашигласан. Хаврын дархлаажуулалтыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын (МЭЕГ) 2023 оны 04-р сарын 11-ний өдрийн А/87 дугаар тушаалаар нийт 21 аймаг, нийслэлийн 5,5 сая үхэр, 32,4 мянган гахай, 3,0 мянган цаа буга хамруулахаас нийт 143,5 мянган малчин өрхийн 5,1 сая толгой үхэр, цаа буга, гахайг 94,0 %-ийн гүйцэтгэлтэй хамруулсан.

Намрын дархлаажуулалт, өвөлжилтийн бэлтгэлийг хангах, нөөц бүрдүүлэх зорилгоор ОХУ-ын Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах холбооны улсын төвтэй байгуулсан 2023 оны 03-р сарын 28-ны өдрийн 35/23 дугаартай гэрээний хүрээнд нийт 10,1 тэрбум төгрөгийн үнэ бүхий 3 цувралтай 9,0 сая тун вакциныг 1 ээлжээр хүлээн авч Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны А/251 дүгээр тушаалаар 21 аймаг, нийслэлийн 6,6 сая толгой үхэр, гахай, цаа буга хамруулахаас 114,1 мянган өрхийн 6,0 сая толгой үхэр, цаа буга, гахайг 92,7 %-ийн гүйцэтгэлтэйгээр хамруулсан.

Бог малын мялзан:

Бог малын мялзан өвчинтэй тэмцэх, устгах Дэлхийн хөтөлбөрийн хүрээнд 2027 онд вакцинжуулалтыг зогсоож, 2030 онд устгах арга хэмжээг олон улсад хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор 2023 онд бог малын мялзан өвчний гаралт Африкийн Руанда болон Турк улсад бүртгэгдсэн байна.

Зураг 92. Бог малын мялзан гаралт 2023 он. Эх сурваж. ДМАЭМБ-ын албан ёсны сайт

Монгол Улсад өвчний дэгдэлт 2022-2023 онд Төв, Булган, Архангай, Хөвсгөл аймагт дамжин тархсан.



Зураг 93. Бог малын мялзан өвчний дэгдэлт, 2023

Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчинтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн:

2023 онд төвийн бүсийн аймгуудад өргөн хүрээтэйгээр хэрэгжүүлсний үр дүнд өвчний дэгдэлт, тархалтыг тодорхой хэмжээгээр хязгаарласан.

Зураг 94. Дархлаажуулалтын аян, 2023

Дархлаажуулалтын аян хэрэгжүүлэх үндэслэл, төлөвлөлт: Уг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 онд дархлаажуулалтын арга хэмжээг мэдээлэл, сургалт, сурталчилгааг сайтар хийж өвчний дэгдэлт, тархалт, малын нягтрал, вакцины хүрэлцээ хангамж, малын төрөл, насыг харгалзан аян хэлбэрээр хэрэгжүүлснээрээ онцлог байв.

Дархлаажуулалтын арга хэмжээг дараах загварын дагуу төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Зураг 95. Дархлаажуулалтын арга хэмжээний төлөвлөлт, 2023

Дархлаажуулалтын үр дүн: Өвчний дэгдэлт, тархалт нэмэгдэх эрсдэлтэй төв, зүүн бүсийн 13 аймаг, нийслэлийн нийт 198 сум, дүүргийн 73,452 өрхийн 17.6 сая толгой бог мал, төлийг хамруулан 92.8 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсний үр дүнд 10-р сарын байдлаар 2 аймгийн 3 сумын 3 голомтод хорио цээрийн дэглэм хэрэгжиж, нийт 12 аймгийн 62 сумын 110 голомтын дэглэм бүрэн цуцлагдсан.

Үхрийн арьс товруутах өвчний гаралт:

Үхрийн арьс товруутах өвчний гаралт олон улсад 2023 онд Израли, ОХУ, Ливи, БНСУ-д тус тус бүртгэгдсэн байна. БНСУ-д 2023 оны 10-р сараас 2024 он дамжин 107 гаралт бүртгэгдсэн бол ОХУ-д хэд хэдэн гаралт бүртгэгдсэн бөгөөд 2023 оны 11-р сард Увс аймгийн Тэс сумын хилийн цаахан талд уг өвчний тохиолдол оношлогдсон байгаа нь цаашид 2024 оны урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөхөд анхаарах шаардлагатай байгааг харуулж байв.



Зураг 96. Үхрийн арьс товруутах өвчний гаралт
2023.01-12-р сар. ДМАЭМБ-ын мэдээлэл

Үхрийн арьс товуутах өвчний гаралт Монгол улсад 2022 оны 06-р сарын 30-ны өдрийн байдлаар Дорнод аймгийн Баянтүмэн суманд 2 голомт бүртгэгдэж байсан бол 2023 оны 07-р сарын 05-ны өдөр Булган аймгийн Сэлэнгэ суманд 1 өрхийн 2 үхэр илэрхий шинж тэмдэглтэйгээр өвчилснийг УМЭАЦТЛ-ийн шинжилгээний дүнгээр баталгаажуулан тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлсний үр дүнд дахин өвчлөл нэмж бүртгэгдээгүй зааврын дагуу хорио цээрийн дэглэмийг бүрэн цуцласан.

Урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ.

Өвчний халдвар дамжуулах гол хүчин зүйл болох ялаа, шумуулын нислэг эхлэхээс өмнө 2023 оны 03-04-р сард МЭЕГ-ын вакцины нөөцөд тулгуурлан

өвчний эрдсэл бүхий Дорнод аймгийн бүх сум, Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдын нийт 470,9 мянган толгой үхэр сүргийг хамруулахаар МЭЕГ-ын даргын 2023 оны 03-р сарын 09-ний өдрийн А/50 тушаалаар дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн. Дархлаажуулалтын арга хэмжээнд МЭЕГ-ын нөөцөд хадгалагдаж байсан Олон улсын цөмийн энергийн агентлаг (ОУЦЭА)-аас 2022 онд худалдан авч нийлүүлсэн Туркийн DOLLVET компанид Neethling омгоор үйлдвэрлэгдсэн 500,0 мянган тун вакцин (165,0 мянган евро), шингэлэгчийг ашигласан. Дархлаажуулалтын арга хэмжээнд нийт 2 аймгийн 16 сумын 5,150 малчин өрхийн 443,150 толгой үхэр сүргийг 94,0 хувийн гүйцэтгэлтэйгээр дархлаажуулсны зүүн бүсийн аймгуудад уг өвчний гаралт дахин бүртгэгдээгүй.

Хонины цэцэг:

Хонины цэцэг өвчний гаралт олон улсад 2023 онд Азарбайджан, Казакстан, ОХУ, Болгар, Бутан, Грек зэрэг улсуудад бүртгэгдсэн байна. ОХУ-ын хувьд Европ талдаа өввчний гаралт бүртгэгдсэн бол Казакстан улсад Баян-Өлгий аймгийн хилийн цаахан талд өвчний гаралт бүртгэгдсэн байгаа тул хонь болон хонины гаралтай бүтээгдэхүүн импортлоход анхаарах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөхөд харгалзах шаардлага байгааг харуулж байсан.

Зураг 97. Хонины цэцэг өвчний гаралт 2023.01-12-р сар.
ДМАЭМБ-ын мэдээлэл

Монгол улсад хонины цэцэг өвчний гаралт 2022 онд Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Төв аймгийн 10 суманд 15 голомт бүртгэгдэж 12 сард өвчний гаралт намжмал байдалтай болсон боловч 2023 оны 01-р сард Дорнод аймагт оношлогдож улмаар Хэнтий, Сүхбаатар, Төв, Дорноговь, Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай зэрэг 8 аймгийн 36 суманд 88 голомтод дамжин тархсан. Хонины цэцэг өвчний гаралт хөрш зэргэлдээ ОХУ болон Казакстан, Пакистан зэрэг

улсад төдийгүй манай улсад жил бүр давтагдан гарч байгаа нь өвчний гаралт, тархалтыг бүрэн таслан зогсоох устгах арга хэмжээг сайтар хэрэгжүүлээгүйтэй холбоотой. Иймд хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааварт өөрчлөлт оруулах (устгах заалт оруулах), нөхөн төлбөрийн зардлыг дараа жилийн төсөвт урьдчилан суулгаж, шуурхай олгодог болох, хорио цээр, малын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тактикийг өөрчлөх, хэрэгжилтийг сайжруулах ажлыг хэрэгжүүлэх шаардлага тулгарсан.



Зураг 98. Хонины цэцэг гаралт 2022.06



Зураг 99. Хонины цэцэг гаралт 2023.01

БҮЛЭГ 3.2 ГАЛ ТҮЙМРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Объектын гал түймэр

Улсын хэмжээнд 2023 онд объектын гал түймрийн 2996 тохиолдол бүртгэгдэж /гал түймэр дээр ажилласан 2319, зөрчил 395, мэдээлэл 238 тохиолдол бүртгэгдэж, 12 иргэний /том хүн 8, хүүхэд 4/ амь насыг аварч, утаажилтын бүсээс 1025 иргэнийг гаргаж, гал түймэрт 59 иргэн /том хүн 53, хүүхэд 5, өөрийгөө шатаасан 1 том хүн/ өртөж нас барж, 35 иргэн /том хүн 32, хүүхэд 3/ түлэгдэж, 7 иргэн /7 том хүн, 0 хүүхэд/ угаартсанаас, 1 иргэн /том хүн 1, хүүхэд 0/ угаартаж нас барсан байна.

Объектын гал түймрийн дуудлага, мэдээллийг өнгөрсөн оны мөн үеэтэй харьцуулахад гал түймрийн тоо **3** хувиар буурсан, гал түймэрт өртөж нас барсан хүний тоо 32.2 хувиар өссөн байна.

Ой, хээрийн гал түймэр

Улсын хэмжээнд 2023 оны байдлаар Архангай, Баянхонгор, Булган, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл Баян-Өлгий, Увс, Хэнтий, Завхан, Говьсүмбэр, Өвөрхангай зэрэг 14 аймгийн 42 суманд 101 удаагийн ой, хээрийн гал түймэр бүртгэгдсэн. Ой, хээрийн гал түймрийн дуудлагын тоог 2022 оны мөн үеэтэй харьцуулахад **43%**-иар буурсан.

Зураг 100. Ой хээрийн түймрийн тархалт

Ой, хээрийн түймрийг унтраах ажиллагаанд Онцгой байдлын байгууллагын 1286 алба хаагч, 125 автомашин, Хил хамгаалах байгууллагын 399 алба хаагч, 49 автомашин, 2 морь, Зэвсэгт хүчний 52 алба хаагч, 3 автомашин, 2 нисдэг тэрэг, Цагдаагийн байгууллагын алба 10 хаагч, 3 автомашин, орон нутгаас 3142 иргэн, 492 автомашин, 1 трактор, 91 мотоцикл,18 морь, нийт 4889 хүн, 669 автомашин, 3 нисдэг тэрэг, 1 трактор, 91 мотоцикл, 20 морьтой ажилласан.

Зураг 101. Ажилласан хүч хэрэгсэл

Дээрх түймэрт урьдчилсан байдлаар 36 гэр, (сууц) 74 хашаа (саравч), 5 автомашин, 5,327 мал, ойн 1,295 га, хээрийн 1,028,107га, нийт 1,029,402га талбай өртөж байгаль экологид 1,850,762,463төгрөг, эд материалын 1,176,104,466 төгрөг, гал түймрийг унтраахад 55,629,776 төгрөг зарцуулж, нийт 3,082,496,705 төгрөгийн хохирол учирсан байна.

ОХУ-ын талаас Монгол улсын хил дамнан Дорнод аймгийн Чулуунхороот, Увс аймгийн Тэс, Сагил, Сэлэнгэ аймгийн Ерөө сумдын нутгаар тус бүр нэг удаа нийт 4 удаа хээрийн түймэр орж ирсэн.

Монгол Улсын талаас ОХУ-ын тал руу Дорнод аймгийн Чулуунхороот, Дашбалбар сумаар тус бүр нэг удаа нийт 2 удаа хил дамнан гарсан.

Монгол Улсын талаас БНХАУ-ын тал руу Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумаар 3 удаа, Дорнод аймгийн Чулуунхороот сумаар 3 удаа, Халхгол сумаар 2 удаа, Баянтүмэн, Чойбалсан сумаар тус бүр 1 удаа нийт 10 удаа хээрийн гал түймэр дамнан гарсан.

Зураг 102. Түймрээс учирсан хохирол

2023 онд тохиолдсон томоохон хэмжээний объектын болон ой, хээрийн гал түймэр:

Объектын гал түймэр

“Баянгол дүүрэг 25 дугаар хороо Улаанбаатар гурил үйлдвэрийн агуулахын барилгад 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 06 цаг 37 минутад гал түймэр гарч уг гал түймрийг унтраах ажиллагаанд Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газар, Нийслэлийн онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 10, 14, 18, 26 дугаар ангийн нийт 73 алба хаагч, 13 автомашинтай ажилласан. Дээр гал түймрийг унтраах ажиллагаанд 248 тн гал унтраах бодис

/ус/, 550л хөөс, 1072.93л шатахуун зарцуулж, 40ш Амьсгалын бие даасан төхөөрөмж ашигласан байна.

Зураг 103. Улаанбаатар гурил үйлдвэрийн агуулахын барилгад гарсан галыг унтрааж буй байдал

Ой, хээрийн гал түймэр

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын "Хадын булаг" багийн "Уртын цагаан" гэдэг газар 2023 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр /аймгийн төвөөс зүүн урд зүгт 290 км-т, сумын төвөөс зүүн зүгт 70 км-т/ хээрийн түймэр гарч Дорнод аймгийн Халхгол сумын чиглэлд тархаж, нийт 2,125,347 га талбай, 1 байшин, 15 гэр, 4 автомашин, 40 хашаа, саравч, 4714 бог мал, 860 бод мал, 148 ан амьтан өртөж, нийт 17,06 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Уг хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд Онцгой байдлын ерөнхий газар, Үндэсний аврах бригад, Сүхбаатар, Дорнод Хэнтий аймгийн Онцгой байдлын газруудаас нийт 144 алба хаагч, 12 автомашин, 1 нисдэг тэрэг, Хилийн цэргийн 53 алба хаагч, 4 автомашин, орон нутгийн мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн 99 хүн, 29 техник хэрэгсэл, нийт 343 хүн, 41 автомашин, 1 трактор, 1 нисдэг тэрэгтэй ажиллаж, 2023.04.11-ний өдрийн 12:16 цагт түймрийг цурамд оруулж, 2023.04.13-ны 09.00 цагт бүрэн унтраасан байна.



Зураг 104. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын "Хадын булаг" багийн "Уртын цагаан"-д гарсан ой хээрийн түймэр

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ.

ХОР УРШГИЙГ АРИЛГАХ, СЭРГЭЭН БОСГОХ АЖИЛЛАГАА

БҮЛЭГ 4.1. УЛСЫН НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын хэмжээнд 2023 онд тохиолдсон гамшиг ослын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 4 удаагийн шийдвэрээр улсын нөөцөөс бараа, материалыг зарцуулсан байна.

1. Монгол Засгийн газрын 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн "Улсын нөөцөөс бараа, материал гаргах, нөхөн бүрдүүлэх тухай" 133 дугаар тогтоолоор 2022-2023 оны өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан өвөлжилт хүндэрсэн 13 аймаг УБ хотын алслагдсан дүүрэгт 127.1 сая төгрөгийн 235.3 тонн өвс, 2.0 тэрбум төгрөгийн 4.1 мянган тонн тэжээлийг 50-100 хувь хямдруулан олгож, тээвэрлэн хүргэх ажлыг зохион байгуулан ажилласан. Мөн өвөлжилт хүндэрсэн аймгууд болон Улаанбаатар хотын алслагдсан дүүргүүдэд 1.6 тэрбум төгрөгийн 18 ширхэг автомашин, 78 сая төгрөгийн 12 ширхэг иж бүрэн гэр, 120.9 сая төгрөгийн хүнсний бараа, 391.1 сая төгрөгийн шатахуун, 40 сая төгрөгийн дулаан хувцас, 210.2 сая төгрөгийн эрүүл мэндийн болон хүнсний багц нийт 2.5 тэрбум төгрөгийн бараа, материалыг олгожээ.

2. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн "Хөрөнгө гаргах тухай" 208 дугаар тогтоолоор цаг агаарын аюулт үзэгдэл гал түймэр, хүчтэй цасан болон шороон шуурганы улмаас учирсан хохирлыг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох зорилгоор улсын нөөцөөс 1.3 тэрбум төгрөгийн 222 ширхэг иж бүрэн гэр, 1.1 тэрбум төгрөгийн 8 ширхэг автомашин, 18.1 сая төгрөгийн 250 ширхэг хүнсний багц, 26.1 сая төгрөгийн ариутгал халдвар хамгааллын хэрэгсэл, 159.5 сая төгрөгийн 40 тн шатахуун нийт 2.6 тэрбум төгрөгийн бараа, материалыг олгосон байна.

3. Бүгд Найрамдах Турк улсад хүчтэй газар хөдлөлт болж, олон хүний амь үрэгдэж, их хэмжээний хохирол учирсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 48 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газраас Бүгд Найрамдах Турк улсад хүмүүнлэгийн тусламж үзүүлэхээр шийдвэрлэж, улсын нөөцөөс 107.5 сая төгрөгийн 5 тн махан нөөш, 30 сая төгрөгийн 1 тн лаа, 63.8 сая төгрөгийн 1064 ширхэг дулаан хөнжил, 130 сая төгрөгийн 20 ширхэг иж бүрэн 5 ханатай гэр, аврах багийн гишүүдэд 11 сая төгрөгийн 2 ширхэг цахилгаан үүсгүүр, 4 сая төгрөгийн 2 ширхэг майхан, 14.1 сая төгрөгийн хувцас хэрэгслийг тус тус олгож, тээвэрлэн хүргэх ажлыг зохион байгуулсан.

4. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн "Хөрөнгө гаргах тухай" 293 дугаар тогтоолоор Улаанбаатар хот болон орон нутагт үргэлжлэн орсон аадар бороо, үерийн улмаас үүссэн нөхцөл байдлын хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор улсын нөөцөөс 21 ширхэг иж бүрэн гэр, 13 ширхэг автомашин, 3 ширхэг

цахилгаан үүсгүүр, 6 ширхэг усны насос, 200 ширхэг хүрз, 300 ширхэг шуудай, 500 ширхэг бээлий, 68 ширхэг цув зэрэг нийт 1.8 тэрбум төгрөгийн бараа, материалыг зарцуулсан байна.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 7.3.15-д "Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулж, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлнэ" гэж, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 7.3.4, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.14-т Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бараа, материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан агуулах, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулна" гэж тус тус заасны дагуу дээрх 2 төслийн газар, зураг төсөв, холбогдох техникийн нөхцөл, ТЭЗҮ зэрэг шаардлагатай баримт бичгүүдийг боловсруулж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

БҮЛЭГ 4.2. ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар гамшигт нэрвэгдсэн Бүгд Найрамдах Турк Улс, Арабын Бүгд Найрамдах Сири Улсад хүмүүнлэгийн аврах баг илгээх, бараа, материалын тусламж үзүүлэхээр шийдвэрлэж 2023 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн 48 дугаар, 5 дугаар сарын 31-ний өдрийн 209 дүгээр тогтоол тус тус батлагдаж улсын нөөцөөс 10 тонн махан нөөш, 20 гэр, 1500 хөнжил, 2 тонн лаа зэрэг нийт 495 сая төгрөгийн бараа, материалын тусламж үзүүлэхээр шийдвэрлэсэн.

Бүгд найрамдах Турк улсад 107.5 сая төгрөгийн 5000 кг махан нөөш, 30 сая төгрөгийн 1 тн лаа, 63.8 сая төгрөгийн 1064 ширхэг хөнжил, 130 сая төгрөгийн 20 ширхэг иж бүрэн гэр буюу нийт 331.3 сая төгрөгийн бараа, материалын тусламж үзүүлсэн байна.

Дээрх тусламжийн бараа материалаас БНТУ-д илгээсэн 3 тонн махан нөөш, 1 тонн лаа, 558 ширхэг хөнжил буюу 4.6 тонн бараа, материалыг 2 дугаар сарын 7-ны өдөр тус улс руу Монгол Улсын Эрэн хайх, аврах багийг хүргэсэн "Монголиан эйрвэйс" ХХК-ийн агаарын хөлгөөр хамт тээвэрлэн 2 дугаар сарын 8-ны өдөр Эрэн хайх, аврах багийн ахлагч, бригадын генерал Б.Ууганбаяр БНТУ-ын Гадаад харилцааны яамны тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд Мустафа Юурдакулад, "МИАТ" ТӨХК-ийн 2 дугаар сарын 9-ний өдрийн нислэгээр тээвэрлэн хүргэсэн 2 тонн махан нөөш, 442 ширхэг хөнжил, 10 гэр,

нийт 7.1 тонн тусламжийн бараа материалыг Монгол Улсаас БНТУ-д суугаа Элчин сайд Г.Мөнхбаяр тус улсын Гэр бүл, нийгмийн халамж, үйлчилгээний яамны Истанбул дахь төлөөлөгчийн газарт тус тус гардуулан өгсөн.

Хүмүүнлэгийн тусламжийн ачааны гурав дахь хэсэг болох 13.7 тн ачааг "МИАТ" ТӨХК-ийн 2 дугаар сарын 12-ны өдрийн Улаанбаатар-Истанбул чиглэлийн нислэгээр илгээснийг 2 дугаар сарын 13-ны өдөр БНТУ-ын Истанбул хот дахь Монгол Улсын Ерөнхий консул Ш.Хишигсүрэн БНТУ-ын Гэр бүл, нийгмийн халамж, үйлчилгээний яамны Истанбул хот дахь төлөөлөгчийн газар, Гадаад харилцааны яамны Истанбул хот дахь төлөөлөгчийн газар, Гамшиг, Онцгой байдлын удирдлагын газарт хүлээлгэн өгчээ.

Эрэн хайх, аврах баг 2 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсаас хүмүүнлэгийн тусламжаар илгээсэн гэрийг барьж, багийн ахлагч, бригадын генерал Б.Ууганбаяр БНТУ-ын Үндэсний их хурлын гишүүн Хасан Серт, Мурат Демир болон албаны бусад хүмүүст хүлээлгэн өгсөн байна.

Зураг 105. Монгол Улсын Засгийн газраас олгосон хүмүүнлэгийн тусламжийг хүлээлгэн өгөх үйл ажиллагаа

Бүгд Найрамдах Турк Улсад үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийн барааг бэлтгэх, тээвэрлэн хүргэх, хүлээлгэн өгөх ажиллагаанд:

- ОБЕГ-н Улсын нөөцийн газраас 9 албан хаагч 3 техник хэрэгсэл,
- ОБЕГ-н дэргэдэх 179 дүгээр ангиас 27 албан хаагч 4 техник хэрэгсэл,
- ОБЕГ-н дэргэдэх 185 дугаар ангиас 33 албан хаагч 4 техник хэрэгсэл

буюу нийт 69 албан хаагч 11 техник хэрэгсэлтэйгээр ажилласан.

Улаанбаатар хотод үргэлжлэн орсон борооны улмаас үүссэн үерийн нөхцөл байдалтай холбогдуулан гамшгийн хариу арга хэмжээ авч үерийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа байгууллага, алба хаагчдад зориулан иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас Улсын Онцгой комисст ирүүлсэн техник хэрэгсэл, бараа, материалыг хүлээн авах, бүртгэх, хадгалах, хуваарилан олгох, тээвэрлэн хүргэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажилласан. Үүнд:

2023 оны 7, 8 дугаар сард Улсын онцгой комисст 2 иргэн, 5 аж ахуйн

нэгж байгууллагаас 434.4 сая төгрөгийн 30937 ширхэг 12 нэр төрлийн бараа, материалын хандив ирүүлснээс 323.4 сая төгрөгийн 29912 ширхэг бараа, материалыг хуваарилан олгож, хариу арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна.

БҮЛЭГ 4.3 МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙН НИЙГЭМЛЭГЭЭС ЗАРЦУУЛСАН ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ

Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбоо, НҮБ-ын Хүүхдийн сан, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран 2022-2023 оны өвөл зудын өндөр, нэн өндөр эрсдэлтэй болон өвөлжилт хүндэрсэн 20 аймаг, 2 дүүргийн 4800 малчин өрх, 18,000 хүнд нийт 2.6 тэрбум төгрөгийн хүмүүнлэгийн тусламжийг үзүүлсэн байна. Үүнд:

- Цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан зудын эрсдэлийн зурагт өндөр болон нэн өндөр эрсдэлтэй 13 аймгийн 114 сумын зорилтот бүлгийн 1000 өрхөд Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооны Гамшгийн яаралтай тусламжийн сангийн дэмжлэгтэйгээр 370,300,000 төгрөгийн бэлэн мөнгөний тусламж үзүүлжээ.
- НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран зудын нэн өндөр эрсдэлтэй 400 өрхөд 148,120,000 бэлэн мөнгөний тусламж үзүүлэв. Тусламж хүртэгчдийг сонгохдоо: Хонин толгойд шилжүүлснээр 50-500 хүртэл малтай; Ган, зудын улмаас отроор явж байгаа; Жирэмсэн эсвэл хөхүүл хүүхэдтэй эх, 18-аас доош насны 3 буюу түүнээс олон хүүхэдтэй өрх толгойлсон өрх; 18-аас доош насны 5 буюу түүнээс дээш хүүхэдтэй өрх гэсэн шалгуураар тусламж олгов.
- АНУ-ын Олон улсын Хөгжлийн агентлагийн Хүмүүнлэгийн тусламжийн товчоотой хамтран цагаанаар зудтай 17 аймгийн 850 өрхөд 314,755,000 төгрөгийн бэлэн мөнгөний тусламж үзүүлсэн байна.
- Швейцарын хөгжлийн агентлагтай хамтарч Өвөрхангай аймгийн, Бат-Өлзий, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Увс аймгийн Тэс, Баруунтуруун, Төв аймгийн Алтанбулаг, Цээл, Баян, Хэнтий аймгийн Жаргалтхаан, Өмнөдэлгэр сумын нийт 550 малчин өрхөд 228,000,000 төгрөгийн хүнс, ариун цэврийн багцын тусламж үзүүлжээ.
- Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооны Гамшгийн яаралтай тусламжийн сангаас 2,000 малчин өрхөд 1,174,600,000 төгрөгийн бэлэн мөнгө, малын эрдэс тэжээлийн багц хүмүүнлэгийн тусламж үзүүлэв.
- Цасан болон шороон шуурганд нэрвэгдсэн 1000 өрхөд Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооны Гамшгийн яаралтай тусламжийн сангийн дэмжлэгтэй бэлэн мөнгөний тусламж, орон

гэрээ бүрэн алдсан 99 өрхөд 5 ханатай иж бүрэн Монгол гэрийн тусламж үзүүлсэн байна.

Түүнчлэн гамшгийн хариу арга хэмжээ болон нийгмийн эрүүл мэнд, өрхийн амьжиргааг дэмжихэд Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн Холбоо, Австралийн Улаан загалмай нийгэмлэг, Катарын Улаан хавирган сар нийгэмлэг, НҮБ-ын Хүүхдийн Сан, Швейцарын хөгжлийн агентлаг, АНУ-ын хөгжлийн агентлаг, БНГУ-ын ЭСЯ, Японы улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран 5.2 тэрбум төгрөгийн хүмүүнлэгийн тусламжийг байгалийн гамшигт нэрвэгдсэн 15100 өрхийн 58,590 хүнд хүргэсэн байна.

БҮЛЭГ 4.4. УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын онцгой комиссоос 2023 онд Монгол Улсын хэмжээнд тохиолдсон гал түймэр, үер, цаг агаарын аюулт үзэгдэл, гамшгийн улмаас орон гэргүй болсон иргэдэд учирсан хохирлыг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чиглэлээр, зохион байгуулалтын арга хэмжээг авч, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэн Улсын онцгой комисс дараах бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын 8,

Улсын онцгой комиссын 1 тогтоол,

Улсын онцгой комиссын 4 албан даалгавар,

Улсын онцгой комиссын даргын 9 тушаалыг баталж, Улсын онцгой комиссын хуралдааныг 4 удаа хуралдуулж, тусгай чиг үүрэг бүхий шуурхай бүлэг, ажлын хэсэг байгуулан холбогдох арга хэмжээг авч, үүрэг, чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Зураг 106. Улсын Онцгой комиссын өвөлжилтийн нөхцөл байдлын талаархи 2023 оны 11 сарын 28-ны өдрийн хуралдаан

Улсын онцгой комиссоос 2023 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгууд 2023 оны 5 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд болсон цаг агаарын аюулт үзэгдлийн улмаас учирсан хохирлыг цаг алдалгүй арилгах, шуурхай хариу арга хэмжээг авч хэрэгжүүлж, Монгол Улсын Засгийн газрын 208 дугаар тогтоолоор улсын нөөцөөс бараа материалл, шатахуун зэрэг 2.6 тэрбум төгрийг шийдвэрлэв.

Нийслэл Улаанбаатар хот болон аймаг орон нутагт 2023 оны 7-8 дугаар саруудад их хэмжээний бороо орж, үерийн аюул болсонтой холбогдуулан Улсын онцгой комисс 7-8 дугаар сард 2 удаа хуралдаж, цаг үеийн асуудлаар цахим хурал зохион байгуулж, улсын болон орон нутгийн онцгой комисс, мэргэжлийн байгууллагууд, бүх шатны Засаг дарга нарт холбогдох үүрэг, чиглэлийг өгч ажиллав.

Баян-Өлгий аймгийн хэмжээнд зургаадугаар сард цаг агаарын хэт халалтын улмаас ууархаг бүсийн цас ихээр хайлснаас модон 2, төмөр бетон 1 гүүр үерт өртөж, дахин ашиглах боломжгүй болсныг сэргээн засварлах, Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Хараа голын гүүр болон Хилийн Гашуунсухайт боомт дахь нүүрс тээврийн зам, чингэлэгт тээврийн терминал, гаалийн хяналтын бүс, барилга байгууламж, хил хяналтын байгууллагуудын албаны байр, орон сууц, эд хөрөнгөд учирсан хохирлыг арилгахад шаадлагатай нийт 3.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлсэн.

Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд :

2023 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 279 дүгээр тогтоолоор “Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” тогтоол гарсан. Улсын онцгой комиссоос 2023 оны 7 дугаар сарын 24-ний өдөр 21 аймгийн Засаг дарга, аймгийн Онцгой комиссын гишүүдтэй цахим хурлыг зохион байгуулж, өвөлжилтийн бэлтгэл хангаж ажиллах талаар үүрэг чиглэлийг өгсөн.

2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн “Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай” 03 тоот албан даалгаварыг гарсан.

Онцгой байдлын ерөнхий газраас “Ган, зудын эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ын дагуу 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдөр “Гангийн эрсдэлийн үнэлгээг 13 аймагт хийж, үнэлгээнд тулгуурласан зөвлөмж гарав.

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан цасан бүрхүүл тогтож, 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндрэх төлөвтэй байгаа тул цаг агаарын аюулт үзэгдэл, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, аймаг, нийслэлийн Онцгой комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх,

нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах Шуурхай бүлгийг Улсын онцгой комиссын даргын 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 7 дугаар тушаалаар байгуулж ажиллав.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр өвөлжилтийн нөхцөл байдлын талаар танилцуулгыг хийлээ. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар өвөлжилтийн нөхцөлийн байдлын талаар хэлэлцэж, Засгийн газрын хуралдаанаа 49 дүгээр тэмдэглэлээр гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Онцгой комисст үүрэг болгосон. Тус тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу 2023 оны 12 дугаар сард Дорнод, Завхан, 2024 оны 01 дүгээр сард Дундговь, Сүхбаатар, Баянхонгор аймгууд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн байдлын зэрэгт шилжиж ажиллав.

Улсын онцгой комиссын даргын 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 8 дугаар тушаалаар ҮСХ, ХНХЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ, ЦХХХЯ, ЭХЯ, ЭМЯ, ЗХЖШ, ХХЕГ, ГЕГ, ОБЕГ, ХХҮЕГ, АМГТГ, ЦУОШГ, МЭЕГ-ын төлөөллөөс бүрдсэн Улсын онцгой комиссын Шуурхай штаб байгуулагдан ажиллаж байна. Нөхцөл байдалд тохируулан авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан 21 аймаг, нийслэлийн алслагдсан дүүргийн малчид, мал бүхий иргэдэд Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 449 дүгээр тогтоолоор улсын нөөцөөс 4015 тонн хивэг, 1274 тонн хорголжин тэжээлийг 50 хувь хямдруулан олгох асуудлыг Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүллээ.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар 82 мянган тонн хүнсний улаанбуудай импортлох зөвшөөрлийг олгож, өвсний экспортыг 2023 оны 9 дүгээр сард, тэжээлийн экспортыг 11 дүгээр сард зогсоох шийдвэрийг гаргасан.

Цас их орсны улмаас өвөлжилт хүндэрсэн Төв, Архангай, Завхан аймгийн Онцгой комиссын үйл ажиллагаанд шаардлагатай 60 тонн шатахуун, түлшийг Улсын онцгой комиссын даргын шийдвэрээр тус аймгуудад шийдвэрлэсэн.

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлийг үндэслэн гурил, гурилан бүтээгдэхүүний чанар, хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор гурил үйлдвэрлэгч 8 аж ахуйн нэгжид 88.0 мян.тн хүнсний улаанбуудай импортлох зөвшөөрлийг олгосон бөгөөд 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 30.8 мянган тонн хүнсний улаанбуудайг импортолсон байна.

Өвөлжилтийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд мэдээлэл хийж, “Өвөлжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны 17 дугаар тогтоол батлагдлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар өвөлжилтийн нөхцөлийн байдлын талаар хэлэлцэж, Засгийн газрын хуралдааны 51 дүгээр тэмдэглэлээр малын тэжээлийн экспортыг 2024 оны 3 дугаар сарын 1 хүртэл зогсоосон хугацааг 2024 оныг дуустал сунгах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Мөн Улсын хил дагуу орших аймаг, сумдад өргөн хэрэглээний хүнс, гурил, тэжээл, бензин, шатахууныг тухайн бүс нутагт байрлах улсын хилийн боомтоор шуурхай нийлүүлэх боломжийг судалж, шийдвэрлэж ажиллахыг Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд болон Гаалийн ерөнхий газрын дарга нарт тус тус даалгасан.

Улсын онцгой комиссын даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 9 дүгээр тушаалаар малчдын худалдан борлуулахаар нөөцөлсөн махыг зах зээлд нийлүүлэх, махны экспортыг нэмэгдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгууллаа.

Монгол Улсын баруун аймгуудад тээврийн зардлаас хамаарч улаанбуудайн гурил бусад бүсээс өндөр үнэтэй байгааг харгалзан Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь боомтоор баяжуулаагүй гурил импортлох нөхцөлийг бүрдүүлж, орон нутгийн 17 аж ахуйн нэгжид нийт 12.0 мян.тн улаанбуудайн гурил импортлох зөвшөөрлийг олгосон. 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 3.1 мянган тонн улаанбуудайн гурил импортолсон байна.

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 479 дүгээр тогтоолоор дахин 3893 тонн малын тэжээлийг 50 хувь хямдруулан олгохоор шийдвэрлэсэн.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

ТАВДУГААР ХЭСЭГ.

2023 ОНЫ ОНЦЛОХ НӨХЦӨЛ БАЙДАЛ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

БҮЛЭГ 5.1. УЛААНБААТАР ХОТЫН ҮЕРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

5.1.1 Нийслэл Улаанбаатар хотод тохиолдсон үерийн нөхцөл байдал, /2023 оны 7 дугаар сар/

Туул, Тэрэлж, Сэлбэ голуудын усны түвшин 2023 оны 07 дугаар сарын 04-10-ны өдрүүдэд үерийн аюултай түвшнээс 40-50 см-ээр давж, онц хүчтэй үерлэж, нөхцөл байдал хүндэрсэн. Үүний улмаас Улаанбаатар хотод 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Баянзүрх дүүргийн 43 дугаар хорооны нутаг дэвсгэрт Сэлбэ голын ус эргээсээ хальж барилга байгууламжийн зоорийн болон 1 дүгээр давхар усанд автсан.

Улаанбаатар хот орчимд Туул голын үерийн түвшин 202 см, үерийн аюултай түвшин 260 см байдаг бөгөөд 2023 оны 07 дугаар сарын 7-8 шилжих шөнө, 08-ны өглөөний 6 цагийн байдлаар 311 см хүрч, үерийн аюултай түвшин 50 см-ээр давав.

Үерийн улмаас нийслэлийн **26** хорооны **31,6 мянган** өрхийн **128,1 мянган** хүн, **11** байршилд гудамж, зам, нүхэн гарц, **144** барилга байгууламж үерт өртсөн, **52,965** хэрэглэгч (барилга) цахилгаангүй болж, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, инженерийн байгууламжид хохирол учирчээ.

Хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор УОК-ын Нэгдсэн шуурхай штабын үйл ажиллагаа идэвхжиж ажиллан, Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабыг байгуулж, “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/769, А/789 дүгээр захирамжийг батлуулан хариу арга хэмжээг зохион байгуулжээ.

Нийслэлийн Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх, Баянгол, Чингэлтэй дүүргийн 18 байршилд Нийслэл, дүүргийн Гамшгаас хамгаалах алба, Мэргэжлийн анги, нутгийн захиргаа, төрийн цэргийн болон тусгайлсан чиг үүргийн байгууллагын нийт **14,828** ажилтан, алба хаагч **2,203** техниктэй үүрэг гүйцэтгэн ажилласан.

Онцгой байдал, Зэвсэгт хүчин, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаа, Дотоодын цэрэг зэрэг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын нийт 3,991 албан хаагч, 290 техник хэрэгсэлтэй 24 цагаар ээлжээр үүрэг гүйцэтгэн дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2.6 тэрбум төгрөгийг шийдвэрлэж үерийн хор уршгийг арилгах, хариу арга хэмжээнд зарцуулан ажилласан байна.

Хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ

Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штаб Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн дараах томоохон байршлууд усанд автсаныг үерийн эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээг зохион байгуулах, сэргээн босгох чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан.

2023.07.04-ний өдрийн байдлаар:

Хүснэгт 4. Үерт автсан томоохон байршлууд

д/д	Дүүрэг	Байршил
1	СХД	25 дугаар хороо 170 дугаар цэцэрлэгийн баруун талд хайрхны 1 дүгээр гудамж
2		9 дүгээр хороо төв зам дагуу
3	СБД	1 дүгээр хороо “Улаанбаатар Буян” ХХК-ийн орчим Сэлбэ голын далан
4		15-20 дугаар хороо зуслан
		43-р хороо Сэлбэ голын далан
5	БЗД	4-р хороо Алтай хотхон
6	БГД	4-р хороо Алтай хотхон
7	ХУД	1-р хороо 39-р байр, Дунд гол
8		20-р байр
9		9 дүгээр хороо, Нисэхийн эцэс орчим
10		12 дугаар хороо, Биокомбинат орчим
11	ЧД	19 дүгээр хороо

Зураг 107. Үерийн усанд өртсөн 93 байрны байршил
/тод болон бүдэг цэнхэр өнгөөр тэмдэглэсэн/



Зураг 108. 7 дугаар сарын 5-ны үерийн нөхцөл байдал

Зураг 109. Зураг Үерийн үеийн хүндэрсэн нөхцөл байдлын зураг

2023 оны 07 сарын 07 ны өдөр агаараас ажиглалт хийн усны түвшинд хэмжилт хийж, үерийн нөхцөл байдлыг фото зургаар баталгаажуулсан.

Зураг 110. Үерийн усанд хүндрэх эрсдэлтэй байршил /7 дугаар сарын 05-ны байдал/

Зураг 111. Үерийн усанд хүндрэх эрсдэлтэй байршил /7 дугаар сарын 05-ны байдал/

Баянзүрх дүүргийн 23-р хороонд Улиастайн 3-р хэсгийн 20 айл усанд автаж , 25-р хороо, 26 дугаар хороонд Баянмонгол хорооллын нүхэн гарц, Сэлбэ гол дагуу "S outlet дэлгүүр", Баруун уулын далан, Дүнжингарав худалдааны төвийн далан, Сэлбэ голын далангийн байршил, 43 дугаар хороонд Сэлбэ голын эрэг дагуу 27 орон сууцны В1 давхар, граж усанд автаж Нийслэлийн Онцгой

байдлын газар, дүүргийн Онцгой байдлын хэлтсээс 51 алба хаагч 10 автомашин, дүүргийн Засаг даргын тамгын газар, хороо, СӨХ-ийн 20 ажилтан, 5 автомашин, Тохижилт үйлчилгээний хэлтсээс 24 ажилтан, Цагдаагийн байгууллагаас 120 алба хаагч, 12 автомашин, Геодези усны барилга байгууламжийн газраас 17 ажилтан, 11 автомашин, Ус суваг удирдах газраас 35 ажилтан, 8 автомашин, Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ-аас 45 ажилтан, 3 автомашин, 1 ковш, 1 крантай, нийт 288 ажилтан алба хаагч, 51 нэгж техниктэй ажилаж Усыг соруулах, шуудуу татах, далан босгон ажилласан.



Зураг 110. 7 дугаар сарын 5, 6-ны өдрүүдэд үерт өртсөн болон үерийн эрсдэлтэй байршлууд

Ариутгал халдваргүйжүүлэлт:

Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд гэр хорооллын болон Нарны зам, Их, бага тойруу, Гандигийн гудамж, Денвер, Баянмонгол, Замын цагдаа, Алтай хотхон, Парисын гудамж, Дундгол зэрэг газруудад нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, байрны 2,208,000 м2 талбайд мананцар үүсгэгч 5 автомашин, хувийн хэвшлийн 5 ариутгалын машин ариутгаж, халдваргүйжүүллээ.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын хяналтын 5 байцаагч 2023 оны 07 дугаар сарын 8, 9, 10, 14, 15, 16-ны өдрүүдэд лабораторийн шинжилгээтэй хяналтыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. УСУГ-ын харъяа Баянгол, УСАТ, Нисэх, Биокомбинат, Төв, Чингэлтэй, Дамбадаржаагийн бохир ус цэвэрлэх байгууламжид орж ирж байгаа болон цэвэрлэсэн бохир уснаас химі, нян судлалын нийт 28 дээж;

2. УСУГ-ын харъяа Нийслэлийн ундны усны 6 эх үүсвэр, 80 ус түгээх байр, нийтэд ус түгээж буй хувийн эзэмшлийн 11 гүн өрмийн худгийн уснаас химі, нян судлалын нийт 194 дээж;

3. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хөрсний бохирдлын түвшингээр тогтоогдсон нийт 74 цэгээс нийт 90 дээж тус тус авч холбогдох стандартын шаардлагад нийцэж буй байдалд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор Стандарт хэмжилзүйн газрын Нийслэлийн төв лабораторид шинжлүүлсэн.

Авто зам, гүүрийн хөдөлгөөнийг хэсэгчлэн хааж ажилласан талаар:

Үерийн нөхцөл байдалтай холбогдуулан нийт 11 авто зам, 5 нүхэн гарц болон зарим хотхонууд усанд автсан тул дараах байршлуудад авто зам, гүүрийн хөдөлгөөнийг хэсэгчлэн хааж, нөхцөл байдал тогтворжсоны дараа нээж, хэвийн горимд шилжүүлсэн.

Цахилгаан эрчим хүч

Хотын төвийн зургаан дүүргийн хэмжээнд үерийн улмаас 1,113 дэд өртөөнд холбогдсон 52,965 хэрэглэгчийг болзошгүй эрсдэлээс сэргийлж, цахилгааныг нь тасалсан бөгөөд зоорийн давхар үерт автсан барилга байгууламжийн усыг соруулж, лаг цэвэрлэгээ хийсний дараа бүх хэрэглэгчийн цахилгаан хангамжийг сэргээсэн.

УБЦТС ТӨХК-ийн 434 инженер техникийн ажилтан, 93 техник хэрэгсэлтэйгээр дэд өртөөнд үзлэг хийж, үерт автагдаж болзошгүй дэд өртөөнд ус орохоос сэргийлэх арга хэмжээ авч, цахилгаан дамжуулах 24 тулгуурыг тэгшлэх, хүчитгэх, сэргээн босгох болон бусад засвар үйлчилгээг шуурхай хийж гүйцэтгэсэн.

Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүдийн нийт усанд автсан нийт 243 өрхийн 743 иргэнийг аюулгүй байршилд нүүлгэн шилжүүлсэн.

Геодези, Усны барилга байгууламжийн газар:

Энхтайвны гүүрний нүхэн гарцанд насосоор 220 рейсээр 2300 тн ус соруулж, 49 рейсээр 722 тн дайрга, шороо зөөж ажилласан. Баянмонгол хороллын нүхэн гарцанд 3300 м3 /мотопомпоор/ ус соруулсан.

Хот байгуулалт, хөгжлийн газар:

Үүссэн нөхцөл байдалтай холбоотой Улаанбаатар хотын Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний өнөөгийн байдлын төлөвлөлтийн зургийн төслийг А0 форматаар хэвлэн мэдээлэл гаргаж Сэлбэ, Дунд голын онцгой хамгаалалтын бүс (244.4 га) талбайд байрлаж байгаа нийт 734 барилга байгууламжийн судалгааг гаргасан.

Ус сувгийн удирдах газар:

Тус газраас 50 гаруй ажилтан 14 машин механизмтай ажиллан Сэлбэ голын баруун хэсгийн 250 гаруй метр урт даланг шуудайтай элсээр өндөрлөж үерийн усны халиаг зогсоосон. Мөн Сэлбэ голын зүүн эрэг дагуух байрнуудын В1 болон 1 давхрын усыг 200 м3-н 3ш, 80 м3-н 5ш насосоор цагт 900 м3 хүчин чадалтай төхөөрөмжөөр усыг соруулан ажилласан.

Нийслэлийн Цагдаагийн удирдах газар:

Нийслэл хотын гудамж замд 150 цэгт 261 алба хаагч үүрэг гүйцэтгэв. Баянзүрх дүүрэг 43 хорооны нутаг дэвсгэрийн Сэлбийн голын далан сэтэрч ойр орчмын байшин хороолол усанд автсан тул Натур худалдааны төвийн орчмын замын орох гарах хөдөлгөөнийг хаасан. Замын хөдөлгөөний нөхцөл байдлын мэдээллийг хэвлэл мэдээллийн 13 телевиз, 20 сайтаар олон нийтэд түгээж ажилласан. Мөн албаны цахим хуудсанд Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн “Авто замын хөдөлгөөнийг түр хаах тухай” А/730 дугаартай захирамжийг байрлуулж 27416 хүнд, 3 удаагийн шууд дамжуулалтаар 83000 хүнд, Замын хөдөлгөөний удирдлагын хэлтсээс 2 удаагийн шууд дамжуулалтаар 71000 хүнд нийт 181416 хүнд замын нөхцөл байдлын талаар мэдээллийг хүргэж ажилласан.

Улаанбаатар Захирагчийн ажлын алба:

Хог тээвэр, зам талбайн цэвэрлэгээний 12 байгууллагын 364 албан хаагч 80 тусгай зориулалтын машин техниктэй Чингэлтэй дүүргийн гэр хороолол, зуслан бүс, Алтай хотхон, Сэлбэ гол зэрэг 4 байршилд ажиллав.

Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгээс 21 удаагийн рейс, Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгээс 86 удаагийн рейсийн шороо зөөх, буулгах ажлыг зохион байгуулан ажилласан.

Мөн Захирагчийн ажлын албанаас 15 албан хаагч ажиллаж үерийн

голомтод ажиллаж байгаа алба хаагчдад нэг бүрийн хамгаалах хэрэгсэл болох усны гутал 304 хос, борооны цув 300, шуудай 5000, бээлий 1000 ширхэгийг бэлтгээд байна. Үүнээс нийслэлийн Замын хөгжлийн газарт усны гутал 20 хос, борооны цув 20, Тээврийн цагдаагийн газрын Замын цагдаагийн газарт усны гутал 20 хос, борооны цув 20, нийслэлийн Онцгой байдлын газарт усны гутал 50 хос, борооны цув 50 ширхгийг тус тус тараасан.

Хэвлэл, мэдээлэл

Үер, усны нөхцөл байдалтай холбогдуулан байгуулагдсан УОК-ын Шуурхай штабын хэвлэл мэдээллийн ажлын хэсэг нь 2023 оны 7 сарын 8-16-ны дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:

Цаг үеийн нөхцөл байдлын болон урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг бүхий 88 мэдээ, мэдээллийг бэлтгэн байгууллагын албан ёсны сайт болон "Онцгой байдлын ерөнхий газрын пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажилласан. Эдгээр мэдээлэл нь давхардсан тоогоор 9 267 181 хүнд хүрсэн байна.

- Мөн 28 видео мэдээлэл бэлтгэн 912.165 хүнд хүргэж,
- 11 удаагийн хэвлэлийн бага хурал,
- нөхцөл байдлын 8 удаагийн шууд дамжуулалтын албаны пэйжээр, дамжуулсан. Нийт 133,4 мянган хүн үзсэн байна.

Нийтдээ цаг үеийн нөхцөл байдлыг давхардсан тоогоор 65 хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу 28 телевиз, 3 сонин, 37 сайтаар байнга мэдээлж ажиллалаа.

Үерийн аюулаас сэрэмжлүүлэх, үерийн үед анхаарах зүйлс, эрүүл ахуйн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг агуулга бүхий сэрэмжлүүлэг, зөвлөмжийн 35 постер бэлтгэж, мөн ЭМЯ, НЭМҮТ, ХӨСҮТ, ЗООНОЗ, НЭМГ-аас бэлтгэсэн 50 постер буюу нийт 85 постерыг "ОБЕГ-ын Урьдчилан сэргийлэх газар" пэйжээр дамжуулан 6 312.841 хүнд хүрсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын "Урьдчилан сэргийлэх хэлтэс"-тэй хамтран "Үерийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээ","Үерээс өмнө, үерийн үед, үерийн дараа", "Үер усны ослоос сэргийлэх","Цахилгаан хуваарилах байгууламжийн ойролцоо ус тогтсон газарт ойртохгүй байхыг анхааруулж байна" зэрэг 7 постерыг цахим орчинд түгээсэн. Дээрх олон нийтийн цахим сүлжээнд байршуулсан 7 мэдээлэл нь 7746 хүнд таалагдаж, 900 хүн сэтгэгдэл үлдээж, 56589 хүн бусадтай хуваалцаж, давхардсан тоогоор 280.709 хүнд хүрсэн байна.

Хандив, тусламж

Үерийн нөхцөл байдал үссэнтэй холбогдуулан шуурхай хариу арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэн, төр, хувийн хэвшлийн аж ахуй

нэгж, байгууллагуудаас 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс 2023 оны 7 дугаар сарын 11-ны өдрийн хооронд дараах мөнгө болон бараа материалын хандив тусламжийг ирүүлсэн. Үүнд:

1. Нийт 170.1 сая төгрөгийн мөнгөн тусламж: Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20 төлөөлөгч нийт 5.0 сая төгрөг, нийслэлийн харьяа агентлагуудаас 20.9 сая төгрөг, Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК 0.6 сая төгрөг, Ачит ХХК 100.0 сая төгрөг, Төрийн тусгай хамгаалалт 2.0 сая төгрөг, Улаанбаатар хотын хөгжлийн корпорац, Эрдэнэс Баян Богд ХХК 0.5 сая төгрөг, Зүүн азийн спорт наадам ХК 0.4 сая төгрөг, Ариг банк 10.0 сая төгрөг, Хүдэр-Эрдэнэ ХХК 5.0 сая төгрөг, Иргэн Д.Батмөнх 5.0 сая төгрөг, Экоконстракшн ХХК 10.0 сая төгрөг, Багахангай дүүргийн ИТХ 3.8 сая төгрөг, БНСУ-ын Элчин сайдын яам 2,000.0 доллар.

2. Нийт 112 сая 450 мянган төгрөгийн шатахууны талон:
- НҮБ 11,9 сая төгрөгийн,
- Шунхлай групп 100,0 сая төгрөгийн,
- Нийслэлийн Биеийн тамир спортын газар 500 мянган төгрөгийн талон.

3. Нийт 113,906 ширхэг бараа материал:

Нийслэлийн нутгийн захиргааны 37 байгууллага, Онцгой байдлын ерөнхий газар, Вест Бэйкэри, ББК ХХК, ЗГН ХХК, Юнител Групп, Монгол эм импекс ХХК, ЭНТО ХХК, Юнитра ХХК, Мобиком ХХК, Өгөөж чихэр боов ХХК, Түвшиг билэг төгөлдөр ХХК, АПУ ХХК, Тесо ХХК, Улаанбаатар хотын худалдааны танхим, Дэзэрэт олон улсын энэрлийн байгууллага, Монголын Улаан загалмай нийгэмлэг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, АОДЕ ХХК, Жүжигчин Учрал, Чинбат нарын 2 иргэн нийт 26 аж ахуйн нэгж байгууллагуудаас шуудай, нэг удаагийн бээлий, нойтон салфетка, ажлын бээлий, ус нэвтэрдэггүй комбинзон, нэг удаагийн маск, усны гутал, Монгол эм импекс ХХК, ЭНТО ХХК-ууд витамин, дархлаа дэмжих бэлдмэл зэрэг болно.

4. Нийт 100 хонь, 28,000 ширхэг ундаа ус, хоол хүнсний тусламж: Нийслэлийн нутгийн захиргааны 35 байгууллага, Мэдээлэл технологийн үндэсний парк, Цогтбаатар гишүүний ажлын алба, лам нар, Бигүрү ХХК, Сео ХХК, Вест Бэйкэри ХХК, Жи энд Жи Интернэшнл ХХК, Дижитал Концеппи ХХК, Вояж ХХК, Номин фүүдс ХХК, Тэгш чанар ХХК, Хархорин хүрээ ХХК, иргэн Пүрэв-Очир, Дэмчигсүрэн, Мөнхцэцэг болон Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат болон нутгийн малчин иргэдээс 100 хонь, нийт 28,000 ширхэг ундаа ус, хоол хүнсний тусламжийг тус тус үзүүлсэн байна.

Дээрх хандив тусламжаас үерийн голомтод үүрэг гүйцэтгэсэн нийт албан хаагчдад дараах байдлаар зарцуулсан бөгөөд 164,323,775 төгрөг бүхий бэлэн мөнгө, 32,800,000 төгрөгийн шатахууны талон, 52,250 бараа материал, 1,110 ширхэг хоол хүнс тус тус үлдсэн байна.

Хүснэгт 6. 2023 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 16 цагийн байдлаарх

№	Хандив тусламжаар ирсэн зүйлс	Хэмжих нэгж	Нийт ирсэн	Зарлага	Үлдэгдэл
1	Бараа материал	Ширхэг	113,906	61,656	52,250
2	Шатахууны талон	Ширхэг	112,450,000	79,650,000	32,800,000
3	Бэлэн мөнгө	Төгрөг	170,079,320	5,755,545	164,323,775
4	Хоол хүнс	Ширхэг	28,000	26,890	1,110

Сэлбэ голын хориглолтын бүсийн газар ашиглалт

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны "Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай" 50 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Сэлбэ голын хориглолтын /50 метрийн/ бүсэд нийт **1725 нэгж** талбар өртсөн байна. Үүнд:

Хүснэгт 7. Эдэлбэрийн хэлбэрээр ангилсан байдал:

№	Дүүрэг	Эдэлбэрийн хэлбэр			
		Өмчилсөн	Эзэмших	Ашиглах	Нийт
1	Баянгол		53	7	60
2	Баянзүрх	128	64	7	199
3	Сүхбаатар	152	616	3	771
4	Хан-Уул	1	66	6	73
5	Чингэлтэй	77	545		622
	Нийт	358	1344	23	1725

Хүснэгт 8. Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжийн төрлөөр ангилсан байдал:

№	Дүүрэг	Захирамжийн төрөл		Нийт
		Нийслэлийн Засаг даргын	Дүүргийн Засаг даргын	
1	Баянгол	40	20	60
2	Баянзүрх	44	155	199
3	Сүхбаатар	67	704	771
4	Хан-Уул	67	6	73
5	Чингэлтэй	16	606	622
Нийт		234	1491	1725

/Тухайн судалгааг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй нэгж талбарт үндэслэн гаргав./

Сэлбэ голын үерийн хамгаалалтын **30 метр** радиус доторх төлөвлөгдсөн (Архитектор, төлөвлөлтийн даалгавар батлагдсан) **42 барилга** болон одоо байгаа **170 барилга** байгууламж байна.

Хүснэгт 9. Сэлбэ голын үерийн хамгаалалтын 30 метр радиус доторх баригдсан барилга, байгууламж

Барилгын зориулалт	Баригдсан барилгын тоо
Орон сууц	74
Үйлчилгээ	24
Албан контор	8
Инженерийн дэд бүтцийн байгууламж	5
Үйлдвэрлэл	3
Их дээд сургууль	1
Амины сууц	12
Бусад	43
Нийт	170

Зураг 113. Үерийн нөхцөл байдал, хэрэгжүүлсэн арга хэмжээний зураг





POLICE

FIRE



5.1.2 НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТОД ТОХИОЛДСОН ҮЕРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, /2023 оны 8 дугаар сар/

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГТ ҮҮССЭН ҮЕРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

Нэг. Цаг агаарын нөхцөл байдал

Цаг уурын байгууллагын өртөө харуулын ажиглалтын мэдээгээр 2023 оны 8 дугаар сарын 5-ны 8:00 цагаас 20:00 цаг хүртэлх баруун аймгуудын нутгийн хойд, төвийн аймгуудын ихэнх нутаг, говь болон зүүн аймгуудын нутгийн зарим газраар бороо, аадар бороо 0.0-25.0 мм орж, үүнээс хамгийн их нь Булган аймгийн Бугат, Төв аймгийн Баянцагаан, Эрдэнэ, Сэлэнгийн Зүүнбүрэн, Дарханы Шарын голд 21.0-25.0 мм, Хэнтийн Биндэр, Хэрлэнбаянд 17.0-18.0 мм тунадас орсон байна.

Улаанбаатар хот орчимд 2023 оны 8 сарын 05-ны 8:00 цагаас 20:00 цагийн хооронд 0.0-5.0 мм бороо, аадар бороо орж, үүнээс хамгийн их нь Сүхбаатар дүүргийн Хуурай мухарт 5.0 мм, Хан Уул дүүргийн Өлзийт, Буянт-Ухаа нисэх онгоцны буудал орчимд 3.0 мм орсон байна.

Сүхбаатар аймгийн Асгат 41 мм, Хэнтийн Норивлон, Батноров 22 мм, Төв аймаг Батсүмбэр, Хэнтийн Батширээтэд 16-17 мм бороо орсон. Улаанбаатар хотод 6-ы өдөр 1-12 мм бороо орсон. 6-7 нд шилжих шөнө бороо ороогүй.

Улаанбаатар хот орчмын голуудын усны түвшин өмнөх өдрийн мөн үеийнхтэй харьцуулахад Тэрэлж гол, Тэрэлж амралт орчимд усны түвшин 29 см, Туул гол Улаанбаатар орчимд 3 см, Алтанбулаг сум орчимд 47 см тус тус нэмэгдсэн хэдий ч үерийн түвшинд хүрээгүй. Харин Сэлбэ гол Санзай, Дамбадаржаа орчимд үерийн түвшинг давсан байдалтай байна.

2023 оны 8 дугаар сарын 08-ны 08:00 цагийн ажиглалтын мэдээг өмнөх өдрийн мөн үеийнхтэй харьцуулахад Туул гол Улаанбаатар орчимд усны түвшин 33 см нэмэгдэж Улаанбаатар хот, Лүн сум орчмоор, Сэлбэ гол Санзай, Дамбадаржаа орчмоор үерийн түвшинг давсан байдалтай байна.

Хүснэгт 9. Нийслэл Улаанбаатар хотод тохиолдсон үерийн нөхцөл байдал

Гамшгийн төрөл	Шалгуур үзүүлэлт							
	Аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал		Хор уршгийн нөхцөл байдал					
	Аюулын эрчимжилт, хор хөнөөлийн түвшин	Үргэлжлэх хугацаа	Нэрвэгдсэн хүний тоо	Нас барсан хүний тоо	Нийт мал, амьтны хорогдол /тус бүр хувиар/	Нийт мал, амьтны өвчлөл /тус бүр хувиар/	Хамрах хүрээ	Учирсан бодит хохирлын орон нутгийн төсөвт эзлэх хувь
Үер /эдгээр шалгуурыг хангасан бол үерийн гамшиг гэж үзнэ/	- Гол, мөрний ус үерийн түвшинд хүрэх, - Хүчтэй аадар борооны ус гуу жалга, хэвгий даган шавар, шороо, чулуутай холилдож хүйлран урсах	Хугацаа хамаарахгүй	10 ба түүнээс дээш	2 ба түүнээс дээш			10-15 айл өрх, 3-5 хүртэл ААН, 1-3 хүртэл дэд бүтцийн байгууламж	2.0
2023.08.05-ний СБД, БЗД-т үүссэн үер	БЗД-ийн Дарь-Эхийн 21, 27, 29 дүгээр хорооны Жамсран уулын Баруун талын амын гуу, жалгаар уруйн үер бууcан.	8 дугаар сарын 05-08 дугаар сарын 7-ний өдрийг хүртэл	1.856 мянган хүн	4	-	-	БЗД: 21, 27, 29 дүгээр хорооны 356 айл өрх, 25 ААН, 105 авто машин, 38.3 га газар,	
Гамшгийн шалгуурыг давсан эсэх	Тийм	Тийм	Тийм	Тийм	-	-	Тийм	

Хоёр. Үүссэн нөхцөл байдал, хэрэгжүүлсэн арга хэмжээ

Нийслэлийн хэмжээнд 2023 оны 8 дугаар сарын 05-ны өдөр үерийн 63 удаагийн дуудлага бүртгэгдсэн ба үүнээс Баянзүрх дүүрэгт 54 /10, 11, 17, 21, 22, 23, 27, 28, 29, 32 дугаар хороо/, Сүхбаатар дүүрэгт 9 /1, 15, 16, 20 дугаар хороо/ дуудлага ирсэн.

Баянзүрх дүүргийн 21, 27, 29 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн 38.3 га буюу 383,000 мкв талбайд “Жамсран уулын баруун талын аманд” уруйн үер бууж 4 хүн /үүнээс 1 хүүхэд/ нас барсан, 356 айл өрх, 25 аж ахуйн нэгж байгууллага, 105 автомашин өртсөн.



Зураг 114. Баянзүрх дүүргийн 21, 27, 29 дүгээр хорооны үерийн зураг



Шуурхай арга хэмжээ авсан талаар:

Үерийн улмаас үүссэн лаг шавар, хогийг цэвэрлэх ажилд Онцгой байдлын байгууллага, Зэвсэгт хүчин, Дотоодын цэрэг, Цагдаагийн байгууллага болон,

нийслэл, дүүргийн Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн нийт 23 байгууллага давхардсан тоогоор 2,888 алба хаагч, 413 тээврийн хэрэгсэл, техникээр 375 айл өрх, 15 аж ахуйн нэгжийн хашааг цэвэрлэж, 10,054 тн лаг шаварыг 410 удаагийн тээвэрлэлтээр зөөж, айл өрхийн хашаа ба нийтийн эзэмшлийн нийт 440,320 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийж, далан хөвөөний засвар дүүргэлтэд 332 удаагийн тээвэрлэлтээр 6,191 метр куб дайргыг ачиж зөөж ажилласан.

Тус дүүргийн 27, 29 дүгээр хорооны 6926 хэрэглэгчийг болзошгүй эрсдэлээс сэргийлж цахилгаан эрчим хүчийг хязгаарлаж, үүнээс 6926 буюу 100 хувь хэрэглэгчийн цахилгааныг сэргээсэн.

Түр орон байраар хангасан талаар:

Үерт өртсөн 1310 иргэнээс (хүүхэд-577, том хүн-709, хөгжлийн бэрхшээлтэй-24) байна. Мөн түр хорогдох байрыг 127 дугаар сургуулийн урлаг зааланд дэлгэж 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс 08 дугаар сарын 08-ны өдөр хүртэл том хүн 27, хүүхэд 20, хөгжлийн бэрхшээлтэй 2, нийт 49 иргэнийг байрлуулсан.

Хэвлэл мэдээлэл

ОБЕГ, ЭМЯ, Ус цаг уурын байгууллага зэрэг оролцогч талуудын хэвлэл мэдээллийн хэрэгслээр Ард иргэдэд үерийн үед анхаарах сэрэмжлүүлэг мэдээллийг нийслэл, 21 аймагт хүргэж ажиллав. Тухайлбал:

- Нийтдээ цаг үеийн нөхцөл байдлыг 73 хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу 19 телевиз, 2 сонин, 62 сайтаар тухай бүр давхардсан тоогоор 2,4 сая хүнд хүргэсэн.

- Орчны эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, болзошгүй осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр 20 сэрэмжлүүлэг мэдээллийг ЭМЯ болон Харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон 21 аймгийн Эрүүл мэндийн газрын веб хуудас болон facebook хуудсаар дамжуулан түгээх арга хэмжээг авсан.

Хандив, тусламж

- Монгол Цэргийн нэгдсэн холбооноос үерийн хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд маск 1000ш, бээлий 1000ш, цэвэр ус 1000ш хандивласан. Иргэд, ААН-ээс 17 гэр хандивласан.

УОК, НОК-т нийт 8 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 11 нэр төрлийн 21.468 ширхэг бараа, материалыг хандив, тусламжаар ирүүлсэн.

Үерийн улмаас үүссэн хог, лаг шаврыг цэвэрлэх, хогийн цэгт тээвэрлэн хүргэх ажилд ачааны Хово өөрөө буулгагч автомашин Зэвсэгт хүчнээс 10, Нийслэлийн Цагдаагийн удирдах газраас 6-г татаж нэмэлтээр ажиллуулсан.

БҮЛЭГ 5.2. СТРАТЕГИЙН КОМАНД ШТАБЫН СУРГУУЛЬ

Монгол Улсын Шадар сайдын "Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах тухай" 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр баталсан 06 дугаар тушаалын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын Ажлын алба, Онцгой байдлын Ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран 2023 оны 06 дугаар сарын 07-09-ны өдрүүдэд "Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Онцгой комисс, нэгдсэн шуурхай штаб, нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, яам, агентлаг, төрийн байгууллагуудын харилцан ажиллагааг жигдрүүлэх, улсын гамшигтай тэмцэх болон төрийн цэргийн байгууллагын чиглэлийн төлөвлөгөөг тодотгох, нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг дээшлүүлэх" зорилгын хүрээнд "Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож "**Онц байдал**" тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа" сэдэвтэйгээр стратегийн команд штабын сургуулийг зохион байгууллаа.

5.2.1. Удирдлагын баримт бичиг боловсруулалт

Сургуулийн хүрээнд дараах удирдлагын баримт бичгүүдийг боловсруулан батлуулж, мөрдөж ажилласан. Үүнд:

- Монгол Улсын Шадар сайд, ҮАБЗ-ийн Нарийн бичгийн даргын хамтарсан "Стратегийн команд штабын сургуулийн бодлого төлөвлөгөө"-г 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, "Стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл ажлын ерөнхий төлөвлөгөө"-г 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр, "Стратегийн команд штабын сургуулийн зохион байгуулалтын заавар"-ийг 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдөр,
- Монгол Улсын Шадар сайдын "Стратегийн команд штабын сургуулийн зохион байгуулах тухай" 06 дугаар тушаалыг 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр,
- Монгол Улсын Шадар сайдын "Стратегийн команд штабын сургуулилалтад оролцогчдыг томилох тухай" 35 дугаар тушаалыг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр,
- Онцгой байдлын ерөнхий газрын даргын "Стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл хангах ажлын хэсэг томилох тухай" А/61 дугаар тушаалыг 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр,
- Нийслэлийн Засаг даргын "Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах тухай" А/194 дүгээр захирамжийг 2023-оны 03 дугаар сарын 10-ны өдөр,

- Нийслэлийн Засаг даргын "Гамшгаас хамгаалах сургалт, дадлага зохион байгуулах тухай" А/232 дугаар захирамжийг 2023 оны 03 сарын 15-ны өдөр тус тус батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан.

Дадлага сургууль зохион байгуулахтай холбоотойгоор "Тактикийн даалгавар", "Ерөнхий болон нарийвчилсан цагийн байдал", "Ажиллагааны дараалал", "Аврах ажиллагааны бодлого болон үзүүлэх сургуулийг зохион байгуулах удирдамж", "Мэргэжлийн ангийн тактикийн үзүүлэх сургуулийн бодлого", "Онцгой байдлын ажиллагааны удирдлагын төвийн бүтэц", "Стратегийн команд штабын сургуулийн холболт зохион байгуулах түр заавар", "Холбоо зохион байгуулах заавар", УИХ-ын Онц байдлыг цуцлах тухай тогтоол, Засгийн газрын "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг"-т шилжих тухай тогтоолын төсөл зэргийг тус тус боловсруулсан.

5.2.2 Бэлтгэл ажил

Монгол Улсын Шадар сайд, ҮАБЗ-ийн Нарийн бичгийн дарга нарын хамтран 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр баталсан "Стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл ажлын ерөнхий төлөвлөгөө" (8 чиглэл 87 арга хэмжээ)-ний хэрэгжилт 99 хувьтайгаар, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/194 дүгээр захирамжаар баталсан "Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах тухай" сургуулийн бэлтгэл ажлын төлөвлөгөө (4 бүлэг 37 заалт)-ний хэрэгжилт 96,1 хувьтайгаар тус тус биелэгдсэн.

2.1. Сургуулийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд зохион байгуулсан уулзалт, хурал:

- Яам, агентлаг, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, аймаг, дүүрэг, хорооны Засаг дарга, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, Сууц өмчлөгчдийн холбоо, аж ахуйн нэгж байгууллага, ДЭМБ-ын суурин төлөөлөгч, Монгол Улсад суугаа Швейцарын хөгжлийн агентлагийн төлөөлөл, удирдлагуудтай 18 удаагийн уулзалт зохион байгуулсан бөгөөд, нийт 1580 гаруй албаны төлөөлөл хамрагдсан.

2.2. Сургуулийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд зохион байгуулсан сургалт, дадлага:

- "Ослын удирдлагын тогтолцоо", "Онцгой байдлын үеийн ажиллагааны удирдлагын төв" сэдвээр төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, гамшгаас хамгаалах улсын алба, Олон Улсын байгууллагуудын удирдах бүрэлдэхүүн, Нийслэл, дүүргийн Онцгой комиссын гишүүд болон нутгийн захиргааны байгууллагууд, нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, Монгол Улс

дахь НҮБ-ын суурин төлөөлөгчийн газрын төлөөлөл, Эрүүл мэндийн яамны удирдлага, албан хаагч, Цагдаагийн ерөнхий газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын удирдах бүрэлдэхүүн, Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын бүрэлдэхүүн нарт сургалт зохион байгуулсан.

Энэ хүрээнд удирдах бүрэлдэхүүний сургалтыг 20 удаа, "Ослын удирдлагын тогтолцоо" сургалтыг 8 удаа, Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг 2 удаа, Штабын дадлага, сургалтыг 7 удаа, Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалтыг 3 удаа, Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг 612 удаа, "Бэлэн бай" сургагч бэлтгэх сургалтыг 6 удаа тус тус зохион байгуулж, нийт 67,250 хүнийг хамруулсан.

Дадлага сургуулийн бэлтгэл хангах ажлын хүрээнд яам, агентлаг, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж зэрэгт 120 албан бичиг боловсруулан хүргүүлж, 120 гаруй албан бичигт хариу өгч ажилласан бөгөөд Монгол Улсын хэмжээнд ар тал хангалтын тоон мэдээллийг нэгтгэн боловсруулан ажилласан.

2.3.Тактикийн үзүүлэх дадлага, сургууль:

Дадлага сургуулийн бэлтгэл хангах ажлын хүрээд ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах 09 дүгээр анги хамтран нурангиас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага сургуулийг, нуранги болон автомашинаас нэрвэгдэгчийг татан гаргах ажиллагааны дадлагыг тус тус зохион байгуулан оролцсон.

Мэргэжлийн ангийн тактикийн урьдчилсан үзүүлэх сургуулийг Сүхбаатар, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэгт нэгээс хоёр удаа тус тус зохион байгуулсан бөгөөд нийт давхардсан тоогоор **1100** орчим хүн, **400** гаруй техник хэрэгсэл оролцсон.

2.4.Олон нийтэд чиглэсэн сурталчилгаа мэдээллийн бэлтгэл ажил:

"Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх нь" баримтат кино бүтээсэн, МҮОНТ-ийн "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлье" сэдвээр нэвтрүүлэг, "Нийгмийн хэлэлцүүлэг", "Газар хөдлөлт хөдөө аж ахуйд нөлөөлөх нөлөөлөл" сэдэвт судалгааны хэлэлцүүлэг, "Гамшгаас хамгаалах сургалтын өнөөгийн байдал, хүртээмж, үр нөлөө" сэдэвт онол, практикийн бага хурал зэрэгт оролцсон, Өдрийн сонинд "Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын суурийн суурь, үндсийн үндэс нь ард түмэн" нийтлэл, Онцгой мэдээ сонины 185, 187 дахь дугаарт "Стратегийн команд штабын сургууль" зохион байгуулах тухай нийтлэл, INSARAG-ийн гарын авлага буюу "Эрэн хайх, аврах олон улсын зөвлөлдөх бүлгийн удирдамж", ЕОС-ийн гарын авлага, "Стратегийн команд штабын сургууль"-ийн бодлогын баримт бичгийн эмхэтгэл зэрэг 3 төрлийн ном зэргийг бэлтгэсэн бөгөөд Жанжин Д.Сүхбаатарын талбайд БНТУ-д үүрэг

гүйцэтгэсэн Монгол Улсын эрэн хайх, аврах багийн үйл ажиллагааны талаарх "Гэрэл зургийн үзэсгэлэн" зохион байгуулсан.

Хэвлэлийн бага хурлыг 30 гаруй сайт, 50 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэсэн. Онцгой байдлын ерөнхий газар пейж хуудас болон nema.gov.mn сайтад нийт 38 удаагийн мэдээ, мэдээллийг бэлтгэн байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэсэн.

Онцгой байдлын ерөнхий газар "Оюу толгой" ХХК-тай хамтран газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх "Бэлэн бай" аяныг зохион байгуулж байна. Аяны хүрээнд нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 158 самбар, 21 аймгийн 100 орчим мэдээллийг самбарт газар хөдлөлтийн талаар мэдээлэл өгөх сурталчилгааны самбарыг байршуулсан.

Стратегийн команд штабын сургуулийн өмнөх болон дараах үеийн харьцуулсан судалгааны асуумжуудыг "төрийн байгууллага, аж ахуйн нэгж", "иргэдээс" гэсэн 2 ангиллаар авахаар олон улсын түвшинд харьцуулан шинжилж, өөрийн орны онцлогт тохируулан боловсруулж цахим хэлбэрт шилжүүлэн google forum https://forms.gle/kB7k22EddRgffHnb9 холбоосоор иргэд олон нийтээс авах судалгааг, https://forms.gle/KCu6SpDacjY8CYzh8 холбоосоор гамшгаас хамгаалах албадаас авах асуумжийг оруулж нийт 2606 асуумжийн судалгаа авч, тайланг нэгтгэсэн.

Онцгой байдлын ерөнхий газрын байрлалд нэгдсэн удирдлагын байрыг бэлтгэн төхөөрөмжилж төрийн нэгдсэн хамгаалалтын сүлжээнд холбож, компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж, лед дэлгэц, хөдөлгөөнт ухаалаг дэлгэцийг байрлуулан, радио холбооны тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглож команд штабын сургуулийг зохион байгуулсан.

ЗХЖШ ,ОБЕГ, ХХЕГ, ЦЕГ хөдөлгөөнт удирдлагын 4 байрыг дэлгэн төхөөрөмжилсөн бөгөөд сургуулийн харилцаа холбоо зохион батлуулж удирдлагаар хангаж ажилласан мөн сургуульд оролцох багуудыг байрлуулах, ажиллах боломжийг бүрдүүлэн 8 гэр, 4 асар байрлуулан бүрэн төхөөрөмжлөн сургуульд ашигласан.

5.2.3 Сургуулийн удирдлага зохион байгуулалт

Сургуульд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, гамшгаас хамгаалах улсын алба 12, яам, агентлаг, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, НҮБ-ын суурин зохицуулагчийн ажлын алба, 12 хүмүүнлэгийн тусламжийн сектор, дэлхийн зөн болон эрүүл мэндийн байгууллага, 21 аймаг, Нийслэлийн 9-н дүүргийн нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл зэрэг нийт **2900** гаруй хүнийг оролцуулан Стратегийн команд штабын сургуулийг Онцгой байдлын ерөнхий газрын байрлалд 3 өдөр буюу 72 цагийн

хугацаатайгаар зохион байгуулсан.

Сургуулийн үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу оролцсон бөгөөд дараах чиглэлээр үүрэг даалгавар өгсөн.

- Төр засаг ард иргэдийн хамтран нийслэлд дэх хүн амын төвлөрлийг бууруулах, аюулгүй амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх, барилгын чанарын асуудал анхаарал хандуулах,

- Барилгын стандартыг мөрдүүлэх, хяналтыг сайжруулах, барилгыг паспортжуулах, хүчитгэх, ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг зогсоох,

- Барилгын материалын чанарт тавих хяналтыг сайжруулах, тэр дундаа сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дулааны цахилгаан станцуудад нарийвчилсан үнэлгээ хийх,

- Төр, нийтийн хамтын хүчээр газар хөдлөлтийн гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавхыг сайжруулах, бэхжүүлэх, төрийн бүх шатны байгууллагуудын бэлэн байдлыг хангах, хамтын ажиллагааг сайжруулах,

- Улсын нөөцийн бүрдүүлэлт, нэр төрөл тоо хэмжээг газар хөдлөлтийн гамшиг болсон үед даван туулах боломжтойгоор шинэчлэн тогтоох, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох,

- Төрийн байгууллагуудын харилцан ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах, төлөвлөлтийг боловсронгуй болгох чиглэлийн сургалт дадлагыг байгууллагуудтай хамтран зохион байгуулах,

- Хэлбэр төдийн хөрөнгө мөнгө, цаг үрсэн сургалт дадлагаас зайлсхийх,

- Команд штабын сургалтаар бүх байгууллагууд боломж бололцоогоо бодитойгоор тодотгох,

- Төрийн цэргийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоогоо сайжруулах,

- Үндэсний эрх ашиг, нийт иргэдийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах тусгай хуультай байх шаардлага үүсэж байгаа тул анхаарах,

- Газар хөдлөлтийн гамшгийн үед бэлэн байдлаа хангах, төлөвлөлтөө боловсронгуй болгох, урьдчилсан сэргийлэх, ард иргэдээ сургаж дадлагажуулахад онцгойлон анхаарах талаар үүрэг чиглэл өгсөн.

Стратегийн команд штабын сургууль 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр “2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 06.00 цагт Хөвсгөл аймгийн Хатгал сумын төвөөс урд зүгт 60 км зайд 7.0 магнитутын хүчтэй газар хөдлөлт боллоо” гэх цагийн байдлын дагуу 05:30 цагт “Яаралтай цуглар дохио”-г сургуульд оролцогчдод хүргэснээр эхэлсэн.

Яаралтай цуглар дохиогоор 06:30 цагт бүрэн цугласан сургуульд оролцогчдын хээрийн үүргэвчийн бэлэн байдлыг шалгаж, цагийн байдал өгч, бүлэг, салбар, багууд тус тусын байрлалд бэлэн болсноор үргэлжилсэн.

3.1. Ажиллагааны багийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ: Ажиллагааны баг нийт 132 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.

Төлөвлөлтийн багийн хариу арга хэмжээг авах 12 ерөнхий төлөвлөгөө, газар хөдлөлтийн гамшигт өртсөн Хөвсгөл, Сэлэнгэ, Дархан-Уул, Булган, Орхон, Төв, Дундговь аймаг, төвийн 6 дүүрэгт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх 17 төлөвлөгөө, Гадаадын 43 улсаас ирсэн (Ази-9, Европ-28, Төв Ази-6, Булан болон Ойрх дорнод, Африк тивээс-9, Америк болон Хойд Америкийн бүс нутгаас-4, Ази, номхон далайн орнуудаас- 5) 60 эрэн хайх, аврах багийг Монгол Улсад хүлээн авах ажиллагааны төлөвлөгөө зэргийг хэрэгжүүлэн ажилласан.

Газар хөдлөлтийн гамшгийн улмаас үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг сургуулийн ажлын зураг, Гамшгийн орон зайн мэдээллийн системд тухай бүр оруулж дээр газар хөдлөлтийн цагийн байдлыг зураглаж ажилласан.

Эрэн хайх аврах салбар газар хөдлөлтийн гамшгийн улмаас 66873 иргэн гэмтэж, 195658 иргэн сураггүй болж, нурсан барилга 4038 , нас барсан 131125 иргэн,газар хөдлөлтийн гамшгийн улмаас 25651 иргэнийг аварч 1922 техник хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэсэн.

Газар хөдлөлтийн гамшигт өртөж орон байргүй болсон иргэдийг нүүлгэн шилжүүлэх, түр орон байраар хангах үйл ажиллагааг нийт 207 барилга байгууламжид 75 мянга гаруй иргэдийг байрлуулах, шаардлагатай нөөц хэрэгслээр хангах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан.

Нийслэлийн дүүрэгт түр орон байраар хангах зориулалт бүхий сургууль, цэцэрлэг, амралт, зочид буудал, спорт заал зэрэг нийт 439 байршилд 97147 иргэн мөн Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Өвөрхангай зэрэг 6 аймгийн нутагт нийт 174924 иргэнийг тус тус нүүлгэн шилжүүлж түр орон байраар хангах ажиллагааг зохион байгуулан ажилласан.

3.2. Төлөвлөлтийн багийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ: Төлөвлөлтийн баг нийт 45 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.

Гамшгийн хариу арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө 16, Баянзүрх дүүрэг 3, Баянгол дүүрэгт 3, Хан-Уул дүүрэг 3, Чингэлтэй 3, Сонгинохайрхан дүүрэгт 4, Сүхбаатар дүүрэг 2, Хөвсгөл аймагт 4, Дархан уул аймагт 3, Орхон аймаг 2, Булган аймагт 2, Төв аймаг 3, Сэлэнгэ аймагт 3, Дундговь аймагт 2, нийт 45 төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулан Ажиллагааны багт хүргүүлэн хэрэгжилтийг хангуулсан.

3.3. Ар тал хангалтын багийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ: Ар тал хангалтын баг улсын хэмжээний бараа бүтээгдэхүүний судалгаанд тулгуурлан ар тал хангалтыг зохион байгуулсан. Гамшгийн нөхцөл байдал үүссэн Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Төв, Дундговь аймгуудад шаардлагатай хүнч хүч, техник хэрэгсэл тоног төхөөрөмжийн тусламж үзүүлэх, зохицуулалтыг

хийх чиглэлээр Онцгой байдлын ажиллагааны удирдлагын төв ажилласан. Улсын хэмжээнд ар тал хангалттай холбоотой тоон мэдээлэл судалгааг авч, судалгаанд тулгуурлан ар тал хангалтыг гамшигт нэрвэгдсэн аймаг, дүүрэгт хуваарилан өгөх ажиллагааг тухай бүр зохион байгуулан ажилласан.

3.4. Санхүү захиргааны багийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ: Сургуульд Захиргаа, санхүүгийн багт ОБЕГ, УБЕГ, НЗДТГ, НОБГ, НУБГ, НАГ-ын 27 ажилтан, алба хаагч Баримт бичиг, албан бичиг, архив, нууц, төлбөр тооцоо болон санхүү, гэрээний бүлгүүдэд хуваарилагдан ажилласан.

3.5. Төрийн цэргийн байгууллага: Үүссэн нөхцөл байдалд Зэвсэгт хүчин, Хил хамгаалах, Тагнуулын байгууллагын хүн хүч техник хэрэгслийн дэмжлэг үзүүлэх төлөвлөлтийг зохион байгуулсан бөгөөд төлөвлөлтийн багийн төлөвлөгөөний дагуу шаардлагатай хүн хүч техник хэрэгслийг хуваарилан ажилласан.

3.6. Олон улсын байгууллага: Газар хөдлөлтийн гамшгийн үед Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хуваарилах, олон улсын тусламжийн арга хэмжээг зохион байгуулан ажиллана.

3.7. Олон нийттэй харилцах баг: Гамшгийн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг ард иргэдэд тухай бүр шуурхай түгээн ажилласан бөгөөд, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай ажиллах талаар заавар зөвлөгөө өгч ажилласан. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай харилцан ажиллагааг зохион байгуулж хамтран ажилласан.

Хэвлэл мэдээллийн хүрээнд нийт 44 мэдээлэл бэлтгэн түгээсэн. Үүнээс 5 нь хэвлэлийн хурал, 4 зөвлөмж мэдээлэл, 4 уриалга, 29 цаг үеийн мэдээ, 2 видео мэдээллийг бэлтгэн, сургуулийн удирдагчаар батлуулан, газар хөдлөлт болсон 7 аймгаас бусад 14 аймгийн нийт 30 гаруй хэвлэл мэдээллийн байгууллага /10 гаруй сайт, 20 гаруй телевиз/-аар түгээсэн.

Түүнчлэн youtube, twitter, facebook, instagram гэсэн флатформуудад 50 мянгаас дээш дагагчтай 10 гаруй нөлөө бүхий хүмүүс нийт 11 албаны мэдээллийг цааш нь түгээж, сэрэмжлүүлэг мэдээлэл, уриалга хүргэхэд хамтран ажиллалаа.

Хэвлэл мэдээллийн хэсгээс гарсан нийт 44 мэдээллийг “Монцамэ” агентлагаас орос, англи, япон, хятад хэлээр, ОХУ-ын “ИТАР-ТАСС”, Япон Улсын “Киодо”, БНХАУ-ын “Синьхуа”, Олон Улсын “Ройтерс”, “Ассошиэтэд пресс”, “Си Эн Эн” зэрэг мэдээллийн агентлагууд Монгол дахь сурвалжлагчаараа дамжуулан газар хөдлөлтийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг шуурхай дамжуулан хүргэж ажилласан.

3.8. Холбогчид: Ажиллагаа, төлөвлөлт, санхүү/захиргаа, ар тал хангалтын багуудад Онцгой байдлын ажиллагааны удирдлагын төвийн даргатай холбох, мэдээлэл, үүрэг дамжуулах, хариу арга хэмжээнд оролцогч байгууллагуудтай холбоо тогтоож, ажилласан. Ослын удирдагчийн өгсөн үүргийн дагуу оролцогч талуудыг мэдээллээр хангаж ажилласан.

3.9. Аюулгүй байдлын ажилтнуудын чиг үүрэг: Онцгой байдлын ажиллагааны төвд ажиллаж байгаа байгууллагуудын төлөөллийн аюулгүй байдлыг хангаж ажилласан бөгөөд түр амрах, хооллох үед төвийн аюулгүй байдлыг ханган ажилласан. Мөн гадагш, дотогш нэвтрэх хөдөлгөөнд хяналт тавьж, галын аюулгүй байдал, хулгай зэргээс сэрэмжлэн ажилласан. Голомтын бүсийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангах үүднээс ажиллагааны хэсэгтэй хамтран ажиллаж заавар, зөвлөмж тухай бүр өгч ажилласан.

Ард иргэд зарлан мэдээллийн дохиогоор түр нүүн шилжих ажиллагаа:

Стратегийн команд штабын сургуулийн үед Нийслэл Улаанбаатар хот, аймгуудад газар хөдлөлтийн аюулын үед аюулгүй байршилд шилжин байрлах дадлагыг зохион байгуулсан бөгөөд зохион байгуулах арга хэмжээнд 1200 орчим ажилтан, алба хаагчид заавар зөвлөгөө өгч ажилласан.

Дадлагыг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 16:00 цагт улс орон даяр газар хөдлөлтийн гамшгийг амжиж анхааруулах систем дуугарч ард иргэд аюулгүй талбайд гарах дадлагыг зохион байгуулсан бөгөөд нийт 470 гаруй мянган иргэн аюулгүйн түр талбайд цуглаж газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээлэл сонссон.

5.2.4 Дүгнэлт

Энэ удаагийн команд-штабын сургуулийн гол үр дүн Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Онцгой комисс, нэгдсэн шуурхай штаб, нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, яам, агентлаг, төрийн байгууллагуудын харилцан ажиллагаа жигдэрсэн, төрийн цэргийн байгууллагын чиглэлийн төлөвлөгөөг тодотгосон бөгөөд нэгдсэн удирдлагын тогтолцоогоор ажиллах арга барилыг эзэмшсэн явдал юм.

Тиймээс гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн уялдаа холбоог хангах, хүн хүч хэрэгсэл, нөөц хангалтыг хуваарилах, дайчлах, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг цогц байдлаар хэрэгжүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах, нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх ослын удирдлага, онцгой байдлын ажиллагааны удирдлагын төвийн бүтцийг нэвтрүүлэх, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

Мөн стратегийн команд штабын сургуулиар бүх шатны газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгож, харилцан ажиллах нөхцөлийг тодорхойлсон бөгөөд Монгол Улсын Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, бүх шатны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, боловсронгуй болгох шаардлагатай байгаа нь харагдсан.

Томоохон хэмжээний газар хөдлөлтийн гамшиг болсон үед тогтвортой, тасралтгүй удирдлагыг хэрэгжүүлэх, байгууллага хоорондын харилцан ажиллагааг хангах чиг үүрэг бүхий "Нэгдсэн удирдлагын төв"-ийг байгуулах шаардлагатай байгаа нь мөн сургуулийн явцад харагдсан.

Сургуулийн үед дуурайлган үзүүлэх дадлага сургуулийг төвийн зургаан дүүрэгт зохион байгуулсан бөгөөд дүүргийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн гамшгийн үед ажиллах ур чадвар дээшилж, мэргэжлийн байгууллагуудын харилцан ажиллагаа жигдэрсэн.

Дадлага сургуулийн үед иргэд аюулгүйн талбайд гарч идэвхтэй оролцсон нь иргэдийн оролцоо нэмэгдсэнийг харуулсан бөгөөд иргэд болзошгүй газар хөдлөлтийн гамшгийн үед өөрийн гарах аюулгүйн талбайг мэдэж авсан.

Монгол Улсад тохиолдсон газар хөдлөлтийн гамшгийн улмаас учирсан хор уршгийг арилгах, эрэн хайх, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор гадаадын улс орнуудаас мөнгөн болон эд материалын хандив тусламжийг хүсэх дадлагыг бодит мэдээлэл дээр тулгуурлан зохион байгуулсан. Тухайлбал: Монгол Улсад газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон хүндхэн нөхцөлд БНЭУ, БНИУ, Сингапур, АНУ, Израйл, Саудын Арабын Хант Улс, АНЭУ, Кувейт, Катар, Өмнөд Африк зэрэг 10 орноос 90 сая ам.долларын тусламж үзүүлэхэд бэлэн, БНСУ, БНТУ, ИБУИНХУ, Испанийн хант улсуудаас 28 нэр төрлийн гамшгийн үед нэн шаардлагатай бараа материалын тусламж үзүүлэхээ тус тус бодитойгоор илэрхийлсэн.

5.2.5 Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал.

Стратегийн команд штабын дадлага сургуулийн явц, үр дүнг үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх саналтай байна. Үүнд:

- Сургуулийн арга хэмжээнд оролцож үүрэг чиглэл өгсөн Монгол Улсын ерөнхийлөгчийн үүргийг Засгийн газар, яам, агентлагуудад хүргүүлэх, биелэлтийг хангуулах, төлөвлөгөө боловсруулан ажиллах;
- Томоохон хэмжээний газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед шуурхай, тогтвортой, тасралтгүй удирдлагыг хэрэгжүүлэх, байгууллага хоорондын харилцан ажиллагааг хангах чиг үүрэг бүхий Нэгдсэн удирдлагын төвийг байгуулах;
- Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолоор батлагдсан гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор

уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний Монгол Улсын төлөвлөгөө”-г болон бусад бүх шатны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах;

- Ослын удирдлага, онцгой байдлын ажиллагааны удирдлагын төвийн бүтцийг нэвтрүүлэх, олон улсын хүмүүнлэгийн байгууллага, төрийн цэргийн байгууллагын чиг үүргийг тодорхой тусгах, уялдаа холбоог хангах, эрх зүйн орчныг бүрдүүлэх;

- Аймаг, сум, дүүрэг, нийслэл гамшгаас хамгаалах Улсын болон орон нутгийн алба, төрийн болон нутгийн захиргааны байгууллага нь гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, төлөвлөлт боловсруулах, хэрэгжүүлэх, хүн хүч хэрэгслийг дайчлан гаргах зэрэг ажиллагааг зохион байгуулахад шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусгах, хэрэгжилтийг хангах;

- Газар хөдлөлтийн гамшгийн үед гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, онц байдал тогтоох зэрэг ажиллагааны зааг хүрээг оновчтой тогтоох, удирдамжийн баримт бичгийг боловсруулах;

- Гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба, мэргэжлийн анги, хуулийн этгээд бусад байгууллагын газар хөдлөлтийн гамшгийн үеийн бэлтгэл, бэлэн байдалд дүн шинжилгээ хийх, байгууллагуудын харилцан ажиллагааг сайжруулах;

- Гамшгийн зарлан мэдээллийн системийг өргөтгөн сайжруулж улсын хэмжээнд нэгдсэн систем байгуулах;

- Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын улмаас онц байдал тогтоосон үед ажиллах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын онцгой комиссын харилцан ажиллагааны удирдлага төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах;

- Газар хөдлөлтийн гамшгийн хор уршгийг арилгах бүх төрлийн нөөц, тээвэр, ложистик харьцангуй сул манай улсын хувьд НҮБ-ийн дэмжлэгтэйгээр Төв болон Зүүн хойд Азийн бүс нутгийн гамшгийн үеийн хүмүүнлэгийн тусламжийн төвийг Монгол Улсад байгуулах;

- Онцгой байдлын байгууллагын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Эрэн хайх, аврах нэгжүүдийг MNS 6740:2018 стандартад заасны дагуу техник хэрэгсэл, хүний нөөцөөр хангах, Эрэн хайх, аврах нэгж, Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжийн тоог нэмэгдүүлэх;

- Онцгой байдлын байгууллагын аврагчдыг газар хөдлөлтийн чиглэлээр гадаад улс орнуудад туршлага судлуулах, хамтарсан дадлага сургалтад хамрагдах алба хаагчдын тоо, давтамжийг нэмэгдүүлэх зэрэг саналтай байгааг илтгэн танилцуулж байна.

5.2.6 Стратегийн команд штабын сургуулийн зургийн сан.
2023 оны 06 дугаар сарын 07-09-ний өдөр

Хээрийн үүргэвчний бэлэн байдал үзэх ажиллагаа.

Өгөгдсөн цагийн байдлын дагуу ажиллах ажиллагаа:

Монгол Улсын Ерөнхийлөгч сургуулийн үйл ажиллагаатай танилцах ажиллагаа

Цагийн байдлын дагуу сургуулийн удирдагчаас үүрэг өгөх ажиллагаа

Хөдөлгөөнт удирдлагын байр

Бүлгүүдийн ажиллагаа

Салбаруудын ажиллагаа

Түр цугларах талбайд гарах ажиллагаа

Нэгдсэн зураг авахуулах ажиллагаа

БҮЛЭГ 5.3. БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН ХАТАЙ ХОТ ДАХЬ ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГАА

5.3.1 Үүссэн нөхцөл байдал

2023 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 04:17 цагт Бүгд Найрамдах Турк, Сири улсын хил залгаа орчимд 7,8 магнитутын хүчтэй газар хөдлөлт болсон. Газар хөдлөлт 7 километрийн (4.3 миль) гүнд Газиантеп мужийн зүүн өмнөд хэсэгт 6.4 магнитуд, гурав дахь удаагаа 6.5 магнитудын хүчтэй газар хөдөлсөн. Газар хөдлөлт нь Анатоли, Арабын болон Африкийн тектоник хавтангийн уулзварт, голомт нь Бүгд Найрамдах Турк улсын Газиантеп хот орчимд байсан. Газар хөдлөлт Кахраманмараш, Газиантеп, Шанлыурфа, Диярбакыр, Адана, Адьяман, Османие, Хатай, Килис, Малатья, Элазиг гэсэн 11 хотыг хамарсан.

2023.02.07-нд Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Бүгд Найрамдах Турк улсад эд материалын тусламж болон аврах ажиллагаанд оролцох 35 хүнтэй Аврах баг илгээх шийдвэр гарсан. 2023 оны 2 дугаар сарын 08-ны өдөр Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, бригадын генерал Б.Ууганбаяраар ахлуулсан Онцгой байдлын байгууллагын 24 (эрэлч нохой 2), Зэвсэгт хүчний 11, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, нийт 41 хүний бүрэлдэхүүнтэй баг тусгай үүргийн нислэгээр Бүгд Найрамдах Турк улсыг зорьсон.

Монгол Улсын Эрэн хайх, аврах ажиллагааны баг газар хөдлөлт болсноос хойш 68 цагийн дараа Турк улсын Хатай хотод очсон. Хатай хотын олон мянган иргэд амь насаа алдаж, зам, гүүр, цахилгааны шугам сүлжээ эвдэрч, барилга байгууламжийн 90 хувь нь нурсан байв. Туркийн SAKOM (Гамшгийн эрүүл

мэнд, зохицуулалтын төв алба)-ын 3 дугаар сарын 18-ны өдрийн мэдээгээр нийт 50096 иргэн амь насаа алдаж, энэ хугацаанд нүүлгэн шилжүүлсэн болон өөрийн хувийн техник хэрэгслээр шилжин нүүсэн 1.971.589 иргэн байжээ. Хатай хотод өдөртөө 3-12 хэмийн дулаан. Шөнөдөө 2 хэм дулаанаас -6 хэм хүйтэн, салхины хурд 5-10 м/с байсан.

5.3.2. Эрэн хайх аврах бүлэг, Эмнэлгийн бүлгийн үүрэг

Эрэн хайх, аврах баг 2 бүлэг, 2 эрэлч нохойтойгоор барилгын нурангид эрэн хайх, аврах ажиллагаа зохион байгуулсан. Гамшиг, Онцгой байдлын байгууллага /AFAD/-д бүртгүүлж, эрэн хайх, аврах ажиллагаа зохион байгуулах чиглэлийг авснаар Хатай хотын аврах багтай хамтран нурангаас 3 иргэнийг /том хүн 1, хүүхэд 2/ эсэн мэнд гаргаж, эмнэлгийн анхны тусламж үзүүлж дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад хүлээлгэн өгсөн. Эрэн хайх, аврах багийн бүрэлдэхүүн нийт 16 цаг ажиллаж, нурангиас 5 иргэнийг эсэн мэнд гаргаж, 12 цогцсыг /буцалтгүй нэрвэгдэгч, том хүн 9, хүүхэд 3/ холбогдох байгууллагад хүлээлгэж өгсөн.

Эрэн хайх, аврах бүлэг 2 дугаар сарын 10-ны өдөр 5 обьектод эрэн хайх ажиллагаа зохион байгуулж, нурангаас 3 иргэний цогцсыг гаргасан. Хатай хотод өдөр бүр 2-3 удаагийн давтамжтай газар хөдлөлтийн чичирхийлэл болж байсан бөгөөд 2 дугаар сарын 11-ний өдөр эрэн хайх, аврах бүлэг 3 иргэний цогцсыг гаргаж, холбогдох байгууллагад хүлээлгэж өгсөн. Тухайн үед гамшгийн голомтод 4.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт болсон тул ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргаж байжээ. 2 дугаар сарын 12-ны өдөр бүрэн нурсан орон сууцны барилгаас 1 иргэний цогцсыг гаргаж, 20.000 доллар болон үнэт эдлэлийг ар гэрийнхэн болон цагдаагийн байгууллагад хүлээлгэж өгсөн.

Монголын ард түмнээс илгээсэн хүмүүнлэгийн тусламжийн барааг Аврах багийн 8 алба хаагч, 2 автомашинтайгаар Адана хот дахь НАТО-гийн агаарын цэргийн баазаас хүлээн авч, 2 дугаар сарын 14-ний өдөр Хатай хотод татан авчирсан.

2 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхэд Бүгд Найрамдах Турк улсад Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулсан ажлын үр дүнг Ажиллагааны багийн ахлагч танилцуулсан.

Эмнэлгийн бүлэг

Эмнэлгийн бүлэг хотын төвд байрлаж байнгын ажиллагаатай нарийн мэргэжлийн мэргэшсэн эмч нарын тусламж үйлчилгээ үзүүлж эхэлснээр иргэдэд эмнэлгийн тусламж авах боломжийг нэмэгдүүлсэн. Мөн нурангид дарагдсан иргэд эмнэлгийн тусламж шууд авч чадаагүйгээс цэргийн хээрийн эмнэлгээр үйлчлүүлж буй эмчлүүлэгчийн дийлэнх хувь нь биеийн олон хэсгийн

бохирдсон шархтай, түлэгдэл, хуйхны язрал, хугарал, мултралууд ихээр ирж байсан. Гэмтэл мэс заслын өвчлөл болох мөчдийн хугарал, зулгарал, гэмтлийн шалтгаант арьсан дор их хэмжээтэй цус хурах, толгойн язарсан шарх, мөчдийн зүсэгдсэн шархнууд, биед зоогдсон олон тооны шилний шархнууд, түлэнхийн шарх зэрэг нурангид дарагдах үед үүссэн гэмтлийн шархтай эмчлүүлэгч нар ихэнх хувийг эзэлж байсан.

Нийт 649 үйлчлүүлэгчид анхан болон лавшруулсан шатны тусламж үзүүлсэн бөгөөд нийт өвчлөлийг хувиар авч үзвэл хамгийн өндөр буюу гэмтэл согог, мэс заслын эмгэг 68,5 хувь, үүнээс хүүхэд 72 буюу /10,9 хувь/, тус тус эзэлж байв. Үүнээс дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлж лаборатори болон багажийн шинжилгээ хийлгэх шаардлагатай 4,8 хувь өвчтөнг илгээсэн. Мөн дотрын өвчлөлийн шалтгаант үйлчлүүлэгч 20 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд сэтгэлзүйн цочролд орсон, сэтгэлзүй тогтворгүй байгаа иргэдэд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэн ажилласан бөгөөд аминд аюултай хэм алдагдал, чихрийн шижингийн хүндрэлийн шалтгаант хөлний идээт үрэвслийн улмаас үүссэн үжил, хүүхдийн уналт таталт зэрэг хүнд өвчтөнүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Түүнчлэн халдварт өвчин бүртгэгдэх тохиолдол гарч байсан бөгөөд уг өвчлөлүүд нь орчны, хөрс, усны бохирдолттой холбоотойгоор үүсэж цаашид нэмэгдэх хандлагатай байсан.

Хүмүүнлэгийн тусламж

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар гамшигт нэрвэгдсэн Бүгд Найрамдах Турк Улс, Арабын Бүгд Найрамдах Сири Улсад улсын нөөцөөс 10 тонн махан нөөш, 20 гэр, 1500 хөнжил, 2 тонн лаа зэрэг нийт 495 сая төгрөгийн бараа, материалын тусламж үзүүлэхээр шийдвэрлэсэн.

2 дугаар сарын 8-ны өдөр тусламжийн бараа материалаас 3 тонн махан нөөш, 1 тонн лаа, 558 ширхэг хөнжил буюу 4.6 тонн бараа, материалыг Эрэн хайх, аврах багийн ахлагч, бригадын генерал Б.Ууганбаяр Бүгд Найрамдах Турк улсын Гадаад харилцааны яамны тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд Мустафа Юурдакулад, 2 дугаар сарын 9-ний өдөр 2 тонн махан нөөш, 442 ширхэг хөнжил, 10 гэр, нийт 7.1 тонн тусламжийн бараа материалыг Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк улсад суугаа Элчин сайд Г.Мөнхбаяр Турк улсын Гэр бүл, нийгмийн халамж, үйлчилгээний яамны Истанбул дахь төлөөлөгчийн газарт тус тус гардуулан өгсөн.

2 дугаар сарын 13-ны өдөр хүмүүнлэгийн тусламжийн ачааны гурав дахь хэсэг болох 13.7 тн ачааг Истанбул хот дахь Монгол Улсын Ерөнхий консул Ш.Хишигсүрэн Турк улсын Гэр бүл, нийгмийн халамж, үйлчилгээний яамны Истанбул хот дахь төлөөлөгчийн газар, Гадаад харилцааны яамны Истанбул хот дахь төлөөлөгчийн газар, Гамшиг, Онцгой байдлын удирдлагын газарт

хүлээлгэн өгсөн.

2 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсаас хүмүүнлэгийн тусламжаар илгээсэн гэрийг барьж, багийн ахлагч, бригадын генерал Б.Ууганбаяр Бүгд Найрамдах Турк улсын Үндэсний их хурлын гишүүн Хасан Серт, Мурат Демир болон албаны бусад хүмүүст хүлээлгэн өгсөн байна.

Хэвлэл мэдээлэл

Эрэн хайх, аврах багийн бүрэлдэхүүнд хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөлөөс (MYOHPT-ээс сэтгүүлч 1, зураглаач 1, Zarig.mn сайтаас сэтгүүлч 1, зураглаач 1, гэрэл зурагчин 1) нийт 5 ажилтан ажилласан. Үүрэг гүйцэтгэх хугацаанд дүрст мэдээллийг 20 удаа, 41000 орчим фото зургийг авч баримтжуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр олон нийтэд нөхцөл байдлын талаарх мэдээллийг хүргэж, газар хөдлөлтийн гамшигт өртсөн орон нутгийн иргэдээс ярилцлага авч, шуурхай дамжуулж ажилласан. Аврах ажиллагааны багийн ахлагч, бригадын генерал Б.Ууганбаяр болон аврагч нохой-хөтлөгч нар Турк улс дахь АНУ-ын CCTN телевизид ярилцлага өгсөн байна.

5.3.3 Туршлага, сургамж

Гамшиг, Онцгой байдлын байгууллага /AFAD/-ын зүгээс удирдан чиглүүлэх, зохион байгуулалт удаашралтай, тээврийн хэрэгслийн хүрэлцээ хангалтгүй, орон сууц болон гудамжны хаяг байршил тодорхойгүй учир заасан байршилд очих, голомтын бүсээс бааз руу буцахад аврагчдыг тээвэрлэх автомашин олдохгүй, газар хөдлөлтийн гамшгийн эхний өдрүүдэд онцгой байдал, эрүүл мэнд, цагдаа, цэргийн байгууллагын харилцан ажиллагаа доголдолтой, зохицуулалт алдагдсан, эмнэлгийн тоног төхөөрөмж, тусгай зориулалтын багаж хэрэгсэл зэрэг овор хэмжээ ихтэй барааг тээвэрлэх автомашин олдохгүй мөн алба хаагчид хувийн ариун цэвэр сахих зориулалтын ариун цэврийн өрөө байхгүй, Эрэн хайх, аврах багийн бүрэлдэхүүн байрлах талбай олдохгүй шилжин байрлах, алба хаагчдын хоол хүнс хангалтгүй зэрэг хүндрэл гарч байжээ.

Давуу тал

Турк улсын сайн дурын ажилтан эрэн хайх, аврах багийг Гамшиг, Онцгой байдлын байгууллага /AFAD/-тай холбон мэдээлэл солилцож, дэмжлэг үзүүлж ажилласан. Томоохон гамшгийн үед сайн дурын ажилтны үүрэг, оролцоо чухал ач холбогдолтой байв. Сайн дурын 6 ажилтан / Эмине Серин, Тижин Касабова, Бухак, Серкан Дилвер, Сайди болон Айча Андатмад / нар хамтарч үүрэг гүйцэтгэсэн нь аврах ажиллагааг хугацаа алдалгүй зохион байгуулах боломжийг олгосон байна.

Газар хөдлөлтийн гамшгийн голомтод 47 улсын эрэн хайх, аврах багт 388 эрэлч нохой үүрэг гүйцэтгэсэн бөгөөд 10-46 нохойтой 13 улс, 6-9 нохойтой 14 улс, бусад нь 1-4 нохойтой улс байсан. Олон улсын түвшинд үүрэг гүйцэтгэх ажиллагаанд Онцгой байдлын албаны 2 эрэлч нохой авч явсан нь нурангид эрэн хайх ажиллагаанд ихээхэн дэмжлэг үзүүлсэн байна.

Эмнэлгийн бүлгийн үйл ажиллагаанд Туркийн талаас англи хэлтэй 2 эмнэлгийн ажилтан, Турк улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яамны зохицуулалтаар турк хэлтэй монгол иргэн хэлмэрчээр дэмжлэг үзүүлж ажилласан байна.

Цаашид анхаарах асуудал

Бүгд Найрамдах Турк улсад болсон хүчтэй газар хөдлөлтийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд “дунд”, “хүнд” түвшний хот доторх эрэн хайх, аврах багийг илгээх хүсэлтийг тус улсын Засгийн газраас олон улсын байгууллагад тавьсан. НҮБ-ын хот доторх эрэн хайх, аврах зөвлөх багаас гаргасан зөвлөмжөөр хот доторх эрэн хайх, аврах дунд шатны баг нь 42-оос доошгүй алба хаагч, эрэлч нохойтой, 32 цагийн дотор газар хөдлөлт болсон газарт очих боломжтой, 24 цагаар тасралтгүй 7 хоног бие даан ажиллах чадвартай, англи хэлний мэдлэгтэй, олон улсын аврах ажиллагааны тэмдэг тэмдэглэгээг мэддэг, газар хөдлөлтийн гамшгийн үед эрэн хайх, аврах ажиллагаа явуулах дадлага туршлагатай байхыг шаардаж байв.

НҮБ-аас гаргасан зөвлөмжийн дагуу хот доторх эрэн хайх, аврах дунд түвшний багийг бүрдүүлж, томилгоожуулах 5, 10, 20 хүнтэй багийн бүтэц, зохион байгуулалтыг нарийн төлөвлөх, гамшиг тохиолдсон улс орны байгаль цаг агаарын онцлогийг нарийн судалж, алба хаагчдад хувийн бэлтгэлээ хангахад мэдээлэл өгч байх, үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг явахын өмнө болон ирсэний дараа эрүүл мэндийн үзлэгт хамруулах, ачаа барааг ариутгах зэрэг ажлыг түргэн шуурхай зохион байгуулах, үүрэг гүйцэтгэх алба хаагчдын аранзанд байх зүйлсийн жагсаалтыг гаргаж, нэгдсэн байдлаар мэдээлэл өгөх шаардлагууд тавигдсан байна. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Үндэсний аврах бригадын Эрэлч нохойн сургалтын албаны эрэлч нохой болох Марта /4 настай, эм/, Балу /3 настай, эр/ нар нь барилгын нурангид эрэн хайх ажиллагаанд 8 иргэнийг эсэн мэнд олсон.

Бүгд Найрамдах Турк улсын Гамшиг, Онцгой байдлын байгууллага (AFAD)-ын албан тушаалтнууд болон иргэдийн зүгээс Монгол Улсын эрэн хайх, аврах баг үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, шуурхай зохион байгуулж байгааг онцлон, талархал илэрхийлсэн байна.

5.3.4 Туркийн газар хөдлөлтийн үеийн эрэн хайх, аврах ажиллагааны зургийн сан

Зураг 113. БНТУ-ын газар хөдлөлтийн гамшгийн үед Монгол Улсаас эрэн хайх, аврах ажиллагаанд оролцсон аврах баг

ХАВСРАЛТ

УЛСЫН ХЭМЖЭЭНД 2023 ОНД ТОХИОЛДСОН ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН НЭГДСЭН МЭДЭЭ/ өссөн дүнгээр/

№	Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын төрөл		Тохиолдсон тоо	Хамарсан тоо		Нэрвэгдсэн хүн				Хорогдсон, устгасан мал, амьтан	Эвдэрсэн гэр, орон сууц, барилга	Сүйдсэн гэр, орон сууц, барилга	Шатсан талбай /м2/	Учирсан хохирол /сая. төг-өөр/	Зарцуулсан зардал /сая. төг-өөр/	Ажилласан хүч хэрэгсэл		Аварсан	
				аймаг, нийслэл	сум, дүүрэг	Нийт	Нас барсан	Тулгэдсэн, бэртсэн, өвчилсөн, хордсон	Сурагчгүй болсон							Хүн	Техник	Хүн	Эд хөрөнгө /сая.төг/
1	Геологийн гаралтай аюулт үзэгдэл	газар хөдлөлт	86	16	50	4	0	0	0	0	0	0	0	0	0	2	1	0	0
2		гүний болон ул хөрсний гулгалт	1	1	1	0	0	0	0	0	2	0	0	0	0.3	2	1	0	30
		Бусад	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
3	Ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл	хүчтэй салхи, шуурга	75	18	55	511	1	0	0	492518	287	189	0	1,773,400,000	46,017,600	1213	256	496	652,200,000
4		Цасан шуурга	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
5		Шороон шуурга	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
6		Догшин хуй салхи	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
7		Мөндөр	1	1	1	0	0	0	0	15	33	0	0	0	0	0	0	0	0
		Цас, их хэмжээний цас	10	6	10	214	0	0	0	49297	0	0	0	2,510,500,000	14,582,000	237	45	213	57,500,000
		Аянга	9	6	9	12	4	8	0	2	0	4	0	65,000,000	0	10	3	0	0
		Цочир хүйтрэл	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		Үер	107	18	57	3978	15	0	0	3213	1018	99	0	5,741,600,206	214,781,000	5107	803	3974	6,885,400,000
		Ган	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		Зуд	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		БУСАД	7	5	7	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

8	Биологийн гаралтай аюулт үзэгдэл	коронавируст халдвар*	1	22		3322	1	3322	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
9		тарваган тахал	5	4	5	3	1	4	0	0	0	0	0	0	29,300,000	203	71	0	0
10		Боом	4	3	3	0	0	2	0	61	0	0	0	41,000,000	270,000	32	12	0	0
11		Шүлхий	1	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
12		Гахайн мялзан	26	13	27	0	0	0	0	883	0	0	0	129,100,000	99,400,000	303	112	0	0
13		Галзуу	11	6	10	2	0	5	0	24	0	0	0	0	2,765,000	71	15	1	0
		Дуут хавдар	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		Бог малын мялзан	51	8	38	0	0	0	0	4656	0	0	0	352,637,000	97,600,000	717	303	0	0
		Цэцэг	53	8	34	1	0	0	0	1207	0	0	0	17,200,000	30,000,000	424	138	1	0
		Үхрийн арьс товруутах	1	1	1	0	0	0	0	2	0	0	0	3,600,000	0	28	5	0	0
		Хорт салт халуурал	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
14		Цусан халдвар	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
15		Бусад	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
16		Хордлого	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
17	Гал түймэр	объектын гал түймэр	3054	22	226	2161	70	51	0	613	448	639	3300.901	38,449,284,624	219,445,913	20771	6110	1975	375,606,379,068
18		ой, хээрийн гал түймэр	101	15	46	10	0	10	0	7732	9	57	24380706700	1,133,310,000	32,370,000	3865	604	0	20,000,000
19	Хүний үйл ажиллагаатай холбоотой осол	Уул, уурхайн осол	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
20		Тэсэрч дэлбэрэх бодисын осол	5	4	4	4	0	2	0	0	0	0	0	0	12,500	21	4	0	0
21		сум, галт хэрэгслийн осол	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
22		Цацраг идэвхт бодис алдагдах	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
23		Химийн хорт бодис алдагдах	1	1	1	2	0	2	0	0	0	0	0	0	0	3	1	2	0
24		Эрчим хүчний осол	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
25		Зам тээврийн осол	106	20	68	210	84	63	0	0	1	0	0	1,442,200,000	32,305,443	697	149	132	626,500,000
26		Усны осол	73	19	56	83	66	0	1	0	0	0	0	96,000,000	17,762,300	951	221	40	0
27		Төөрсөн, сураггүй болсон	224	22	127	315	37	4	11	0	0	0	0	8,400,000	56,348,750	2951	641	277	0
		Цас, шавар, ус, элсэнд суусан	246	20	99	1089	0	0	0	0	0	0	0	66,500,000	20,480,684	1289	257	1070	1,285,850,000
		Өндрөөс унах осол	39	10	17	49	5	2	0	0	0	0	0	0	1,568,250	364	69	40	0
		Нисдэг тэрэг бүхий ажиллагаа	51	8	16	15	0	1	0	0	0	0	0	0	0	43	17	14	0
		Бусад /ахуйн осол/	128	20	67	409	37	61	0	0	0	2	0	228,080,000	17,609,045	1308	272	357	234,000,000
Бүгд			4485	22	266	12394	321	3537	12	560223	1796	990	24380710001	52,057,811,830	946,133,485	40747	10127	8592	385,372,829,068

УЛААНБААТАР

№	Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын төрөл		Тохиолдсон тоо	Хамарсан тоо		Нэрвэгдсэн хүн				Хорогдсон, устгасан мал, амьтан	Эвдэрсэн гэр, орон сууц, барилга	Сүйдсэн гэр, орон сууц, барилга	Шатсан талбай /га-гаар/	Учирсан хохирол /сая.төг-өөр/	Зарцуулсан зардал /сая.төг-өөр/	Ажилласан хүч хэрэгсэл		Аварсан	
				аймаг, нийслэл	сум, дүүрэг	Нийт	Нас барсан	Түлэгдсэн, бэртсэн, өвчилсөн, хордсон	Сураггүй болсон							Хүн	Техник	Хүн	Эд хөрөнгө /сая.төг/
1	Геологийн гаралтай аюулт үзэгдэл	газар хөдлөлт																	
2		гүний болон ул хөрсний гулгалт																	
		Бусад																	
	Ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл	хүчтэй салхи, шуурга																	
		Цасан шуурга																	
		Шороон шуурга																	
		Догшин хуй салхи																	
		Мөндөр																	
		Цас, их хэмжээний цас																	
		Аянга																	
		Цочир хүйтрэл																	
		Үер	33	1	12	941	4				835	16		3,218,600,206	72,050,000	3156	437	937	1,835,400,000
		Ган																	
		Зуд																	
		Бусад																	
3	Гал түймэр	объектын гал түймэр	1563	2	9	1894	42	22			170	67	34.7	4,932,573,900	126,987,125	11852	3453	1837	284,863,900,000
4		ой, хээрийн гал түймэр																	
	Хүний үйл ажиллагаатай холбоотой осол	Уул, уурхайн осол																	
5		Тэсэрч дэлбэрэх бодисын осол	1	1	1														
6		сум, галт хэрэгслийн осол																	
7		Цацраг идэвхт бодис алдагдах																	
8		Химийн хорт бодис алдагдах																	
9		Эрчим хүчний осол																	
10		Зам тээврийн осол	16	8	13	53	8	12						128,000,000	1,082,663	58	15	31	
11		Усны осол	14	4	10	22	11							10,000,000	4,275,300	298	54	12	
12		Төөрсөн, сураггүй болсон	15	6	8	44	6		4						1,200,000	81	15	40	
13		Цас, шавар, ус, элсэнд суусан	37	17	32	501									3,500,000	412	78	491	
14		Өндрөөс унах осол	23	7	16	31	4								648,250	218	37	26	
15		Нисдэг тэрэг бүхий ажиллагаа																	
16		Бусад /ахуйн осол/	68	24	72	260	23	17						37,700,000	12,215,347	789	162	221	
Бүгд			**1772**	73	184	**7033**	**99**	**3338**	**4**	**0**	**1005**	**83**	**34.7**	**8,326,874,106**	**235,458,685**	**16876**	**4255**	**3595**	**286,699,300,000**

АРХАНГАЙ АЙМАГ

д/д	Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын төрөл		Тохиолдлын тоо	Хамарсан тоо		Нэрвэгдсэн хүн				Хорогдсон, устгасан мал, амьтан	Эвдэрсэн гэр, орон сууц, барилга	Сүйдсэн гэр, орон сууц, барилга	Шатсан талбай /м2/	Учирсан хохирол /тег-өөр/	Зардуулсан зардал /тег-өөр/	Ажилласан хүч хэрэгсэл			Аварсан
				аймаг, нийслэл	сум, дүүрэг	Нийт	Нас барсан	Түлэгдсэн, бэртсэн, өвчлөсөн	Сураггүй болсон							Хүн	Техник	Хүн	Эд хөрөнгө /тег/
1	Геологийн гаралтай аюулт үзэгдэл	газар хөдлөлт	3	1	3														
2		гүний болон ул хөрсний гулгалт																	
3		Бусад																	
4	Ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл	хүчтэй салхи, шуурга	11	1	9					22	10			215,500,000	505,000	57	18		20,000,000
5		Цасан шуурга																	
6		Шороон шуурга																	
7		Догшин хүй салхи																	
8		Мөндөр																	
9		Цас, их хэмжээний цас																	
10		Аянга	1	1	1	4	2	2								3	1		
11		Цочир хүйтрэл																	
12		Үер	1	1	1					10	31	1		405,600,000	2,500,000	57	9		220,000,000
13		Ган																	
14		Зуд																	
15		Бусад	1	1	3														
16	Биологийн гаралтай аюулт үзэгдэл	коронавируст халдвар*																	
17		тарваган тахал																	
18		Боом																	
19		Шулхий																	
20		Гахайн мялзан																	
21		Галзуу																	
22		Дуут хавдар																	
23		Бог малын мялзан	5	1	5					1343				24,000,000	3,000,000	93	49		
24		Цэцэг																	
25		Үхрийн арьс товруутах																	
26		Хорт салт халуурал																	
27		Цусан халдвар																	
28		Бусад																	
29		Хордлого																	
30	Гал түймэр	объектын гал түймэр	44	1	26		3	1			16	14		1,137,000,000	3,000,000	305	89		3,745,000,000
31		ой, хээрийн гал түймэр	2	1	1								70000	500,000	500,000	12	2		
32	Хүний үйл ажиллагаатай холбоотой осол	Уул, уурхайн осол																	
33		Тэсэрч дэлбэрэх бодисын осол																	
34		сум, галт хэрэгслийн осол																	
35		Цацраг идэвхт бодис алдагдах																	
36		Химийн хорт бодис алдагдах																	
37		Эрчим хүчний осол																	
38		Зам тээврийн осол	2	1	2	3	3							15,000,000	100,000	10	2		
39		Усны осол	2	1	2	3	3								600,000	25	6		
40		Төөрсөн, сураггүй болсон	9	1	7	13	1	3							700,000	66	11	10	
41		Цас, шавар, ус, элсэнд суусан	6	1	6	7									100,000	24	5	7	
42		Өндрөөс унах осол	1	1	1	2									20,000	5	1	1	
43		Нисдэг тэрэг бүхий ажиллагаа	3	1	2	1		1											
44		Бусад /ахуйн осол/	3	1	4	3	1	1						28,000,000		15	3	3	
Бүгд			**94**	**15**	**73**	**36**	**13**	**8**	**0**	**1375**	**57**	**15**	**70000**	**1,825,600,000**	**11,025,000**	**672**	**196**	**21**	**3,985,000,000**

БАЯНХОНГОР АЙМАГ

д/д	Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын төрөл		Тохиолдлын тоо	Хамарсан тоо		Нэрвэгдсэн хүн				Хорогдсон, устгасан мал, амьтан	Эвдэрсэн гэр, орон сууц, барилга	Сүйдсэн гэр, орон сууц, барилга	Шатсан талбай /м2/	Учирсан хохирол /төг-өөр/	Зардуулсан зардал /төг-өөр/	Ажилласан хүч хэрэгсэл			Аварсан
				аймаг, нийслэл	сум, дүүрэг	Нийт	Нас барсан	Түлэгдсэн, бэртсэн, өвчилсөн, хордсон	Сураг үгүй болсон							Хүн	Техник	Хүн	Эд хөрөнгө /төг/
1	Геологийн гаралтай аюулт үзэгдэл	газар хөдлөлт	3	2	2														
2		гүний болон ул хөрсний гулгалт																	
3		Бусад																	
4	Ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл	хүчтэй салхи, шуурга	7	2	5	2					6			7,500,000		33	10	2	40,000,000
5		Цасан шуурга																	
6		Шороон шуурга																	
7		Догшин хүй салхи																	
8		Мөндөр																	
9		Цас, их хэмжээний цас																	
10		Аянга	1		1														
11		Цочир хүйтрэл																	
12		Үер	3		1	10	4								3,000,000	24	5	10	13,000,000
13		Ган																	
14		Зуд																	
15		Бусад																	
16	Биологийн гаралтай аюулт үзэгдэл	коронавируст халдвар*																	
17		тарваган тахал																	
18		Боом	1	1	1			2		2				2,000,000	50,000	6	2		
19		Шүлхий																	
20		Гахайн мялзан																	
21		Галзуу	1	1	1	1		1		4					100,000	5	2	1	
22		Дуут хавдар																	
23		Бог малын мялзан																	
24		Цэцэг																	
25		Үхрийн арьс товруутах																	
26		Хорт салт халуурал																	
27		Цусан халдвар																	
28		Бусад																	
29		Хордлого																	
30	Гал түймэр	объектын гал түймэр	43	17	25	34	1	1			10	15	194	525,000,000	1,980,000	154	57	33	3,700,000,000
31		ой, хээрийн гал түймэр	1	1	1								140000000	3,000,000	500,000	34	4		
32	Хүний үйл ажиллагаатай холбоотой осол	Уул, уурхайн осол																	
33		Тэсэрч дэлбэрэх бодисын осол																	
34		сум, галт хэрэгслийн осол																	
35		Цацраг идэвхт бодис алдагдах																	
36		Химийн хорт бодис алдагдах																	
37		Эрчим хүчний осол																	
38		Зам тээврийн осол	3	2	3	17	2	1						3,000,000	270,000	50	8	15	80,000,000
39		Усны осол																	
40		Төөрсөн, сураг үгүй болсон	9	5	7	13	2							200,000	600,000	104	26	11	
41		Цас, шавар, ус, элсэнд суусан																	
42		Өндөөс унах осол																	
43		Нисдэг тэрэг бүхий ажиллагаа	7																
44		Бусад /ахуйн осол/	2	1	2	16		1						20,200,000	100,000	19	3	16	140,000,000
Бүгд			**81**	**32**	**49**	**93**	**9**	**6**	**0**	**6**	**16**	**15**	**140000194**	**560,900,000**	**6,600,000**	**429**	**117**	**88**	**3,973,000,000**

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ

д/д	Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын төрөл		Тохиолдлын тоо	Хамарсан тоо		Нэрвэгдсэн хүн				Хорогдсон, устгасан мал, амьтан	Эвдэрсэн гэр, орон сууц барилга	Сүйдсэн гэр, орон сууц барилга	Шатсан талбай /м2/	Учирсан хохирол /төг-өөр/	Зарцуулсан зардал /төг-өөр/	Ажилласан хүч хэрэгсэл			Аварсан
				аймаг, нийслэл	сум, дүүрэг	Нийт	Нас барсан	Тулгдсан, бэртсэн, өвчилсөн, хордсон	Сураггүй болсон							Хүн	Техник	Хүн	Эд хөрөнгө /төг/
1	Геологийн гаралтай аюулт үзэгдэл	газар хөдлөлт	1		1	2													
2		гүний болон ул хөрсний гулгалт	1		1														
3		Бусад																	
4	Ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл	хүчтэй салхи, шуурга	1	1	5						11			17,700,000		8	2		30,000,000
5		Цасан шуурга																	
6		Шороон шуурга																	
7		Догшин хуй салхи																	
8		Мөндөр																	
9		Цас, их хэмжээний цас	2	1	2										1,500,000	12	2		2,000,000
10		Аянга																	
11		Цочир хүйтрэл																	
12		Үер	3	2	4	101				120	3			1,086,000,000	30,000,000	469	62	101	800,000,000
13		Ган																	
14		Зуд																	
15		Бусад																	
16	Биологийн гаралтай аюулт үзэгдэл	коронавируст халдвар*																	
17		тарваган тахал																	
18		Боом																	
19		Шүлхий	1	1	1														
20		Гахайн мялзан																	
21		Галзуу																	
22		Дуут хавдар																	
23		Бог малын мялзан	1	1	1					15					1,000,000	2	2		
24		Цэцэг																	
25		Үхрийн арьс товруутах																	
26		Хорт салт халуурал																	
27		Цусан халдвар																	
28		Бусад																	
29		Хордлого																	
30	Гал түймэр	объектын гал түймэр	32	14	12	31					5	16		134,500,000	3,970,400	167	47	22	3,676,800,000
31		ой, хээрийн гал түймэр	1	1	1								50000		570,000	52	4		
32	Хүний үйл ажиллагаатай холбоотой осол	Уул, уурхайн осол																	
33		Тэсэрч дэлбэрэх бодисын осол																	
34		сум, галт хэрэгслийн осол																	
35		Цацраг идэвхт бодис алдагдах																	
36		Химийн хорт бодис алдагдах																	
37		Эрчим хүчний осол																	
38		Зам тээврийн осол	1	1	2	5	3				1			48,500,000	50,000	28	5	2	2,000,000
39		Усны осол	7	5	5	9	7							12,000,000	1,516,000	92	16	2	
40		Төөрсөн, сураггүй болсон	7	5	6	13	2								695,000	46	7	12	
41		Цас, шавар, ус, элсэнд суусан	5	4	5	223									4,770,000	25	5	221	1,000,000,000
42		Өндөөс унах осол																	
43		Нисдэг тэрэг бүхий ажиллагаа																	
44		Бусад /ахуйн осол/	3	4	3	17		3						10,000,000	1,327,000	39	6	16	40,000,000
Бүгд			**66**	**40**	**49**	**401**	**12**	**3**	**0**	**135**	**20**	**16**	**50000**	**1,308,700,000**	**45,398,400**	**940**	**158**	**376**	**5,550,800,000**

БУЛГАН АЙМАГ

д/д	Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын төрөл		Тохиолдлын тоо	Хамарсан тоо		Нэрвэгдсэн хүн				Хорогдсон, устгасан мал, амьтан	Эвдэрсэн гэр, орон сууц, барилга	Сүйдсэн гэр, орон сууц, барилга	Шатсан талбай /м2/	Учирсан хохирол /төг-өөр/	Зарцуулсан зардал /төг-өөр/	Ажилласан хүч хэрэгсэл			Аварсан
				аймаг, нийслэл	сум, дүүрэг	Нийт	Нас барсан	Тулгдсан, бэртсэн, өвчилсөн,	Сураггүй болсон							Хүн	Техник	Хүн	Эд хөрөнгө /төг/
1	Геологийн гаралтай аюулт үзэгдэл	газар хөдлөлт	1	1	1														
2		гүний болон ул хөрсний гулгалт																	
3		Бусад																	
4	Ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл	хүчтэй салхи, шуурга	2	1	2						25			373,700,000	500,000	157	39		30,000,000
5		Цасан шуурга																	
6		Шороон шуурга																	
7		Догшин хүй салхи																	
8		Мөндөр																	
9		Цас, их хэмжээний цас																	
10		Аянга	1	1	1							1		57,000,000		5	1		
11		Цочир хүйтрэл																	
12		Үер	1	1	1										1,000,000	12	3		50,000,000
13		Ган																	
14		Зуд																	
15		Бусад																	
16	Биологийн гаралтай аюулт үзэгдэл	коронавирус халдвар*																	
17		тарваган тахал																	
18		Боом																	
19		Шулхий																	
20		Гахайн мялзан	1	1	1					265				79,500,000	1,000,000	24	8		
21		Галзуу																	
22		Дуут хавдар																	
23		Бог малын мялзан	22	1	16					965				90,900,000	30,000,000	46	15		
24		Цэцэг																	
25		Үхрийн арьс товруутах	1	1	1					2				3,600,000		28	5		
26		Хорт салт халуурал																	
27		Цусан халдвар																	
28		Бусад																	
29		Хордлого																	
30	Гал түймэр	объектын гал түймэр	49	1	35	5	1	4			27	12		215,900,000	3,100,000	345	78	1	577,500,000
31		ой, хээрийн гал түймэр	2	1	2							1	32540000		3,300,000	172	17		20,000,000
32	Хүний үйл ажиллагаатай холбоотой осол	Уул, уурхайн осол																	
33		Тэсэрч дэлбэрэх бодисын осол																	
34		сум, галт хэрэгслийн осол																	
35		Цацраг идэвхт бодис алдагдах																	
36		Химийн хорт бодис алдагдах																	
